



1924-2024

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН  
ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот  
2024 он

## **МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ, АРГА ХЭРЭГСЭЛ**

Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулах нь иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк инфляцыг дунд хугацаанд зорилтот интервалд тогтворжуулахыг зорьж байна. Монголбанк бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Макро зохистой бодлогын хүрээнд банкны системийн хэмжээнд мөрдүүлэх зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратеги баримталж байна. Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгдөг. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад сектор, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилттой нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц, түүний ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлнө. Бодлогын хэрэгслийн өөрчлөлт нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкнуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Бодлогын хүүний коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.



# ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ.....	5
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	8
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2024 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 99 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ .....	45
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2024 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ .....	47
ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА .....	73
I. ИНФЛЯЦ .....	73
II. БОДИТ СЕКТОР .....	74
2.1. Нийт нийлүүлэлт .....	74
2.2. Нийт эрэлт .....	75
III. УЛСЫН ТӨСӨВ.....	76
IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ .....	77
4.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв .....	77
4.2. Инфляцын төлөв .....	78
4.3. Төсвийн бодлогын төлөв.....	80
4.4. Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлөв .....	81
4.5. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв .....	87
4.6. Инфляцын гол эрсдэлүүдэд суурилсан хувилбар төсөөлөл.....	88
V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	91
5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	91
5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр .....	93
5.3. Мөнгөний зах, хүүний түвшин.....	94
5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш.....	96

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗЭЭЛ.....	98
6.1.Төлбөрийн тэнцэл.....	98
6.2.Хөрөнгө оруулалтын позиц .....	101
6.3 Монгол Улсын гадаад өр .....	102
VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	104
7.1.Санхүүгийн салбар .....	104
7.2.Банк бус санхүүгийн салбар.....	105
7.3.Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв.....	109
7.4.Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүд.....	114
СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД.....	116

### **Шигтгээний жагсаалт**

Шигтгээ 1. Инфляцыг хэмжих нь .....	13
Шигтгээ 2. Банкнуудын ногоон зээл .....	28
Шигтгээ 3. Хадгаламжийн сертификат.....	37
Шигтгээ 4. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээ .....	84

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,  
Улаанбаатар хот

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН  
ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ  
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

**Цар тахлаас эхлэн геополитикийн хурцадмал байдлаар даамжирсан эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван туулж, санхүүгийн зах зээл, эдийн засаг сэргээд байна. Энэхүү сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

### **1. Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:**

1.1. Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын зорилтыг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.3. Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

### **2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:**

2.1. Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлнэ.

2.2. Банкнуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлнэ.

2.3. Банкны салбарын тогтвортой, ногоон санхүүжилтийн мэдээлэл цуглуулах тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, стресс тестийн арга зүйг хөгжүүлнэ.

2.4. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэж, шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ.

### **3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1. Төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг дэмжиж, цаг үедээ нийцсэн хяналт зохицуулалтын уялдааг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

3.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх суурь нөхцөлийг бүрдүүлэн дотоодын мөнгөний захыг хөгжүүлнэ.

3.3. Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлж, төв банкны бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллана.

3.4. Жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлнэ.

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*Цар тахлаас эхлэн геополитикийн хурцадмал байдлаар даамжирсан эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван туулж, санхүүгийн зах зээл, эдийн засаг сэргээд байна. Энэхүү сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.*

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 2 жилийн хугацаанд хурдацтай сэргэж байна. БНХАУ-ын нүүрсний худалдан авалт өсөж, манай нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдлээ. Гадаад валютын орох урсгал сайжран дотоод эдийн засгийн идэвхжил эрчимжиж, энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг 5.6 хувиар өслөө. Цалин, тэтгэвэр зэрэг өрхийн орлогын өсөлтийг даган хувийн хэрэглээ сүүлийн 5 улирал дараалан 10 хувийг давж өссөний зэрэгцээ төрийн байгууллагын хэрэглээ эрчимжсэн нь эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ. Өнгөрсөн өвөл цаг агаарын нөхцөл хүндэрснээс хөдөө аж ахуйн салбар энэ оны эхний хагаст 27 орчим хувиар агшлаа. Харин уул уурхай, хөдөө аж ахуйгаас бусад салбаруудын үйлдвэрлэл оны эхний хагас жилд 10.3 хувиар өслөө.

Сүүлийн жилүүдэд тохиосон дараалсан хүндрэлүүдийг амжилттай даван туулж, эдийн засаг сэргээд байгаа ч гадаад эдийн засгийн орчинд тодорхой бус байдал өндөр, суурь эрсдэлүүд үргэлжилсэн хэвээр байна. Геополитикийн тогтворгүй байдал үргэлжилж, манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт сул, үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл үргэлжилж байгаа нь глобал эдийн засгийн өсөлт төдийгүй, эрдэс бүтээгдэхүүний үнэд сөргөөр нөлөөлж эхлээд байна. Ирэх онд нүүрсний экспортын үнэ буурах, төсвийн тэлэлтээр дамжин импортын эрэлт, валютын төлбөртэй үйлчилгээний зардал өсөх, худалдааны түнш орнуудын нөхцөл байдал зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцэл сайжрахааргүй байна. Иймээс эдийн засгийн сэргэлтийг цаашид тогтворжуулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

Тогтвортой, бага инфляц нь иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засагт тодорхой бус байдлыг бууруулан дунд хугацааны тогтвортой өсөлтийг бүрдүүлэх суурь нөхцөл болдог. Монголбанк ирэх хоёр жилд инфляцыг 6 +/- 2 хувийн интервалд тогтворжуулах, 2027 оноос эхлэн зорилтын голчийг 5 хувь болгон бууруулахад мөнгөний бодлогын үйл ажиллагааг чиглүүлэхээр тусгалаа. Эдийн засаг, санхүүгийн зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах замаар инфляцын зорилтыг дунд хугацаанд бууруулж, цаашлаад нам, тогтвортой инфляцын орчинг бүрдүүлснээр иргэд, өрх гэрийн худалдан авах чадварыг дээшлүүлэх, бодит орлогыг хамгаалах, тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх юм. Өнгөрсөн хугацаанд инфляцыг бууруулж, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого үр дүнгээ өгч, инфляц сүүлийн 5 сарын турш зорилтын голчийн орчимд тогтвортой хадгалагдлаа. Гэвч дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаатай зэрэгцээд мөчлөг дагасан төсвийн хэт тэлсэн бодлого хэрэгжүүлэх нь импортыг өсгөж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид ирэх дарамтыг нэмэгдүүлж, цаашлаад инфляц эрчимжих эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.



Жижиг, нээлттэй, гадаад эдийн засгийн орчноос өндөр хамааралтай эдийн засгийн хувьд төгрөгийн ханш макро суурь нөхцөлтэй нийцтэй тогтож, эдийн засагт шок шингээгчийн үүргээ гүйцэтгэснээр аливаа цочролын үед хурдан тохиргоо хийгдэх боломжийг олгохын зэрэгцээ экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг дэмжих юм. Иймээс Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй, уян хатан тогтох зарчмыг тууштай баримталж, валютын захад ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор оролцох арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгалаа.

Монголбанк сүүлийн хоёр жилд гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрэх боломжийг нээж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай бодлого, зохицуулалтын механизмыг бий болгоход анхаарч ажиллалаа. Энэ хүрээнд гадаадын банк нь Монгол Улсад охин компани үүсгэн байгуулах, салбар болон төлөөлөгчийн газар нээх хэлбэрүүдээр нэвтрэх боломжтой болов. Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, санхүүгийн дэд бүтэц, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлд ажиллана. Түүнчлэн, банкнуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий улс орнуудын нэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, дасан зохицох чадавхаа нэмэгдүүлэхэд анхаарах нь улам бүр чухал болж байна. Уур амьсгалын эдийн засаг, санхүүгийн секторт үзүүлэх нөлөөг тооцох, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, улмаар бодлогын хариу арга хэмжээ авахын тулд нэн түрүүнд нарийвчилсан тоон мэдээллийг цуглуулах шаардлагатай байна. Иймээс Монголбанк дээр хөгжүүлж буй их өгөгдлийн суурь дэд бүтцийг ашиглан банкнуудаас ногоон, тогтвортой санхүүжилтийн зээл, түүнтэй холбоотой тоон мэдээллийг цуглуулж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг үүсгэх, ногоон зээлийн үр дүнг хэмжих тогтолцоог хөгжүүлэх ажлыг ирэх онд үргэлжлүүлнэ. Мөн банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн шинжилгээний аргачлалыг боловсруулан, туршилтын тооцоог хийж эхлэхээр төлөвлөж байна. Ингэснээр банк, санхүүгийн салбарт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үүнд банк, санхүүгийн салбарыг бэлтгэх, цаашлаад макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх юм.

Дэлхий нийтэд техник, технологи хурдацтай хөгжихийн хэрээр төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн үйлчилгээг технологийн дэвшилтэй уялдуулах, цаг үедээ нийцсэн байдлаар хяналт зохицуулалтын орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох шаардлага улам бүр нэмэгдэж байна. Ирэх онд холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, зохицуулалтын орчны уялдаа холбоо, давхардлыг арилган шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжих, зээлийн мэдээллийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалахад мөнгөний зах зээлийн хөгжил чухал үүрэгтэй. Энэ хүрээнд Монголбанк олон улсын мөнгөний захын үйл ажиллагааны жишгийн дагуу мөнгөний захын дэд бүтцийг сайжруулах, арилжаалж буй үнэт цаасны төрөл, хугацаа болон оролцогчдын тоог нэмэгдүүлэх, цаашлаад мөнгөний захын үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана. Төв банк нь өөрийн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх, олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана. Ирэх оны хувьд жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг нэвтрүүлэх чиглэлээр бодлого, зохицуулалтын өөрчлөлтүүдийг хийх бөгөөд энэ хүрээнд олон улсын байгууллагууд болон бусад бодлого боловсруулагчидтай хамтран ажиллана.

Цаашид макро эдийн засагт гарч буй эдгээр эерэг үр дүнг бэхжүүлэхийн зэрэгцээ үүсэж болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, эдийн засаг болон санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаа нь эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцлийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

**1. МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:****ЗОРИЛТ 1.1**

Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын зорилтыг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

**Үндэслэл**


Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд зааснаар мөнгөний бодлогын үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд үүнийг төгрөгийн худалдан авах чадварыг хангах гэж тодорхойлдог. Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн хэлбэлзлийг бууруулж, инфляцыг урьдчилан тодорхойлсон зорилтот интервалын орчимд тогтворжуулах нь зах зээлийн тодорхой бус байдлыг бууруулан иргэд, бизнес эрхлэгчид хэрэглээ, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тусалж, улмаар дунд, урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Тогтвортой, нам түвшний инфляц нь иргэдийн бодит орлого, худалдан авах чадвар, өрхийн амьжиргааг хамгаалах ач холбогдолтой.

*Зураг 1. Инфляц, түүний зорилт*

Эх сурвалж: Монголбанк

Манай улсын инфляц хавсарсан шокуудын нөлөөгөөр 2022 оны дунд үе хүртэл эрчтэй нэмэгдэж 16.9 хувьд хүрээд байв. Гадаад, дотоод тэнцвэр алдагдаж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол хүчтэй нөлөөлсөн үед Монголбанк инфляцыг зорилтын түвшинд хүргэж бууруулах, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах бодлогыг баримтлан ажилласан. Худалдааны түнш орнуудын үнэ 2023 оноос тогтворжиж, экспорт эрчимжсэний зэрэгцээ мөнгөний бодлогын төлөв чанга түвшинд хадгалагдсанаар инфляц 2024 оны 7 дугаар сард 5.5 хувьд хүрч буурлаа.

Зураг 2. Инфляц, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: YCX, Монголбанк

Инфляц 2025 онд зорилтот түвшинд хадгалагдахад дараах хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэхээр байна. Үүнд:

1. Худалдааны түнш орнуудын эдийн засаг тогтвортой байж, худалдааны эргэлтэд доголдол үүсэхгүй байх,
2. Улирлын шинжтэй үнэ нь өсдөг дотоодын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж, үнийн хэлбэлзлийг бууруулах,
3. Төсвийн зардал огцом нэмэгдэж, инфляцад үзүүлэх эрэлтийн дарамтыг нэмж өдөөхгүй байх.

Эдийн засгийн идэвхжил өндөр байгаагийн зэрэгцээ төсвийн зардал эрчтэй нэмэгдсэн нь импорт, валютын төлбөртэй үйлчилгээ өсөхөд нөлөөлж, цаашид төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамтыг үүсгэж байна. Үүний дээр худалдааны тээврийн саатал бүрэн арилаагүй, Тяньжин боомтод түгжрэл үүссэн хэвээр байгаа нь тээврийн зардал өсөх, цаашлаад импортын үнэ өсөх нөхцөл болж байна.

## ШИГТГЭЭ 1. Инфляцыг хэмжих нь

Инфляц нь бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшинд гарч буй өөрчлөлтийг хэмжих үзүүлэлт юм. Төв банкнууд мөнгөний бодлого хэрэгжүүлэхдээ өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний чанар, төрөлд гарч буй сайжруулалт, хэрэглэгчийн зан төлөвийн өөрчлөлтийг тусгах чадвартай үнийн индекс ашиглахыг эрмэлздэг. Гэвч амьдрал дээр үүнийг тооцоолоход олон бэрхшээл тулгардаг бөгөөд дэлхийн ихэнх орны төв банкнууд инфляцыг хэмжих үндсэн үзүүлэлтээр хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийг сонгож байна. Өргөн ашиглагддаг хэдий ч, ХҮИ нь төгс үзүүлэлт биш юм. Энэ нь бүтээгдэхүүний чанарын өөрчлөлт болон технологийн хурдацтай дэвшлийг төдийлөн тусгаж чаддаггүй зэрэг дутагдалтай. Гэхдээ эдгээр дутагдалтай тал, шинэ сорилтуудын дунд ХҮИ нь агуулга, практикийн хувьд инфляцыг хэмжих боломжит үзүүлэлт хэвээр байна.

ХҮИ нь өрхийн худалдан авсан бараа, үйлчилгээний тогтмол сагсны дундаж үнийн түвшний өөрчлөлтийг тооцдог хэмжүүр юм. Энэхүү тогтмол сагсны аргачлал нь ХҮИ-ийг хэд хэдэн сул талтай байхад хүргэдэг. Үүнд:

- ХҮИ нь бараа үйлчилгээний орлуулах хандлагыг тооцохгүй. Барааны үнэ өсөхөд хэрэглэгчид хямд үнэтэй хувилбар руу шилжиж болно. Жишээ нь, үхрийн махны үнэ өсөх үед хэрэглэгчид тахианы махыг илүү их хэмжээгээр худалдан авч болно. Тогтмол сагс дээр суурилсан ХҮИ нь хэрэглэгчийн энэ зан төлөвийг мэдэрдэггүй. Үнэ нь өөрчлөгдсөн хэдий ч, хэрэглэгчид ижил бараа, үйлчилгээг ижил тоо хэмжээгээр худалдан авсаар байна гэж үздэг. Энэ нь бодит байдлаас зөрүүтэй үр дүнд хүргэж, инфляцын түвшинг өндөр гаргаж болзошгүй байдаг.
- ХҮИ нь чанарын өөрчлөлтийг тусгаж чадахгүй. Сагсанд байгаа бараа, үйлчилгээний чанар цаг хугацааны явцад сайжирч байвал инфляцаас шалтгаалж биш, харин тухайн бараа, үйлчилгээ илүү чанартай болсон учраас үнэ нь өсөж болно. Энэ нь ХҮИ инфляцын түвшинг хэт өндөр үнэлэхэд хүргэж болзошгүй. Тухайлбал, өнөөгийн ухаалаг гар утасны үнийг хэдэн жилийн өмнөх энгийн утастай харьцуулахтай адил зүйлд хүргэдэг. Энэ хоёр нь техникийн хувьд ижил төрлийн бүтээгдэхүүн боловч, ухаалаг утас нь илүү олон боломж, давуу талуудыг санал болгодог.

Хэрэглээний сагсыг төлөөлөх чадвараа алдахаас сэргийлж олон улсын жишгээр суурь үе, сагсны, бүрдэл жинг 5 жил тутамд 1 удаа шинэчилдэг.<sup>1</sup> Гэвч технологийн тасралтгүй хөгжлийн улмаас эдийн засаг, нийгмийн хөгжил, иргэдийн хэрэглээний хандлага өмнөх үетэй харьцуулахад хурдацтай хувьсдаг. Энэ нь нэг талаас үнийн өөрчлөлтийг хэмжих асуудлыг улам нарийн төвөгтэй болгож байна. Үүнээс шалтгаалан ХҮИ нь тодорхой хугацааны туршид амьжиргааны өртгийн бодит дүр зургийг бүрэн гаргаж чадахгүй байж магадгүй юм.

Эдгээр ХҮИ-ийн сул талуудыг харгалзан зарим улс оронд инфляцыг тооцох өөр үнийн индексийг давхар ашигладаг. Тухайлбал, АНУ-ын Холбооны нөөцийн банк нь ХҮИ-ээр тооцдог инфляцаас гадна хувийн хэрэглээний зарцуулалт (Personal Consumption Expenditures)-аас тооцсон инфляцыг зарлаж, бодлогын зорилтын хэрэгжилтийг үүгээр дэмждэг байна. ХХЗ-ын индекс нь үнэ өөрчлөгдөхөд бараа, бүтээгдэхүүний хооронд орлуулах боломжийг тооцоололдоо ашигладаг. Энэ нь уг үзүүлэлтийг ХҮИ-ээс илүү уян хатан болгодог.


<sup>1</sup> Үндэсний статистикийн хороо (2022). Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал, *Хэрэглээний бараа үйлчилгээний сагс, жин, аргачлал, маягтыг батлах тухай*

ХХЗ үнийн индексийн онцлог нь илүү өргөн хүрээг хамарсан олон тооны бараа, үйлчилгээг багтаадаг бөгөөд өрхийн хэрэглээний бүхий л бараа, үйлчилгээг агуулна. Гэхдээ ХХЗ үнийн индекс нь мөн л сул талтай юм. Энэ нь бизнес эрхлэгчдээс цуглуулсан мэдээлэлд үндэслэдэг тул хэрэглэгчдийн судалгаанаас гардаг ХҮИ-ээс бага нарийвчлалтай байх эрсдэлтэй.

Эцэст нь, ХҮИ нь олон улсад инфляцыг хэмжих хамгийн үр дүнтэй хэрэгсэл хэвээр байна. ХҮИ болон ХХЗ үнийн индекс хоёулаа үнийн өөрчлөлтийн талаар үнэ цэнтэй мэдээлэл өгдөг бөгөөд зарим орнууд харьцуулсан байдлаар ашиглаж байна. Технологийн дэвшил тасралтгүй явагдсаар байгаа өөрчлөгдөж байгаа орчинд нөхцөл байдлыг үнэн зөв тусгахын тулд шинэ арга, аргачлалыг ашиглах шаардлага ч үүсэж байна.

Монгол Улс 5 жил тутамд ХҮИ-ийн сагсаа шинэчилдэг бөгөөд хамгийн сүүлд 2020 оны суурь үнээр шинэчлээд байна. Хэрэглээний сагсны ерөнхий бүтцийн өөрчлөлтөөс харахад иргэдийн орлого нэмэгдэж буйтай зэрэгцэн хүнсний хэрэглээний жин буурч хүнсний бус хэрэглээний жин нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2005 оны суурьтай ХҮИ-ийн сагсны 41 хувийг хүнсний бүлэг бүрдүүлж байсан бол 2020 оны суурьтай сагсны хүнсний бүлгийн жин 24 хувь болж буурчээ. Улс орны орлого нэмэгдэхийн хэрээр хүнсний бүтээгдэхүүнд зарцуулсан зардлын эзлэх хувь ийнхүү буурах хандлага нийтлэг ажиглагддаг. Өндөр орлоготой орнуудын хувьд хэрэглээний сагсны хүнсний бүлгийн жин 10 хувь эсвэл түүнээс бага байх нь түгээмэл байдаг.<sup>2</sup> Харин ХХЗ индексийн хувьд манай улсад хараахан тооцож эхлээгүй байгаа тул өрхийн хэрэглээний үнийн өсөлтийг хэмжих алтернатив индекс одоогоор байхгүй байна.

Зураг 3. Сагсан дах бүтээгдэхүүний тоо, жилийн өсөлтийн хувиар



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Мөнгөний бодлого нь эдийн засаг дахь эрэлтийн хүчин зүйлсэд, улмаар инфляцад нөлөөлдөг. Харин нийлүүлэлтийн эсвэл зардлын шинжтэй инфляцад төсвийн бодлого үр дүнтэй. Гэхдээ мөнгөний бодлогоор эдгээрийн дам нөлөөг багасгах, хүлээлтээр дамжин үнийн өсөлт цаашид даамжрах эрсдэлээс сэргийлэх шаардлага үүсдэг. Дэлхий нийтээр инфляцын хүлээлт тогтворжиж, буурах хандлагатай байгаа хэдий ч олон оронд зорилтот

<sup>2</sup> Энгелийн хууль: Баян хүмүүс хоол хүнсэндээ илүү их мөнгө зарцуулдаг хэдий ч орлогод нь бага хувийг эзэлдэг.

түвшнээс өндөр хэвээр байна. Энэ нь гадаад хүү богино хугацаандаа өндөр хэвээр байхад нөлөөлсөөр байна.

Мөнгөний бодлогын нөлөө тодорхой хугацааны дараа бодит эдийн засагт илрэх тул инфляцын зорилтыг дунд хугацааны зорилт болгон тодорхойллоо. Дунд хугацааны инфляцын зорилтыг хангах бодлого хэрэгжүүлснээр түр зуурын шинжтэй шоконд хариу арга хэмжээ авах буюу хэт хатуу эсвэл зөөлөн бодлого явуулахаас сэргийлэх болно. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт, бусад бодлогын зорилтыг харгалзан, хүлээлтээр дамжин үнийн хэлбэлзлийг нам түвшинд тогтворжуулах боломж олгох давуу талтай.<sup>3</sup> Иймд Монголбанк дунд хугацааны үнийн тогтвортой байдлын зорилтод чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

Хөгжиж буй орнууд эдийн засгийн бүтцийн онцлогоос шалтгаалан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд өндөр хэлбэлзэлтэй байдаг. Иймд эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлого инфляцын зорилтыг цэгэн голчтой, интервалаар тогтоох нь илүү үр дүнтэй. Энэ нь хүлээлтийг удирдах, дотоод эдийн засгийн шокуудад хариу үйлдэл үзүүлэх бодлогын орон зайг нэмэгдүүлэх, дунд, урт хугацаанд үнийн хэлбэлзлийг бууруулах зэрэг ач холбогдолтой. Тиймээс Монголбанк ирэх хоёр жилд инфляцыг 6+/-2 хувийн орчимд тогтворжуулах бодлогыг хэвээр үргэлжлүүлнэ. Харин 2027 оноос эхлэн зорилтын голчийг 5 хувь болгон бууруулахад мөнгөний бодлогын үйл ажиллагааг чиглүүлэхээр тусгалаа.

## Стратеги

1. **Инфляцыг өдөөж буй хүчин зүйлс, хүлээгдээгүй шокууд, тэдгээрийн үргэлжлэх хугацаа болон ирээдүйд үүсэж болзошгүй өөрчлөлтүүдийг төсөөлж мөнгөний бодлогыг боловсруулна.** Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүү нь зээл, хүү, ханш, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импортод нөлөөлөх замаар эдийн засгийн идэвхжилийг эрэлт талаас удирдаж, инфляцад нөлөөлнө. Харин нийлүүлэлт, зардлын шалтгаантай үнийн өсөлтийн үед түүний дам нөлөө, хүлээлтэд үзүүлэх нөлөөнөөс хамаарч мөнгөний бодлогоор хариу үйлдэл үзүүлнэ.
2. **Инфляцыг дунд хугацаанд тогтворжуулахад чиглэсэн байдлаар мөнгөний бодлогын төлөвийг өөрчилнө.** Түр зуурын эсвэл байнгын шинжтэй инфляцад нөлөөлж буй хүчин зүйлсийг зөв ялгаж, дунд хугацаанд инфляцыг тогтворжуулах бодлого баримтална. Түр зуурын, улирлын шинж чанартай үнийн өсөлтөд бодлогын хариу хэмжээ авах нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх, хүлээлтийг буруу удирдах эрсдэлтэй. Тиймээс инфляцад нөлөөлж буй хүчин зүйлийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, шокийн шалтгаан зэргийг харгалзаж, тооцоо судалгаанд үндэслэн ирээдүйд чиглэсэн бодлогын шийдвэр гаргана.
3. **Тодорхой бус байдал, эдийн засгийн эрсдэлийг харгалзан үзэж мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.** Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрт үндэслэн мөнгөний бодлогын шийдвэр гаргахаас гадна макро эдийн засагт учирч болзошгүй хүндрэл, шокуудыг шийдвэр гаргалтдаа харгалзан үзнэ.

Мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах боломжгүй инфляцын хэлбэлзлийг бууруулахад эдийн засгийн бусад агентуудын үүрэг чухал юм. Тиймээс дунд, урт хугацаанд инфляцыг нам, тогтвортой түвшинд барихад дараах арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ:

<sup>3</sup> Jahan, S. (2011). Inflation Targeting: Holding the Line. In *FINANCE & DEVELOPMENT* (p. 72). IMF.

- Эдийн засгийг олон тулгууртай болгон төрөлжүүлэх. Энэ нь валютын ханшийн савлагааг тогтворжуулах, инфляцад шилжих нөлөөллийг бууруулах зэрэг олон эерэг нөлөө үзүүлнэ;
- Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах хүчний ур чадварыг нэмэгдүүлэх. Энэ нь цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөөг бууруулна;
- Төсвийн сахилга бат, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн хэт халалт, уналтын мөчлөг дагасан бодлогоос зайлсхийх;
- Гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулах;
- Нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг сайжруулах. Энэ нь барааны түр хугацааны хомсдолоос үүдсэн үнийн өсөлтөөс сэргийлэхэд тусална;
- Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга батыг сайжруулахад чиглэсэн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх. Энэ нь иргэдийн хэрэглэх, хуримтлуулах зан төлөвт эергээр нөлөөлнө.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, хараат бусаар, хамтын зарчимд тулгуурлан гаргах. Мөнгөний бодлогын хороог жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулах бөгөөд хурлын товыг оны эхэнд зарлана. Хорооноос гарсан шийдвэр эдийн засагт оролцогчдын үйл хөдлөлд нөлөөлөх замаар эрэлт, ханш, инфляцын хүлээлтийг удирдахад чухал ач холбогдолтой.
- Мөнгөний бодлого боловсруулж шийдвэр гаргах үйл явцыг сайжруулж, бодлогын шийдвэрийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд:
  - Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн харилцан хамаарал, мөнгөний бодлогын шилжих сувгийн талаарх судалгааг өргөжүүлнэ;
  - Эдийн засгийн шинжилгээ, төсөөлөл, учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлоход шаардлагатай тоон болон чанарын мэдээллийн баазыг өргөтгөнө;
  - Төсөөлөл, симуляци хийх шинжилгээний загваруудыг сайжруулж, хөгжүүлнэ;
  - Олон улсын байгууллагууд, төв банкнууд, судалгааны байгууллагуудтай хамтран шинжилгээ, тооцоолол дээр ажилладаг экспертүүдийн ур чадварыг дээшлүүлнэ;
- Мөнгөний бодлогын олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлж, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах. Тухайлбал, олон нийттэй харилцах ерөнхий стратегийг тодорхойлж, нэгдмэл байр суурийг бэхжүүлэх бодлогыг боловсруулна.



## **ЗОРИЛТ 1.2**

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

### **Үндэслэл**

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй уян хатан байдлаар өөрчлөгдөх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Монгол Улсын эдийн засаг эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнийн өсөлтөд хэт мэдрэг байдаг бөгөөд төлбөрийн тэнцлийн сөрөг цочролын үед валютын ханш уян хатан байх нь эдийн засаг шинэ нөхцөл байдалд түргэн хугацаанд дасан зохицох, богино хугацаанд төлбөрийн тэнцэлд тохиргоо хийгдэх, гадаад валютын албан нөөцөд ирэх дарамтыг бууруулах давуу талыг олгодог. Улмаар дунд хугацаанд гадаад төлбөрийн чадварын тогтвортой байдлыг хангах, макро болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахад чухал нөлөөтэй. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд тогтвортой үед зах зээлд оролцогчдын тоо бага, тэдгээрийн үйл ажиллагааны улирлын онцлог, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээ бага гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалан богино хугацаанд зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүсэж улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл бий болох нь зах зээлд цочрол үүсгэж, улмаар зах зээлд оролцогчдын хүлээлт, үйл хөдлөлд нөлөөлөх замаар цочролын хэмжээг дэвэргэх сөрөг нөлөө гарч болзошгүй байдаг. Иймд уг эрсдэлээс зайлсхийх үүднээс Монголбанк уян хатан ханшийн бодлого баримтлахдаа богино хугацаанд үргэлжлэх шинжтэй эрэлт нийлүүлэлтийн зөрүү үүсэх тохиолдолд зах зээлд оролцох нь зохимжтой юм.

Түүнчлэн ханшийн бодлогоор худалдаалагддаг секторын өрсөлдөх чадварыг дэмжих шаардлагатай байна. Эрдэс баялгийн салбараас шалтгаалсан хөрөнгийн урсгал нэмэгдсэнээр төгрөгийн бодит ханш тэнцвэрт түвшнээсээ хэт хазайхад хүргэж болзошгүй юм. Энэ нь экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг доройтуулж, эдийн засгийг зөвхөн нэг сектор буюу уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бууруулахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Улмаар гадаад валютаар орлого олох, гадаад валютын хэрэглээг бууруулах боломж хязгаарлагдсанаар төлбөрийн тэнцлийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлдэг. Иймд валютын ханшийн уян хатан байдлыг тодорхойлохдоо огцом хэлбэлзлийг бууруулахын зэрэгцээ экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг харгалзан үзэх шаардлагатай. Мөн эдийн засгийн сөрөг цочролын үед ханшийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүгийн секторын тогтвортой байдлыг харгалзан үзэх шаардлагатай болдог. Манай улсын хувьд эрдэс бүтээгдэхүүний үнийн огцом хэлбэлзэл болон хөрөнгийн урсгал нь зах зээлд тодорхойгүй байдлыг бий болгож, долларжилтийг нэмэгдүүлэн санхүүгийн системийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг.

Төв банк өнгөрсөн 10 гаруй жилд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцож ирлээ. Ингэснээр төв банк гадаад секторт үүссэн том хэмжээний сөрөг цочролыг валютын ханшаар дамжуулан зөөлрүүлж эдийн засагт шаардагдах тохиргоо хийгдэх боломж олгож байсан бол гадаад валютын орох урсгал өндөртэй үеүдэд гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлж ажиллав. Түүнчлэн валютын ханшид

баримталж буй төв банкны бодлогын үр дүнд 2016 он болон 2022 онд гадаад секторт бий болсон сөрөг цочрол санхүүгийн систем, бодит секторт шилжин даамжрахаас сэргийлсэн. Иймд эдийн засгийн өсөлт 2024 оны эхний улиралд 7.8 хувь, 2024 оны 7 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 4.7 тэрбум ам.доллар, инфляц улсын хэмжээнд 5.5 хувь болж зорилтот түвшинд хүрсэн зэрэг эдийн засгийн таатай үед энэхүү бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эдийн засгийг улам тогтворжуулах нь зүйтэй байна.

Мөн төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2024 оны эхний 7 сарын байдлаар 0.9 хувиар чангарч, бусад улс оронтой харьцуулахад харьцангуй тогтвортой түвшинд байлаа. Тухайлбал, 2024 оны эхний 7 сарын байдлаар нийт улсын орнуудын валютын ханшийн 73 хувь нь ам.долларын эсрэг суларсан байна (Зураг 4).

Зураг 4. Дэлхийн улс орнуудын валютын ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (158 улс), оны эхнээс 2024/07/31-ний өдрийн байдлаар



Эх сурвалж: Блумберг

Түүнчлэн манай улс шиг жижиг, нээлттэй эдийн засгийн хувьд үндэсний валютын ханш сулрах нь импортын бүтээгдэхүүний үнэ, цаашлаад бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний орцоор дамжин нийт үнийн түвшинг нэмэгдүүлэх нөлөөтэй байдаг. Харин уламжлалт эдийн засгийн онолын дагуу тухайн улсын валютын ханш суларснаар импортын бүтээгдэхүүнийг худалдан авах дотоодын эрэлт импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн рүү шилжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах замаар тухайн улсын экспорт нэмэгдэх, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг гэж үздэг. Иймд валютын ханш сулрах болон чангарах нь тухай улсын эдийн засгийн онцлогоос шалтгаалан эерэг нөлөөтэй бөгөөд эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй байдлаар валютын ханш уян хатан байдлаар тогтох нь хамгийн чухал юм.

## Стратеги

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг хангаж, валютын захад ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор оролцоно.

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого нь гадаад зах зээлд бий болсон аливаа сөрөг цочролын бодит секторт үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлэх, экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг алдагдуулахгүй байхад чиглэнэ.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ханшийн хэлбэлзэл зах зээлд үүсэж улмаар санхүүгийн тогтвортой байдал алдагдахаас сэргийлэх үүднээс гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанк тухай бүр захад оролцоно.
- Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг тогтвортой хадгалах, нийт нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэр татах ажлыг зохион байгуулна.
- Валютын захын оролцогчдын хүлээж буй ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### ЗОРИЛТ 1.3

Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

#### Үндэслэл

Дэлхийн улс орнууд 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш санхүүгийн системийн тогтвортой байдлыг бүхэлд нь хангах асуудлыг чухалчлах болж, түүний сегментүүдэд эрсдэл хэт нэмэгдэж хуримтлагдахаас сэргийлэх, хямрал өрнөж эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг хамгийн бага байлгахад чиглэсэн макро зохистой бодлогыг хэрэгжүүлж байна.

Жижиг нээлттэй эдийн засагтай, хөрөнгийн урсгалын хэлбэлзэл өндөртэй улсуудын хувьд макро эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг зэрэг хангах нь бодлого боловсруулагчдын хувьд томоохон сорилт болсоор байна. Ялангуяа, эдийн засагт сөрөг шокууд зэрэг тулгарсан үед макро эдийн засгийн уналтаас сэргийлэх, тогтворжуулах нь бодлого боловсруулагчдын зүгээс макро эдийн засгийн болон санхүүгийн бодлогуудыг хослуулан ашиглах шаардлагыг бий болгож байна.

Макро зохистой бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь хүчин зүйлс нь институцийн болон үйл ажиллагааны оновчтой тогтолцоог бүрдүүлэх явдал байна. Манай улсын хувьд 2018 онд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх, үүргийг Монголбанканд олгосон. Улмаар Монголбанк нь санхүүгийн тогтолцооны мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.


Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл 2021 оны сүүл үеэс сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарч, хөнгөлөлттэй хөтөлбөрүүдийн зээл олголт нэмэгдсэнээр манай улсын санхүүгийн мөчлөг сэргэж эхэлсэн. Харин бизнесийн зээл олголт нэмэгдсэнээр үл хөдлөх хөрөнгийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалан санхүүгийн мөчлөг богино хугацаанд унасан боловч 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар өсөх хандлагатай байна (Зураг 5). Ийнхүү зээл олголт нэмэгдэж, санхүүгийн салбар тэлэх нь аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа, эдийн засгийн өсөлтийг дэмжих эерэг нөлөөтэй боловч иргэдийн хэрэглээний зээл хэт ихээр нэмэгдвэл өрхийн аж ахуйн салбарт эмзэг байдлыг бий болгож, санхүүгийн системд мөчлөгийн эрсдэл хуримтлагдах эрсдэлтэй.

Тухайлбал, 2023 оноос эхэлсэн цалин, тэтгэврийн өсөлт нь хэрэглээний зээлийн өсөлтийг эрчимжүүлж, 2024 оны 5 дугаар сарын байдлаар 10.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.4 хувиар нэмэгджээ. Харин банкны салбарын нийт зээлийн жилийн өсөлт 28.2 хувь байсан бөгөөд үүний 11.4 нэгж хувийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлж байна (Зураг 6). Банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ 2018 оны эцэст 36.2 хувьд хүрээд байсан бол иргэдийн хэрэглээний зээлд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалт тогтоох макро зохистой бодлогын арга хэмжээний нөлөөгөөр 2019 оноос эхлэн буурч, 2021-2022 онд дунджаар 26.6 хувьд хүрч тогтворжоод байв. Харин сүүлийн 2 жилийн цалин, тэтгэврийн өсөлтийн нөлөөгөөр энэхүү хувь хэмжээ 2024 оны 4 дүгээр сард 32.3 хувьд хүрч эргэн нэмэгдээд байна (Зураг 6). Цаашид зээлийн хэт өсөлтөөс үүдэх эрсдэлийг бууруулах, зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулан тогтвортой хадгалах шаардлагатай юм.

Зураг 5. Бизнесийн болон санхүүгийн мөчлөг



Зураг 6. Банкны зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт /хувь ойролцоогоор/




Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: \*Зээлийн бодит өсөлт, \*\*зээл, ДНБ-ий харьцаа.


Түүнчлэн, банк болон бусад санхүүгийн байгууллагын давхар зээлтэй иргэдийн зээлийн дүн огцом өсөж, санхүүгийн салбарт нийтлэг хамаарлаас үүдэлтэй системийн эрсдэл бий болж байна. Тодруулбал, банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо сүүлийн 1 жилд хурдтай өсөж, 2024 оны 5 дугаар сарын байдлаар 350 мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 26.4 хувиар нэмэгдсэн дүн юм. Эдгээр иргэдийн банкны зээлийн үлдэгдэл 6.8 их наяд төгрөгт, ББСБ-ын зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад харгалзан 44.2 болон 53.4 хувиар эрс нэмэгджээ (Зураг 8). Мөн дундаж

ӨОХ нь 79.8 хувьтай байгаа нь эдгээр зээлдэгчдийн хувьд бодит өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна. Иймд банк болон бусад байгууллагаас давхар зээлтэй иргэдийн хувьд сөрөг шок тулгарч, зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учрах тохиолдолд банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Зураг 7. Банкны салбарын нийт зээлд хэрэглээний зээлийн эзлэх хувь




Зураг 8. Банк болон ББСБ-аас олгосон иргэдийн зээл, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголбанк, Зээлийн мэдээллийн сан

Нөгөөтэйгүүр банкны салбарын эх үүсвэрийн долларжилт сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч байгаа хэдий ч олон улсад эрсдэлгүй хүүгийн түвшин өндөр хэвээр байгаа нь хөрөнгийн урсгал гадагшлах эрсдэлийг нэмэгдүүлж байна. 2022 оны ханшийн огцом сулралын үед эх үүсвэрийн долларжилт 36.6 хувьд хүрээд байсан бол 2023 оноос эхлэн экспорт, төлбөрийн тэнцэл сайжирч, ГВУН нэмэгдсэнээр гадаад валютын ханш тогтворжиж, үүнийг дагаад долларжилт эрчимтэй буурч 2024 оны 5 дугаар сарын эцэст 24.9 хувьд хүрлээ (Зураг 9). Харин тус хугацаанд Монголын арилжааны банкуудын зарлаж буй ам.долларын хадгаламжийн дундаж хүү (3.8%) нь АНУ-ын ХНБ-ны бодлогын хүү (5.25%-5.5%)-нээс нам дор түвшинд хадгалагдсан хэвээр байгаа ба ам.долларын эрсдэлгүй хүү болох АНУ-ын ЗГ-ын үнэт цаас (4.35%-5.38%) нь илүү өгөөж санал болгож байна. Иймд гадаад валютын хадгаламж эзэмшигчдийн хувьд гадны зах зээлд илүү хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэх, гадаад валютын гадагшлах урсгал, цаашлаад валютын ханшинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй (Зураг 10).

Зураг 9. Зээл, хадгаламжийн долларжилт      Зураг 10. Банкнуудын валютын хадгаламжийн хүү болон гадаад суурь хүү



Эх сурвалж: Монголбанк

Ирэх онд дотоод эдийн засгийн нөхцөл байдал, гадаад орчны нөлөөг харгалзан санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянаж, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн макро зохистой бодлогыг үргэлжлүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь чухал байхаар байна. Учир нь өмнөх жилүүдэд тохиож байсан бодит эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн уналтууд давхцаж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэн, банк, санхүү, бодит эдийн засгийн хүндрэл үүсэх эрсдэл хэвээр байна. Тухайлбал, Орос-Украины хурцадмал байдал, үүнээс үүдэлтэй худалдааны хориг арга хэмжээнүүд нь дэлхийн эрчим хүч, хүнс болон түүхий эдийн зах зээлд сөрөг шокуудыг бий болгон, улмаар дэлхийн улс орнуудад инфляцын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилийг сааруулах зэргээр макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэв. Цаашид энэхүү нөхцөл байдал даамжирсан тохиолдолд дэлхийн улс орнуудад эрчим хүч, хүнсний нийлүүлэлтийн хомсдол, өндөр инфляц илүү урт хугацаанд хадгалагдах, эдийн засгийн хүндрэл үүсгэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Түүнчлэн, олон улсын зах зээлд суурь хүүгийн түвшин өндөр хэвээр байгаа нь засгийн газар, аж ахуйн нэгж, этгээдийн хувьд санхүүжилтийн зардлыг өсгөн, өрийн тогтвортой байдлаа хангах нь том сорилт болж байна. Олон улсад арилжааны зориулалттай үл хөдлөхийн үнэ эрчимтэй унаж, банкны бус санхүүгийн салбарын зээл эрс нэмэгдэн, АНУ-д аж ахуйн нэгжүүд ихээр дампуурах болсон нь системийн эрсдэл, цаашлаад глобал санхүүгийн хямралд хүргэж болзошгүй юм. Энэ нь төлбөрийн тэнцэл, орлого, зээлийн сувгаар дамжин Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

### Стратеги

Монголбанк нь макро зохистой бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог

олон улсын сайн туршлагад нийцүүлэн бэхжүүлнэ.

- Макро санхүүгийн бодлогуудын арга хэрэгслүүдийн үр нөлөө, харилцан хамаарлыг тодорхойлох шинжилгээний цогц арга зүйг хөгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд институцийн хувьд хийх шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлүүдийн саналыг боловсруулна.
- Макро санхүүгийн бодлогын нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэн, үр дүнг зах зээлд оролцогчдод мэдээлж, хүлээлтийг удирдах арга хэмжээнд ашиглаж эхэлнэ.
- Санхүүгийн системд үүсэж буй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг сайжруулан, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэрийг гаргахдаа мөнгөний, ханшийн болон макро зохистой бодлогын харилцан үйлчлэлийг харгалзан үзнэ.

## 2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

### ЗОРИЛТ 2.1

Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлнэ.

#### Үндэслэл

Эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлж буй банкны салбарт Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, эрдэс, түүхий эдийн эрэлт, үнээс хамааралтай байдлыг багасгах, олон тулгуурт эдийн засгийг бий болгохын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татах шаардлага тулгарч байна. Ковид-19 цар тахал, эдийн засгийн тодорхойгүй байдлаас улбаатайгаар өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын банкны системийн зээлийн өсөлтийн дийлэнх хувийг хэрэглээний зээл бүрдүүлж, харин бизнесийн зээл олголт саарч, банкнуудын гадаадаас татсан эх үүсвэр буурч, хүүгийн түвшний улмаас эх үүсвэрийн зардал нэмэгдсэн.

Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд гадаадын банк, санхүүгийн байгууллага нь арилжааны банкны хувьцааг 20 хувь хүртэл эзэмших, өөрийн банкны салбар байгуулах, охин компани хэлбэрээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах боломж бий болсон хэдий ч одоогийн байдлаар гадаадын банк, санхүүгийн байгууллагаас зөвхөн төлөөлөгчийн газраа нээн ажиллуулахаас хэтрэхгүй байна. Тайлант оны II дугаар улирлын байдлаар Монгол Улсад үүсгэн байгуулагдсан зургаан банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд гадаадын хөрөнгө оруулалт хийгдээд байна. Системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжин, хөрөнгө оруулалт татах таатай орчин бүрдэж байгаа боловч гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн оролцоо дутмаг хэвээр байна. Цаашид банкны салбарын урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, инновац, өндөр технологид суурилсан, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд тус салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих нь нэн чухал байна.

#### Стратеги

- Гадаадын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас банканд хөрөнгө оруулах, охин компани, салбар нээн, үйл ажиллагаа эрхлэх асуудлыг Монгол Улсын санхүүгийн салбар, эдийн засгийн тогтвортой байдалд учруулах эрсдэл, эерэг, сөрөг нөлөөлөл болон ирээдүйд үүсэж болох үр дагаврыг харгалзан үзсэний үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ, зохицуулалт, эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлэхийг зорино.

#### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтыг татах зохицуулалтын орчинг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлнэ.
- Олон улсын санхүүгийн байгууллагын арилжааны банканд дахь хувь эзэмшил Банкны тухай хуульд заасан хязгаарлалтад хамаарахгүй байхаар хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулна.



## ЗОРИЛТ 2.2

Банкнуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлнэ.

### Үндэслэл

Монголбанкнаас банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд олон улсын хяналт шалгалтын Базел стандартын Бүлэг 2-ыг<sup>4</sup> банкнуудын болон банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд туршилтын байдлаар нэвтрүүлж, банкны системийн онцлогт тааруулан нутагшуулах ажлыг гүйцэтгэж байна.

Монголбанк сүүлийн 2 жилийн хугацаанд банкнуудын Базел стандартын Бүлэг 2-ын шаардлагын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (PLAAP)-г дотооддоо үнэлж, бэлтгэсэн тайланг хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-аар үнэлэх ажлыг туршилтын байдлаар 2 удаа гүйцэтгэсэн. Энэхүү туршилтын хугацаанд Монголбанк болон банкнууд холбогдох аргачлалыг боловсруулах, хүний нөөцийг чадавхжуулах, хяналт шалгалтын үнэлгээ, арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллаж байна. Бүлэг 2-ын өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын шаардлагуудыг банкны салбарын нөхцөл байдлыг харгалзан үзэж, тогтвортой байдлыг хангах байдлаар шат дараатай нэвтрүүлж, холбогдох журам, зааварт тусгах ажлыг зохион байгуулж байна.

Манай улсын хувьд Базелын цуврал стандартыг дотоодын банкны системийн онцлогт нийцүүлэн хэсэгчлэн нэвтрүүлсэн бөгөөд одоо мөрдөгдөж буй зохицуулалтын хүрээнд зээлийн, гадаад валютын ханшийн, үйл ажиллагааны эрсдэлүүд, өөрийн хөрөнгийн нөөц интервал, хөшүүргийн харьцаа, нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тооцдог. Харин Базел стандартын Бүлэг 2-ын шаардлагыг нэвтрүүлснээр дээр дурдсанаас бусад гол эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, тэдгээрт харгалзах өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцох, банкны бизнес төлөвлөгөө, стратеги, стресс тест зэрэгт үндэслэн ирээдүйд шаардлагатай эдийн засгийн өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлж, төлөвлөх тогтолцоог бүрдүүлэх чухал ач холбогдолтой. Үүний үр дүнд банкнууд өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй гол эрсдэлүүдээс сэргийлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө, хөрвөх чадвартай байх тогтолцоог бүрдүүлж, банкнуудын засаглал, эрсдэлийн удирдлага болон эрсдэл даах чадамжийг бэхжүүлэх боломжтой.

Базелын цуврал стандартад тодорхойлсон банкны өөрийн хөрөнгийн шаардлагад зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны эрсдэлүүдээс гадна хүүгийн, төвлөрлийн болон бусад гол эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийг тооцдог. Банкнууд нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ, эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий нөөц өөрийн хөрөнгийг бүрдүүлж ажиллах шаардлагыг тавьдаг. Үүнд: 1) нөөц өөрийн хөрөнгө (CCB – Capital Conservation Buffer),

<sup>4</sup> Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос Базел 1, 2, 3 цуврал стандартуудыг 1988, 2004, 2010 онд тус тус нэвтрүүлж, хэрэгжүүлж байна. Бүлэг 2 (Pillar 2) нь Базел 2, 3 стандартын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас банкнуудын эрсдэлийн удирдлага, өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний дотоод үнэлгээний үйл явцыг үнэлэх, Бүлэг 1-г тусгагдаагүй бусад гол эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах тогтолцоог бүрдүүлэхийг зорьдог.

2) мөчлөг сөрсөн нөөц өөрийн хөрөнгө (CCyB – Countercyclical Capital Buffer), 3) системийн нөлөө бүхий банкнуудад тавих нэмэлт нөөц өөрийн хөрөнгийн шаардлага хамаарна (Зураг 11).

Зураг 11. Өөрийн хөрөнгийн талаарх Базел стандартын тогтолцоо

<b>Бүлэг 1</b> Өөрийн хөрөнгийн доод шаардлага	<b>Бүлэг 2</b> Хяналт шалгалтын үнэлгээ	<b>Бүлэг 3</b> Зах зээлийн сахилга бат
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд</b> <ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн эрсдэл</li> <li>- Зах зээлийн эрсдэл</li> <li>- Үйл ажиллагааны эрсдэл</li> <li>- Нөөц өөрийн хөрөнгө (CCB)</li> <li>- Мөчлөг сөрсөн нөөц өөрийн хөрөнгө (CCyB)</li> <li>- Системийн нөлөө бүхий банкны нэмэлт нөөц өөрийн хөрөнгө (SIB)</li> </ul> </li> <li>• <b>Хөшүүргийн харьцаа</b></li> <li>• <b>Хөрвөх чадварын харьцаа</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR)</li> <li>- Цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR)</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ИСААР):</b> Голлох эрсдэлүүдийн үнэлгээ, өөрийн хөрөнгийн төлөвлөлт, стресс тест</li> <li>• <b>Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ИЛААР):</b> Хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээ, санхүүжилтийн нөөц төлөвлөгөө, стресс тест</li> <li>• <b>Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP):</b> Банкны эрсдэлийн ерөнхий түвшний үнэлгээ, хяналт шалгалтын арга хэмжээ</li> </ul>	<p><b>Ил тод байдлын шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Банкнуудын эрсдэлийн ерөнхий түвшин, эрсдэлийн удирдлагын тогтолцооны ил тод байдал</li> </ul>

Монголбанкнаас Бүлэг 2-ын шаардлагыг мөн өөрийн банк, санхүүгийн системийн онцлог, нөхцөл байдалтай уялдуулан нэвтрүүлэхээс гадна одоо хэрэгжиж байгаа өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын зарим шаардлагыг Бүлэг 1-ийн стандартын дагуу өөрчлөн нэвтрүүлнэ<sup>5</sup>. Түүнчлэн Бүлэг 2-ын хяналт шалгалтын үнэлгээний аргачлалын дагуу аливаа илэрсэн доголдол, дутагдлыг залруулж, болзошгүй эрсдэлийг бууруулах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг сайжруулах арга хэмжээг авах тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна.

Иймд Базел стандартын өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын шаардлага, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг банкны салбарын зохицуулалтад нэвтрүүлэх хүрээнд Монголбанкнаас холбогдох аргачлалуудыг тодорхойлон банкнуудад мөрдүүлэх, бусад хууль тогтоомж, журам, зөвлөмжтэй уялдуулан тусгахад чиглэсэн ажлуудыг гүйцэтгэнэ.

<sup>5</sup> Манай улсын банкны системд одоо хэрэгжиж буй банкны өөрийн хөрөнгийн шаардлага нь Базел стандартын өөрийн хөрөнгийн шаардлагатай харьцуулбал Бүлэг 1 дэх зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны эрсдэлүүдийг тооцох аргачлал, нөөц өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын шаардлагын хувьд тодорхой ялгаатай байдаг. Тухайлбал, зах зээлийн эрсдэлийн хүрээнд зөвхөн гадаад валютын ханшийн эрсдэлийг харгалзан үздэг бол хөрвөх чадварын эрсдэлийг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтээр хянадаг. Энэ нь Базелийн стандартыг улс орон бүр өөрийн онцлогт нийцүүлэн нэвтрүүлдэгтэй холбоотой.

## Стратеги

- Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийж, гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх зорилгоор Базелын цуврал стандартад тусгагдсан аргачлалуудыг эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар нэвтрүүлэх зарчмыг баримтална.
- Банкны хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх хүрээнд холбогдох журам зааврыг боловсруулж, өөрчлөн шинэчилж, уялдаа холбоог хангах замаар зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Базел стандартын Бүлэг 2-ын шаардлага болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (LAAP)-г дотооддоо үнэлэх аргачлалыг холбогдох журам, зөвлөмжид тусгаж, банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин зэрэгтэй уялдуулан хугацаат төлөвлөгөөний дагуу банкнуудад шат дараатайгаар мөрдүүлнэ.
- Хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх хүрээнд холбогдох журам, зөвлөмжийг шинэчилж, хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх болон албадлагын арга хэмжээний тогтолцоотой уялдуулна.
- Банкны салбарт зохицуулалтын шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэх хүрээнд банкнуудад арга зүйн заавар туслалцаа үзүүлж, банкны хянан шалгагч нарыг эрчимжүүлсэн сургалтад хамруулж, чадавхжуулна.

### ЗОРИЛТ 2.3

Банкны салбарын тогтвортой, ногоон санхүүжилтийн мэдээлэл цуглуулах тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, стресс тестийн арга зүйг хөгжүүлнэ.

#### Үндэслэл

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийг өдөөж, дэлхийн агаарын температурыг өсгөж байна. Үүнээс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, далайц нэмэгдэж, улс орнуудын эдийн засаг, санхүүгийн салбарт ихээхэн сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тиймээс олон улс орон энэхүү уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, бодлого боловсруулалтдаа тусгаж эхэллээ.

Банк, санхүүгийн байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг хэмжих стресс тестийг 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш хийж эхэлжээ. Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тест нь байгалийн гамшигт үзэгдэл (physical risks) болон бодлогын өөрчлөлтэй холбоотой (transition risks) эрсдэлээс үүдсэн сөрөг үр дагаврыг банкны удирдлага болон санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагуудад анхааруулж, томоохон шок тохиолдоход үүсэх алдагдлыг арилгахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг банкнууд болон санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагуудад мэдээлэхэд ашиглагддаг.

Монголбанк “Тогтвортой санхүүжилтийн замын зураг”-ийн хэрэгжилтийн хүрээнд 2023 онд Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх, удирдах аргачлалыг боловсруулан батлуулаад байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн банкны салбарт

учирч болох нөлөөллийг тооцоолох, банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг үнэлэх стресс тестийн аргачлалыг хөгжүүлэхээр олон улсын зөвлөхүүдтэй ажиллаж байна. Ирэх онд санхүүгийн салбарт үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тодорхойлох, тооцох аргачлалыг боловсруулж, шаардлагатай мэдээллийг цуглуулах, туршилтын тооцооллыг хийхээр төлөвлөж байна. Манай улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө өндөртэй улсуудын нэгд тооцогддог бөгөөд уул уурхай болон хөдөө аж ахуйн салбараас өндөр хамааралтай эдийн засагтай тул уур амьсгалын биет болон шилжих эрсдэл өндөр байна.

## ШИГТГЭЭ 2. Банкнуудын ногоон зээл

Ногоон зээлийн тайланг 2019 оны IV улирлаас эхлэн улирлын давтамжтай аван нэгтгэж олон нийтэд мэдээлж байна. Банкнуудын олгосон ногоон зээл 2024 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өсч 1071.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын нийт зээлийн 3.2 хувийг эзэлж байна. Нийт ногоон зээлийг үйл ажиллагааны салбарын хувьд харбал, эрчим хүчний хэмнэлтийн салбарт хамгийн өндөр 651 тэрбум төгрөг буюу 60.8 хувь нь олгогджээ.

Зураг 12. Ногоон зээл 2024 оны II улирлын байдлаар



Эх сурвалж: Монголбанк

2024 онд гүйцэтгэсэн ногоон зээлийг хүйсээр ангилах ажлын үр дүнгээс танилцуулбал: Банкнуудаас олгосон ногоон зээлийн 2023 оны үлдэгдлийн 34 хувь буюу 270.6 тэрбум төгрөг нь эмэгтэй зээлдэгчдэд олгогдсон бөгөөд үйл ажиллагааны салбарын хувьд зөвхөн ногоон барилгын салбарт эмэгтэй зээлдэгчдийн зээл дийлэнх нь байна. Харин **дансны тооны хувьд дунджаар 57% нь эрэгтэй зээлдэгчид байгаагийн зэрэгцээ** салбар бүрт эрэгтэй зээлдэгчдийн тоо эмэгтэйчүүдийнхээс илүү байна.

Зураг 13. Зээлийн үлдэгдэл /2023 он/



Зураг 14. Зээлдэгчид /дансны тоо, 2023 он/



Эх сурвалж: Монголбанк

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг хэмжих стресс тест нь банк, санхүүгийн салбарт нийгэм эдийн засгийн болоод цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг шокуудын нөлөөллийг үнэлдэг. Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тестийг банкны салбарын үндсэн стресс тестийн аргачлалтай нийцүүлэн боловсруулах бөгөөд уг аргачлалыг гүйцэтгэснээр уур амьсгалын өөрчлөлтийн банкнуудад үзүүлэх үр дагавар, нөлөөллийг тооцох арга зүйг тогтоох, сайжруулах, арга аргачлалыг боловсронгуй болгох ач холбогдолтой.

Уур амьсгалын өөрчлөлтийн шинжилгээнд шаардлагатай тоон мэдээллийг тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын санхүүжилтийн таксономийн ангиллаар их өгөгдлийн дэд бүтцийн суурь дээр тулгуурлан цуглуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар хийж эхлүүлээд байна. Уур амьсгалын мэдээллийн санг бүрдүүлснээр цаашид тогтвортой, ногоон санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх суурийг тавихаас гадна банкнуудын санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг салбараар хэмжих боломжтой болно.

### Стратеги

Монголбанк Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тестийн аргачлал боловсруулахдаа дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тестийн аргачлалыг Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн системийн бүтцэд нийцүүлэн боловсруулж, тогтмол сайжруулан хөгжүүлнэ.
- Их өгөгдлийн суурь дэд бүтцийг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн санг хөгжүүлэх, тогтмолжуулна.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тестийн аргачлалыг олон улсын стандарт болон бусад орны сайн туршлагыг судалж, манай улсын макро эдийн засаг, банк санхүүгийн салбарын бүтэц, онцлогт тохируулан боловсруулж, хөгжүүлнэ.
- Уг аргачлалд ашиглагдах макро загварууд, суурь болон сөрөг сценари төсөөллийг тодорхойлох, шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэх, шинэчлэх.
- Уур амьсгалын өөрчлөлтийн стресс тестийн хувилбар, сценари төсөөллийг боловсруулна.
- Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний болон төлбөрийн чадварын стресс тестийн загварыг боловсруулж, уур амьсгалын шокууд нь банкнуудын тайлан тэнцэл, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж буйг урьдчилсан байдлаар тогтоох, шинжилнэ.
- ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн хэрэгжилтийг санхүүгийн салбарт туршиж, таксономийн дагуу зээлийн үр нөлөөг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн суурь шаардлага, мэдээлэл цуглуулах процесс, эх сурвалжуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэн, холбогдох талуудтай хамтран ажиллана.

### ЗОРИЛТ 2.4

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэж, шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ.

### Үндэслэл

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд 2017 онд хийсэн Харилцан үнэлгээний үр дүнд суурилан ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д оруулж байсан. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүнд, жил хүрэхгүй хугацааны дотор нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай үүрэг даалгаврыг бүрэн хангаж ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан. Үүнээс хойш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх ажлыг шат дараатай авч хэрэгжүүлсний үр дүнд одоогоор ФАТФ-ын 40 Зөвлөмжийн бүх шаардлагыг хангасан Ази, Номхон далайн бүсийн анхны орон болоод байна.

Хууль эрх зүйн орчны олон улсын стандартад нийцтэй байдал ийнхүү сайжирсан ч хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах тал дээр анхаарах шаардлагатай хэвээр байна. ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үр дүнтэй хэрэгжилтийг үнэлдэг 11 шалгуур үзүүлэлтийн хувьд манай улс хангалтгүй үнэлгээтэй хэвээр байна. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2028-2029 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд дараагийн Харилцан үнэлгээг хийнэ.

Энэхүү харилцан үнэлгээнд бэлтгэх зорилгоор Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд жил бүр ФАТФ-ын шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын үнэлгээг хийхэд шат дараатайгаар бэлтгэх, өөрөө өөрийгөө үнэлэх ажил тусгагдсан. Үүний дагуу Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурын дагуу 2025 онд өөрөө өөрийгөө үнэлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.

Тус үнэлгээний үр дүнгээр хангалтгүй гэж үнэлэгдсэн хэсэгт онцгойлон анхаарч, дутагдлыг залруулах арга хэмжээ авах, хэрэгжилтэд анхаарах, хэрэгжилтийн үр дүнг статистик, тоон мэдээлэлд үндэслэн гаргаснаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо бэхжиж, дараагийн Харилцан үнэлгээнд амжилттай үр дүн үзүүлэх, олон улсад эерэгээр үнэлэгдэх үндэс суурь бий болно.

Түүнчлэн ФАТФ-ын Зөвлөмжийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан зарчмаар явуулах шаардлагатай бөгөөд үндэсний, салбарын, мэдээлэх үүрэгтэй этгээдийн түвшинд эрсдэлийн үнэлгээг хийдэг. Монгол Улсын хувьд үндэсний эрсдэлийн үнэлгээг 2016, 2020 онуудад хийж байсан бөгөөд дараагийн үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээний ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан Үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломжтой болно. Ингэснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр дүнг дээшлүүлэх, шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой юм.

### Хүрэх үр дүн

ФАТФ-ын аргачлалын дагуу үр дүнтэй байдлын 11 шалгуур үзүүлэлтээр өөрөө өөрийгөө үнэлэх, Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээ хийх ажлуудыг хийснээр дараах үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг хангах;
- Тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлнэ.
- Дараагийн харилцан үнэлгээнд амжилттай үнэлгээ авах, ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтад орохоос сэргийлнэ.
- Олон нийтэд тархсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаар сөрөг ойлголтыг тэнцвэржүүлнэ.

- Олон улсын хэмжээнд манай улсын банк, санхүүгийн байгууллагын нэр хүнд өсөх, гадаад харилцааг өргөжүүлэх, корреспондент банкны харилцаа нэмэгдэх, төлбөр тооцооны шимтгэл буурах, хугацаа богиносгох, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэргээр эдийн засгийн эерэг нөлөөлөл бий болох боломжтой.

## Стратеги

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрөө өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээ хийх ажлуудыг эхлүүлнэ.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрөө өөрийгөө үнэлэх багийг бүрдүүлэх, шаардлагатай сургалт, хэлэлцүүлгийг хийнэ.
- ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үзүүлэлтийг үнэлэхэд шаардлагатай статистик тоон мэдээллийг холбогдох байгууллагууд гаргадаг болох ажлыг зохион байгуулна.
- Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой зохион байгуулалтын ажлыг хийх, оролцох байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллана.
- Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг тодорхойлох, хэлэлцүүлнэ.
- Өөрөө өөрийгөө үнэлэхэд ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, дэд бүтцийг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- Үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж буй болон хууль сахиулах байгууллагад шилжүүлж буй тайлан, мэдээллийн тоо, чанарт хяналт тавина.
- Мэдээлэх үүрэгтэй этгээдийн чадавхыг сайжруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн холбоодын боловсон хүчний чадавхжуулах ажилд дэмжлэг үзүүлэх замаар үр дүнтэй байдлыг нэмэгдүүлнэ.
- Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэн, мэдээлэх үүрэгтэй этгээдийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанаржуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлнэ.



### 3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

#### ЗОРИЛТ 3.1

Төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг дэмжиж, цаг үедээ нийцсэн хяналт зохицуулалтын уялдааг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

#### Үндэслэл

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу төлбөрийн систем, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг хянан, зохицуулах чиг үүрэгтэй билээ. Энэ хүрээнд зах зээлд шинээр нэвтэрч буй төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл, санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, олон улсын стандартын дагуу үнэлэн нийцүүлэх зарчмыг баримтална.

Санхүүгийн салбарт технологийн шинэчлэл, цахим шилжилтийн эерэг нөлөөгөөр шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ тухайлбал, төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой зарим үйл ажиллагаа нь санхүүгийн хэрэглэгч, цаашлаад салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байгаа тул санхүүгийн хянан зохицуулах байгууллагуудад зохицуулалт болон хяналтын тогтолцоог цаг тухайд нь холбогдох өөрчлөх, хөгжилд дасан зохицсон тогтвортой эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Иймээс инноваци, техник технологийн дэвшилтэй хамт Монгол Улсад шинээр нэвтэрч байгаа төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг өнөөгийн хууль тогтоомж бүрэн зохицуулах чадамжтай эсэхийг дүгнэх, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн давхардал хийдлийг судлах ажлыг Монголбанк Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх шаардлагын дагуу эхлүүлээд байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлан мөрдүүлснээс хойш хугацаанд Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг дагалдан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоос бусад байдлаар уг хуульд зарчмын томоохон шинэчлэл, өөрчлөлт ороогүй юм. Тус хууль нь Монголбанкны бүрэн эрх, зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн зохицуулалт, зээлийн мэдээлэлд агуулагдах мэдээллийн төрөл, зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн ашиглалт зэрэг өргөн агуулгатай зохицуулалтыг тусгаснаас гадна Дэлхийн банкны 2011 оны “Зээлийн мэдээллийн үндсэн зарчмууд”-ын дийлэнхийг агуулсан байдаг. Хууль хэрэгжих явцад Монголбанкны хяналт шалгалт, зээл төлөлтийн түүхэнд суурилсан оноо, үнэлгээ хийх (скоринг), зээлдэгч-хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн мэдээлэлтэй холбоотой маргаан шийдвэрлэх зэрэг зарим харилцааг бүрэн зохицуулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Мөн зээлийн мэдээллийн үйлчилгээний тоног төхөөрөмж, санхүүжилт, мэргэшсэн хүний нөөц дутмаг, нийгэм дэх зээлийн мэдээллийн ойлголт бүрдээгүй шилжилтийн үеийн нөхцөл байдлаас улбаалж Монголбанк болон зээлийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчийн аль алинд зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх зохицуулалттай байсан ч төр хувийн хэвшилд энэ чиг үүргийг бүрэн шилжүүлэх, цаашид зээлийн мэдээллийн

үйлчилгээг эрхлэхгүй байх нь зохистой. Өөрөөр хэлбэл ашгийн төлөө хуулийн этгээд зээлийн мэдээллийн бүтээгдэхүүнийг боловсруулж олон нийтэд санал болгосноор өөрийн үйл ажиллагааны зардлыг нөхөж, ашигт ажиллагааг хангах бөгөөд Монголбанк зөвхөн үйл ажиллагааг нь хянан шалгах, банкны системийн тогтвортой байдлын хүрээнд зээлийн мэдээллийн санг ашиглах мөн шаардлага, стандарт тогтоох байдлаар оролцох нь оновчтой юм. Олон улсад төр нь зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж зөвхөн хянан шалгах болон үйл ажиллагаа явуулах шаардлагыг тогтоох эрх үүргийг л авч үлдсэн жишиг түгээмэл байдаг.

Монголбанк 2021 онд нэр бүхий компаниудад зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор анх удаа зээлийн мэдээллийн иж бүрэн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх нөхцөл бодитой бүрдсэн билээ. Зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн хэвшил дангаар гүйцэтгэснээр тавигдах шаардлага, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцлалыг хадгалах, үйл ажиллагааны найдвартай ажиллагаа, мэдээллийг ашиглах нөхцөлийг нарийвчлан тодорхойлж, маргаан шийдвэрлэх процесс ойлгомжтой, иргэн, хуулийн этгээдэд зардал, чирэгдэл учруулахгүй хэлбэрээр явагдах ёстой бөгөөд энэ шинэчлэл нь эдийн засгийн эргэлтийг сайжрах, хөрөнгө оруулалт нэмэгдэх, зээлийн төрөлжсөн бүтээгдэхүүн хөгжихөд ихээхэн түлхэц болно.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нь Монголбанкны үйл ажиллагааны нэг чиглэл байхаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан билээ. Энэ дагуу банк ба банкны харилцагч, хадгаламж эзэмшигч хоорондын харилцааг зохицуулсан хууль, банкны үйл ажиллагаанд тогтоосон стандарт, шаардлагыг Монголбанк мөрдүүлж байгаатай адилаар зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, зээлдэгчийн суурь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан зээлийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн орчинг сайжруулахыг зорилт болгов.

Монгол Улсын санхүүгийн салбар нь банк давамгайлсан бүтэцтэй хэдий ч 2023 оны байдлаар 13 банкнаас гадна 529 банк бус санхүүгийн байгууллага, 191 хадгаламж зээлийн хоршоо, 337 даатгалын компани, 2416 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс банкны салбарын үйлчилгээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг авч үзэхэд Иргэний хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банкны тухай хууль зэрэг хуулиар тус тус зохицуулж байна. Тус хууль тогтоомжид хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар ерөнхий заалтууд байдаг хэдий ч санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой тусгайлсан зохицуулалт бага байдаг.

Санхүүгийн зах зээл тэлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэн хэрэглэгчдийн тоо улам бүр өсөж буй энэ үед зах зээлийн онцлог байдлыг тусгасан нарийвчилсан зохицуулалт хийхгүйгээр худалдаа, үйлчилгээтэй холбоотой нийтлэг хэм хэмжээгээр зохицуулах нь учир дутагдалтай байна. Санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хариуцсан чиглэлийн хүрээнд хэрэгжүүлдгээс Монголбанкны хувьд тогтвортой, үр ашигтай банкны тогтолцоог дэмжих, нэн ялангуяа «системийн» эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд голлон чиглэсэн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн

төлөө газраас “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”, “Зар сурталчилгааны тухай хууль”-ийг хэрэгжилтийг хангах үүрэгтэй ажилладаг. Үүнд, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах үүрэг багтдаг.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хооронд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нэгдсэн зохицуулалтын тогтолцоо байхгүйгээс зарим үүрэг, хариуцлагын давхардал зэрэг шийдвэрлэх шаардлагатай асуудлууд үүсдэг. Мөн санхүүгийн зах зээл дэх хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж уг харилцаанд оролцогчдын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь санхүүгийн зөрчил, гэмт хэрэг багасах, цаашлаад банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

### Стратеги

- Үндэсний төлбөрийн системийн эрх зүй, зохицуулалтын орчны уялдаа холбоог сайжруулах, шинэ инновац, шилдэг технологид суурилсан төлбөр тооцооны хэрэгслийг дэмжиж ажиллах, төлбөрийн системд хяналт тавих замаар найдвартай, тасралтгүй байдлыг ханган санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Зээлийн мэдээллийн тухай хууль нь хувь хүний болон байгууллагын эмзэг мэдээллийг агуулдаг ч нууцлалын байдлыг цогцоор нь шийдвэрлээгүй бөгөөд зээлийн мэдээллийн санд ямар тохиолдолд өөрчлөлт оруулах үндэслэлийг нарийвчлан зохицуулж, зээлийн мэдээллийн санд байгаа мэдээллээр зээлдэгчийн эрсдэлийг оновчтой тооцоолж байгаа эсэхийг тодорхойлж, цаашид Монгол Улс зээлийн мэдээллийн үйл ажиллагааг хувийн хэвшилд бүрэн шилжүүлэх байдлаар эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор мэдээллийн ил тод байдлыг хангасан, санал болгож буй бүтээгдэхүүний мэдээллээ зээлдэгчид урьдчилан мэдэгдэх, хяналтын хуудсыг танилцуулж баталгаажуулж зээлдэгчийг зээлийн нөхцөлтэй танилцах, зөв шийдвэр гаргах боломжийг нь бүрдүүлсэн, маргаан үүссэн нөхцөлд түргэн шуурхай шийдвэрлэх боломжтой эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Үндэсний төлбөрийн системд мөрдөж буй журам, дүрэм, зааварт шаардлагатай өөрчлөлтийг тухай бүр оруулж, зохицуулалтын орчны уялдаа холбоо, давхцалыг арилгахын зэрэгцээ шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжинэ.
- Монголбанк төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд төлбөрийн системийн оролцогчийн цахим мөнгө, операторын шалгалт зэргийг газар дээрх болон зайнаас тавих төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн, хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлын дагуу гэнэтийн шалгалтыг тухай бүр хийнэ.
- Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн хэрэгслээр дамжуулан санхүүгийн хүртээмжийг алслагдсан хөдөө орон нутагт хүргэнэ.
- Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж хууль санаачлагчид уламжлан хамтран ажиллана.

### ЗОРИЛТ 3.2

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх суурь нөхцөлийг бүрдүүлэн дотоодын мөнгөний захыг хөгжүүлнэ.

#### Үндэслэл

Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт өндөр, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдсэнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт 2024 оны эхний улиралд 7.8 хувьтай гарлаа. Дэлхийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр, макро эдийн засгийн ерөнхий үзүүлэлт сайжирч буй өнөөгийн нөхцөлд санхүүгийн зах зээл, тэр дундаа хөрөнгийн зах зээлийн хөгжил чухал асуудал болж байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд хадгалахад санхүүжилтийн эх үүсвэр, техник технологийн сайн туршлагыг нэвтрүүлж, нутагшуулах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Хөрөнгө оруулагчдын өнцгөөс авч үзвэл Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтын өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын эрсдэлээ тараан байршуулах боломжийн нэн тэргүүнд анхаардаг. Төгрөгийн суурь өгөөжийн түвшин тодорхойгүй, зээлийн эрсдэлгүй үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших боломжгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын эрсдэл нэмэгдэж, энэ нь Монгол Улсад хөрөнгө оруулалт хязгаарлагдах нэг хүчин зүйл болдог. Иймд олон улсын жишгийн дагуу мөнгөний захыг<sup>6</sup> хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

<sup>6</sup> Мөнгөний зах буюу хөрвөх чадвар хамгийн сайтай хөрөнгийн зах гэдэгт бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, 1 жилээс доош хугацаатай үнэт цаасны зах зээлийг ойлгоно.


Хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацааг тодорхойлох шийдвэр гаргахад мөнгөний зах дахь төгрөгийн санхүүжилтийн жишиг хүүг юун түрүүнд харгалзан үздэг тул Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг хугацааны олон төрлөөр тогтмол арилжаалснаар тус арилжааны үр дүнд тулгуурлан төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох боломжтой. Энэ нь пүүс, компаниуд өрийн хэрэгсэл гаргахад ашиглах жишиг хэмжүүрийг бий болгож тодорхой бус байдлыг бууруулах, цаашлаад мөнгөний захад оролцогчдын тоог нэмэгдүүлж, зах зээлийг тэлэх замаар олон улсын жишигт нийцсэн мөнгөний захын хөгжлийг дэмждэг.

### ШИГТГЭЭ 3. Хадгаламжийн сертификат

Хадгаламжийн сертификат нь хадгаламж авах эрхтэй байгууллага татан төвлөрүүлсэн эх үүсвэрийнхээ хугацааг тогтвортой байлгах зорилгоор харилцагчдадаа санал болгодог санхүүгийн бүтээгдэхүүн юм. Уг бүтээгдэхүүнийг санхүүгийн зах зээлд худалдан борлуулах, өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх боломжтой бөгөөд хугацаатай хадгаламжтай харьцуулахад хөрвөх чадвар өндөртэй бүтээгдэхүүн юм.

Олон улсын санхүүгийн зах зээл дээр хадгаламжийн сертификатыг уламжлалт, буцаан дуудах боломжтой, өсөн нэмэгдүүлэх, брокерын буюу хоёрдогч зах зээлд арилжаалагдах боломжтой зэргээр төрөлжүүлэн ашигладаг байна. Манай улсад өнөөг хүртэл банкууд зөвхөн уламжлалт хадгаламжийн сертификатыг гаргаж байсан ба 2024 оны 7 дугаар сарын байдлаар байдлаар уламжлалт хадгаламжийн сертификатыг Хаан, Голомт, Худалдаа Хөгжил, Төр, Хас, Капитрон, Ариг банкууд гаргаж байна. Банкны салбарын хадгаламжийн сертификатын дүн өмнөх оны мөн үеэс 60 хувиар буурч 75.7 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 15. Хадгаламжийн сертификат



#### Эрх зүйн зохицуулалтын орчин

- Банкны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 19<sup>1</sup> дүгээр зүйл
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

- *Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль,*
- *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль.*

Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмын нарийвчилсан зохицуулалтыг Төв банк / Монголбанк/ болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран боловсруулахаар ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үнэт цаас хэлбэртэй хадгаламжийн сертификатын зохицуулалтыг тусган батлуулснаар хөрөнгийн зах зээл дээр хадгаламжаар баталгаажсан үнэт цаас хэлбэртэй хадгаламжийн сертификатыг гаргах боломжтой боллоо. Хадгаламжаар баталгаажсан үнэт цаас хэлбэртэй хөрвөх чадвар бүхий хадгаламжийн сертификатыг бий болгосноор дараах давуу талууд үүснэ.



#### Санхүүгийн зах зээлийн хөгжлийн хувьд:

- Хөрөнгийн зах зээл дээр арилжих боломжтой банкны Хадгаламжаар баталгаажсан Үнэт цаас буюу Брокероор дамжих Хадгаламжийн сертификат.



#### Банкуудын хувьд:

- Доорх давуу тал бий болсноор хадгаламжийн хүү буурах,
- Хадгаламжийн хөрвөх чадвар нэмэгдэх тул хугацаатай хадгаламжийн шаардах өгөөж буурах,
- Хөрвөх чадварын эрсдэлийн үнэ (liquidity premium), хугацааны үнэ (maturity premium) буурах,
- Хадгаламжийн сертификатын эрэлт нэмэгдэх тул хадгаламжийн хүү буурах,
- Хадгаламж, зээлийн хугацааны зөрүү (duration gap) буурах
- Хадгаламж хоёрдогч зах зээл дээр харилцагчдын дунд арилжаалагддаг болсноор банкны салбараас эх үүсвэр гэнэт татагдах эрсдэлийг бууруулах,
- Хадгаламжийн хэт төвлөрлөөс үүсэх эрсдэлийг бууруулах
- Банкуудын тусгай нөхцөлтэй хадгаламжийн дарамт буурах,
- Банкуудын одоогийн гаргасан уламжлалт хадгаламжийн сертификатын сул талуудыг арилгах
- Хадгаламжийн хугацаа, эх үүсвэрийн дундаж хугацаа уртсах,
- Банкны эх үүсвэрийн зардал буурснаар зээлийн хүү буурах,
- Бирж дээрх хадгаламжийн сертификатын хүү нь банкны үйл ажиллагааг үнэлэх зах зээлийн индикатор болох боломжтой.



#### Харилцагчдын хувьд:

- Харилцагч хадгаламжаа цуцлах шаардлагагүй болно. Хоёрдогч зах зээл дээр буюу бирж дээр арилжаалан эх үүсвэрээ суллах боломжтой.
- Хоёрдогч зах дээр арилжаалах боломжтой тул заавал богино хугацаат хадгаламж пээлгэх шаардлагагүй.
- Жилийн нэрлэсэн хүүгээр богино хугацааны хуримтлагдсан хүүний орлого олох боломжтой.
- Өөрөөр хэлбэл, жилийн хугацаатай хадгаламжийн сертификатыг 3 сарын дараа худалдвал нэрлэсэн үнэн дээр жилийн хүүний 3 сард хуримтлагдсан хүүгээ нэмж арилжаалах боломжтой



Манай улсын хувьд 2017 оноос ЗГҮЦ-ны арилжаа зогссоноор зах зээл дэх зээлийн эрсдэлгүй санхүүгийн бүтээгдэхүүн нь зөвхөн ТБҮЦ болсон бөгөөд зөвхөн банк хоорондын захад ТБҮЦ арилжаалагдаж байна. Банк хоорондын захын арилжааны дундаж хугацаа урт байх нь санхүүгийн тогтвортой байдлын эхлэл болдог боловч манай улсын мөнгөний зах зээл дэх эрсдэлгүй бүтээгдэхүүний хомс байдлаас шалтгаалан банк хоорондын захын арилжааны дундаж хугацаа сүүлийн жилүүдэд дунджаар 8-10 хоног буюу хэт богино болоод байна. ТБҮЦ нь ихэвчлэн өгөөжийн муруйн богино хугацааны хэсгийг, харин ЗГҮЦ нь өгөөжийн муруйн урт хугацааны хэсгийг бүрдүүлдэг (ОУВС, 2015). Тиймээс ТБҮЦ-ны хугацаа ЗГҮЦ-ны хугацаатай давхцахгүй байх, эсвэл зах зээлд эрэлт багатай ЗГҮЦ-ыг орлохуйц байвал эрсдэлгүй өгөөжийн муруй бүрдэхэд эергээр нөлөөлнө. Энэ тухай Монгол Улсын мөнгөний захын нөхцөл байдлыг дүгнэж, цаашид сайжруулах чиглэлд олон улсын байгууллагын өгсөн зөвлөмжүүдэд “2018 оноос өмнө засгийн газрын бондын өгөөж нь санхүүгийн бүтээгдэхүүний үнийг тогтооход чухал жишиг болж байсан. Харин засгийн газрын үнэт цаасны арилжаа зогссоноор банкнуудад урт хугацаат актив, өр төлбөрийн үнийг тогтооход хүндрэл учруулж байна” хэмээн дурдсан байдаг<sup>7</sup>. Иймд өгөөжийн муруйг бүрдүүлж, мөнгөний зах зээлд үнийн мэдээллийг ил тод болгоход ЗГҮЦ арилжаалахад үнэт цаасны хэмжээ төдийлөн өндөр байх шаардлагагүй бөгөөд арилжааны давтамж тогтмол байх нь нэн тэргүүний зорилт юм. Ийнхүү ЗГҮЦ-ыг нээлттэй тогтмол хуваарийн дагуу арилжаалснаар өрийн дарамт өсөхгүй бөгөөд хоёрдогч захын арилжааны идэвх нэмэгдэх эерэг талтай. Мөнгөний захын дэд бүтэц сайжирч, зах зээлд жишиг хүү болон өгөөжийн муруй бүрэлдсэнээр мөнгөний бодлогын үр нөлөө сайжрах, цаашлаад хөрөнгийн зах зээлийн хөгжилд эергээр нөлөөлнө.

Цаашилбал улс орнуудын хөгжлийн түвшнээс үл хамаарах дэлхийн ихэнх улс орнуудад ихэвчлэн Засгийн газрын үнэт цаас худалдаж авах, хадгаламжийн сертификат худалдан авах эсвэл хамтын санд хөрөнгө оруулах замаар иргэд, аж ахуйн нэгжүүд мөнгөний зах зээлд оролцдог. Гэтэл дотоодын мөнгөний зах зээлд уг хэрэгслүүд үүсэж бэхжээгүйгээс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүд мөнгөний зах зээлд чөлөөтэй оролцох боломж хомс байна. Цаашид санхүүгийн зах зээлд мөнгөний захын төрөл бүрийн хэрэгслүүдийг нэвтрүүлж, арилжааны идэвхийг нэмэгдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжүүд мөнгөний зах зээлд оролцож, богино хугацаат эх үүсвэрийн хэрэгцээгээ хангах, илүүдэл эх үүсвэрээ богино хугацаат хэрэгсэлд байршуулан өгөөж хүртэх боломж бий болох юм.

<sup>7</sup> Money Market Development Framework – Mongolia, EBRD болон OG Research, 2020

## Стратеги

- Олон улсын мөнгөний захын үйл ажиллагааны жишгийг дагаж дотоодын мөнгөний захад арилжаалж буй үнэт цаасны төрөл хугацааг нэмэгдүүлж, улмаар дотоодын зах зээлд төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, оролцогчдыг нэмэгдүүлэх, мөнгөний захын үр ашгийг нэмэгдүүлнэ.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгөний захын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр холбогдох талуудтай хамтран ажиллана.
- Мөнгөний захад ЗГҮЦ-ыг тогтмол арилжаалахад шаардлагатай орчныг бүрдүүлнэ.
- ЗГҮЦ-ны арилжааны үр дүнд бий болох жишиг хүү болон мөнгөний захын мэдээ, мэдээллийг тогтмол давтамжтай олон нийтэд мэдээлнэ.

### ЗОРИЛТ 3.3

Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлж, төв банкны бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллана.

### Үндэслэл

Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлж, улмаар Төв банкны олон нийттэй харилцах харилцааг үр дүнтэй хэрэгжүүлснээр санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, мөнгөний бодлогын шийдвэр гаргахад урьдчилан таамаглах чадварыг нэмэгдүүлэх, Төв банкны макро эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой.

Олон улсад Төв банкнууд нь нээлттэй ил тод байдлыг эрхэмлэж, мөнгөний бодлогын зорилт, стратеги, эдийн засгийн төлөв, бодлогын шийдвэрээ ил тод нээлттэй мэдээлэх байдлаар олон нийттэй харилцах харилцааг бэхжүүлж байна.<sup>8</sup> Ил тод байдлын индексээр өндөр үзүүлэлттэй төв банктай улс орнуудад инфляцыг нам бөгөөд тогтвортой байлгах зорилт илүү амжилттай биелж байжээ.<sup>9</sup> Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь олон улсын жишгийн дагуу хөгжиж, улам боловсронгуй болоход зорьж байна.

Төв банкны олон нийттэй харилцах харилцааны нэг тулгуур зарчим бол зорилтот бүлэг нь санхүү, эдийн засгийн суурь мэдлэгтэй байх явдал юм. Суурь мэдлэгтэй байснаар Төв банк олон нийттэй харилцахад илүү хялбар болж, аливаа өөрчлөлтөд үзүүлэх шокыг бууруулж, Төв банкны бодлого үйл ажиллагаанд итгэх итгэлийг өсгөдөг.<sup>10</sup> Нөгөөтээгүүр, иргэд санхүү, эдийн засгийн мэдлэг, ойлголтоо сайжруулж чадвал нас, хүйс, боловсрол, орлогын түвшин зэргээс үл хамаарч тэдний амьдралын чанарт эерэг өөрчлөлтүүд бий болдог. Учир нь хувь хүнд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг оновчтой сонгох, зөв хэрэглэх мэдлэг, ур чадвар, хандлага тогтсоноор санхүүгийн аливаа эрсдэлээс сэргийлж, мөнгөө зөв удирдаж, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг зохистой сонгох боломж бүрдэх

<sup>8</sup> Blinder A., Ehrmann M., Fratzscher M., De Haan J., and Jansen D. (2008) Central bank communication and monetary policy a survey of theory and evidence. Working paper series 898, European Central Bank.

<sup>9</sup> Cukierman A. (2006). Central Bank Independence and Monetary Policymaking Institutions: Past, Present, and Future,” Working Papers Central Bank of Chile 360, Central Bank of Chile.

<sup>10</sup> Haldane A., Macaulay A., and McMahon M. (2020). “The 3 E’s of central bank communication with the public” Staff Working Paper 847, Central Bank of England.



ба энэ нь цаашлаад банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Манай улсын эдийн засаг тогтворжиж, инфляц Төв банкны зорилтот түвшнийг хангаж, макро орчны үзүүлэлтүүд эерэг үр дүнд хүрсэн ч гадаад орчинд геополитикийн эрсдэлтэй нөхцөл байдал хэвээр хадгалагдсаар байна. Иймээс Монголбанкнаас бодлогын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнд хүрэхийн тулд олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг өргөжүүлж, олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлэх нь зах зээл дэх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, эдийн засагт оролцогчдын хүлээлтийг үр дүнтэй удирдах, эдийн засагт тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

### Стратеги

- Монголбанкнаас батлагдсан “Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх 2024-2030” болон “Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” гэсэн хоёр стратегийн хүрээнд зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Олон нийттэй харилцах үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг өргөжүүлэн чадавхжуулж, Монголбанкны бодлогын шийдвэр гаргалтад эзлэх байр суурийг нэмэгдүүлнэ.
- Төв банканд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийн ил тод нээлттэй байдлыг дотоод харилцаа холбооны уялдаа холбоог бэхжүүлснээр хангана.

## Хэрэгжүүлэх арга хэмжээ

### **Санхүү, эдийн засгийн боловсрол олгох хүрээнд:**

- Зорилтот бүлгүүдэд чиглэсэн арга хэрэгслүүдийн хүртээмжийг нэмэгдүүлж, цахим сургалт, контентуудыг хийж, санхүүгийн боловсролын цахим хуудас болон гар утасны аппликейшныг шинэчилж, сайжруулна.
- Зорилтот бүлэг тус бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцтэй сургагч багш нарыг үргэлжлүүлэх бэлтгэж, банкны харилцагчдын залиланд өртөж байгаа байдлын талаарх судалгааг хийж, гарсан үр дүнд үндэслэн холбогдох талуудтай хамтран нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.
- Бусад төв банкнуудын санхүү, эдийн засгийн мэдлэг түгээх сайн туршлагыг судалж, нэвтрүүлж, залуу үеийн хэрэглээнд нийцсэн мэдээллийн сувгуудыг хөгжүүлэх, контент боловсруулж түгээнэ.

### **Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд:**

- Мөнгөний бодлогын мэдэгдлийг зах зээлд оролцогчид идэвхтэй хүлээн авах хүлээлтийг нэмэгдүүлэхийн тулд түүний ач холбогдол, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг таниулан сурталчлахын зэрэгцээ хүргэж байгаа мэдээллийг энгийн ойлгомжтой байдлаар хүргэнэ.
- Инфляцын тайланг олон нийтэд хүргэх сувгийг өргөжүүлж, инфляцын хүлээлтийн судалгааны үр дүнг тусгаж, олон нийтэд нээлттэй танилцуулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Төв банкны мэдэгдэл, мэдээ мэдээлэл тархаах байдлыг тогтмол болон тухай бүрд гэсэн цаг үед төрийн дээд байгууллага болон эдийн засагт оролцогч бүлгүүдэд зориулан түгээх байдлаар олон нийттэй харилцах сувгийг төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- Монголбанкны олон нийтийн цахим сүлжээн дэх сувгуудын мэдээлэл байршуулах хэлбэр агуулгыг нэгдсэн хэв загварт оруулж, сайжруулах, зорилтот бүлгүүдийг харгалзан цахим сүлжээн дэх сувгийн төрлүүдээ нэмэгдүүлнэ.
- Олон улсын байгууллагуудаас Төв банкны олон нийттэй харилцах харилцааны чиглэлд өгсөн зөвлөмжийн дагуу олон нийттэй харилцах үйл ажиллагааг өргөжүүлэн, төрөлжүүлж, шуурхай хүртээмжтэй байдлыг хангана.

## ЗОРИЛТ 3.4

Жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлнэ.

### Үндэслэл

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь жижиг, дунд бизнес /ЖДБ/-ийн санхүүгийн хүртээмжийг сайжруулна. ЖДБ-ийн хувьд санхүүгийн хүртээмж муу санхүүжилтийн дутагдалтай байхад барьцаа хөрөнгийн дутагдал, бизнесийн эрсдэл өндөр, санхүүгийн мэдлэг боловсрол хангалттай биш зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Харин банк, санхүүгийн байгууллагуудаас бизнес эрхлэгч, аж ахуй нэгжүүдийн хувьд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн санхүүжилт олгохдоо ихэвчлэн үл хөдлөх барьцаалах замаар олгож байна.

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь ирээдүйд орж ирэх орлого /авлага/, тоног төхөөрөмж, бараа материал, бараа материалын агуулахын үлдэгдэл зэрэг хөдлөх хөрөнгө барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл, санхүүжилт олгодог байна. Энэ нь жижиг дунд, бизнес эрхлэгчээс гадна худалдан авагч аж ахуйн нэгж, байгууллагын зээл төлөх чадвар дээр үндэслэн богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүжилт олгож буй шинэлэг аргачлал билээ. Түүнчлэн, барьцаа хөрөнгийн хүндрэлийг шийдвэрлэхээс гадна ханган нийлүүлэгчдийн хувьд худалдан авагч талын санхүүгийн чадавх болон худалдан авах гэрээ, төлөх төлбөр зэрэгт үндэслэн худалдан авагч талуудын санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлдэг. Энэ утгаараа бүтээгдэхүүн үйлчилгээ нь нэмэгдсэнээр санхүүгийн зах зээл болон бодит эдийн засгийн хоорондох харилцаа, хамаарал гүнзгийрч аж ахуйн нэгж болон санхүүгийн байгууллагуудад хамтын өсөлтийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой. Санхүүжилт олгогч санхүүгийн байгууллагуудын хувьд зээлийн эрсдэл буурахаас гадна зээлдэгч талын хувьд борлуулалтын эрсдэл буурч, бизнес нь тэлэх бололцоо бүрддэг.

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь сүүлийн үед дотоодын болон олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд өргөнөөр ашиглагдаж, ач холбогдол нь улам нэмэгдэж байна. Иймд тус санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, энэ төрлийн санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг стандартчилж, тэдгээрийг ашиглах хууль эрх зүйн орчин болон дэд бүтцийн таатай орчныг бүрдүүлснээр санхүүгийн байгууллагуудад инновац эрчимжиж, бүтээгдэхүүний төрөл олширсноор санхүүгийн салбар өргөжин тэлж, хүртээмж нь нэмэгдэхийн хэрээр зээл олголт нэмэгдэх, зээлийн хүүгийн түвшин буурах эерэг нөлөөтэй билээ.

Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага болох Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хөгжүүлэх төслийн хүрээнд Монголбанк харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Энэ хүрээнд нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг санхүүгийн зах зээлд таниулан сурталчлах, тулгарч буй бэрхшээлүүдэд авах арга хэмжээний саналыг тодорхойлж, оролцогч талуудтай хамтран ажиллаж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхээр зорьж байна.

## Стратеги

- Монгол Улсын санхүүгийн салбарт нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хөгжүүлэх хүрээнд бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талуудыг хамруулсан ажлын хэсэг байгуулж, тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Монгол Улсын санхүүгийн салбарт нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хөгжүүлэх хүрээнд бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бүхий замын зураг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн дэд бүтцийг бий болгохтой холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн стандарт, активын ангиллын зохицуулалтад өөрчлөлт оруулах талаар холбогдох зохицуулалтуудыг судалж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- Зээлдэгч, зээлдүүлэгчээс гадна үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгч зэрэг олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийж, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцооны талаар олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулна.

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2024 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 99 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

(2024 оны 2 дугаар улирлын байдлаар)

### **2.1. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;**

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 99 дүгээр тогтоолоор ТМБТБҮЧ-2024 баталсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-246 дугаар тушаалаар “Банканд ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зээл олгох түр журам”-ыг баталсан. Тус ажлын хүрээнд Монголбанк, банкнууд, МИК ОССК ХХК-ийн хооронд 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан бөгөөд Монголбанк, банкнуудын хооронд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-г мөн шинэчлэн байгуулж хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанк өөрийн эзэмшлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын эргэн төлөлтөөр хэвийн үргэлжлүүлж байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийг баталж, 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хурлаар “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тус тогтоолд хуримтлалын санд 499.5 тэрбум хүртэл төгрөгийг төвлөрүүлж, төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт Монголбанкаар дамжуулан хөрөнгө оруулахаар заасан. Тогтоолын хүрээнд Сангийн яам, Монголбанк хооронд 81, 0524/171 дугаартай “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

Хөтөлбөрийн хүрээнд 2024 оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар Монголбанк болон банкнуудын эх үүсвэрээр нийт 760.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 6.6 мянган өрхөд олгоод байна.

### **2.2. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах;**

Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онуудад олгосон нийт зээлийн дүнгийн дунджаар 17 хувийг, нийт олгосон зээлийн тоогоор дунджаар 25 хувийг орон нутагт олгосон бол 2023 онд 932.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 8.9 мянган өрхөд олгосноос 32 хувийг буюу 302.6 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 3.7 мянган өрхөд олгосон. Засгийн газраас Улаанбаатар хот руу чиглэх шилжилт хөдөлгөөнийг саармагжуулах, орон нутгийн хөгжлийг дэмжих зэрэг зорилгын хүрээнд хэрэгжүүлж байгаа 3 хувийн хүүгийн татаастай зээлийг 1/ Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж буй өрх, 2/ орон нутагт анх удаа орон сууц худалдан авч буй өрхөд олгож байна. Оны эхнээс Засгийн газраас хэрэгжүүлж буй 3 хувийн хүүгийн татаастай нийт 200 орчим тэрбум төгрөгийн зээлийг 2 мянган орчим зээлдэгчид олгожээ.

Харин 2024 онд хөтөлбөрийн зээлийн эхүүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах ажлын хүрээнд орон нутагт олгох хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд хоёрдугаар улирлын эцсийн байдлаар олгосон нийт зээлийн 44 хувь буюу 331.3 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 3.3 мянган өрх (нийт олгосон зээлийн өрхийн тооны 50 хувь)-д олгосон байна.

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2024 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ


(2024 оны 2 дугаар улирлын тайлан)

### 1. МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:


**1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувь орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.**

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц үргэлжлэн буурч 2024 оны 5 дугаар сард 5.7 хувь буюу зорилтын голчийн орчимд хүрлээ (Зураг 16). Үүнд, дотоодын хүнсний үнийн суурь үеийн нөлөө болон импортын барааны үнэ харьцангуй тогтвортой байгаа нь нөлөөлөв. Гэхдээ, гадаад орчны тодорхой бус байдал буураагүйн зэрэгцээ Тяньжин боомтод чингэлгийн тоо ихсэж байгаа нь инфляцын дарамт үүсэх эрсдэл болж байна.

Зураг 16. Улс болон УБ хотын инфляц



Зураг 17. Улсын жилийн инфляц (бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Инфляцын хөдөлгөөнийг бүлгүүдээр задлан тайлбарлавал (Зураг 17):

- Импортын барааны инфляц<sup>11</sup> 5 дугаар сард 4.3 хувьд хүрч, нийт инфляцад үзүүлэх нөлөө I улирлаас 0.4 нэгж хувиар бууран 2.0 нэгж хувь боллоо. Төгрөгийн ханш тогтворжиж, худалдааны голлох түншүүдийн инфляц саарсан зэрэг нь гадаад шалтгаантай инфляцын дарамтыг бууруулав. Ийнхүү импортын барааны инфляцад үзүүлэх нөлөө сүүлийн 3 жилийн хамгийн бага түвшинд хүрээд байна.
- Үйлчилгээний<sup>12</sup> үнэ жилийн 6.7 хувиар өсөж, инфляцад өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар бага буюу 1.0 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Дэлгэрүүлбэл, онгоцны тийзийн үнэ хямдарсан болон нийтийн хоолны үйлчилгээ өнгөрсөн жилтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байгаа зэрэг голлон нөлөөлөв.

<sup>11</sup> Импортын хүнс, шатахуун импортын бараа зэргийг багтаасан.

<sup>12</sup> Төрийн зохицуулалттай үйлчилгээг хассан.

- Дотоодын хүнсний үнийн жилийн өсөлт өмнөх улирлаас 4.7 хувиар буурч 8.3 хувьд хүрчээ. Үүнд, өнгөрсөн оны мөн үед гурил, махны үнэ өндөр өссөн суурь үе нөлөөлж байна.
- АИ-92, 95 шатахууны үнэ тогвортой байгаа бол дизель түлш 5-р сард 200 төгрөгөөр хямдарч, шатахууны бүлэг нийт инфляцад 0.1 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв.

*Хүснэгт 1. Инфляцад хамгийн өндөр нөлөөтэй 20 бүтээгдэхүүн, 2024 оны 5 дугаар сар<sup>13</sup>*

	Бүлэг	Бүтээгдэхүүн	Жилийн өсөлт	Инфляцад үзүүлэх нөлөө	Инфляцад эзлэх хувь
1	Импортын бараа	Эмэгтэй хүний нүүрний шингэн энгэсэг, “VDL”, Солонгос	28.1%	0.4%	40.0%
2	Дотоодын хүнс	Хонины мах, ястай, 1 кг	3.7%	0.3%	
3	Үйлчилгээ	Улсын их, дээд сургуулийн сургалтын төлбөр, 1-р дамжаа, 1 жил	12.4%	0.3%	
4	Дотоодын хүнс	Гурил, 1-р зэрэг, савласан, “Алтан тариа”, 1 кг, Монгол	15.1%	0.3%	
5	Үйлчилгээ	Хувийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр, 1-р дамжаа, 1 жил	26.7%	0.2%	
6	Импортын бараа	Параденк, хүүхдийн лаа, 250 мг, 1 ш, Герман	21.9%	0.2%	
7	Дотоодын хүнс	Талх, зүсээгүй, ууттай, “Атар талх”, 600 гр, 1 ш, Монгол	14.1%	0.2%	
8	Дотоодын хүнс	Сүү, үнээний, задгай, 1 л	11.1%	0.2%	
9	Дотоодын бараа	Түлшний мод, шуудайтай, 1 шуудай	12.8%	0.1%	
10	Дотоодын хүнс	Өндөг, “Түмэн шувуут, Баян”, 1 ш, энгийн, Монгол	20.6%	0.1%	
11	Дотоодын хүнс	Гуанзны хоолны үнэ, /цуйван/	16.6%	0.1%	
12	Дотоодын хүнс	Үхрийн мах, ястай, 1 кг	4.7%	0.1%	
13	Дотоодын хүнс	Гурилан боов, ууттай, Аймгийн үйлдвэр, 1 кг, Монгол	12.7%	0.1%	
14	Үйлчилгээ	Хувийн бага сургуулийн сургалтын төлбөр, 1 жил	30.1%	0.1%	
15	Дотоодын хүнс	Талх, ууттай, “Хөх тарианы хар талх “ 300 гр, 1 ш, Монгол	23.9%	0.1%	
16	Дотоодын хүнс	Гурилан боов, ууттай, “Зүсмэл”, 900 гр, Монгол	6.9%	0.1%	
17	Үйлчилгээ	Хувийн дунд сургуулийн сургалтын төлбөр, 1 жил	18.3%	0.1%	
18	Дотоодын хүнс	Төмс, 1кг, Монгол	11.0%	0.1%	
19	Дотоодын хүнс	Үхрийн мах, гуяны цул, 1 кг	2.6%	0.1%	
20	Дотоодын хүнс	Элсэн чихэр, ууттай “Заан”, 1 кг, импорт	30.8%	0.1%	
<b>ДЭЭРХ 20 БҮТЭЭГДЭХҮҮН</b>		<b>Хүнс /13 бүтээгдэхүүн/</b>		<b>1.9%</b>	<b>57.6%</b>
		<b>Хүнс бус /7 бүтээгдэхүүн/</b>	<b>1.4%</b>		
<b>БУСАД 390 БҮТЭЭГДЭХҮҮН</b>				<b>2.4%</b>	<b>42.4%</b>
<b>НИЙТ ИНФЛЯЦ</b>				<b>5.7%</b>	

Эх сурвалж: УСХ

**Мөнгөний бодлогын шийдвэр**

- Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 12 хувьд хүргэх, малчны эргэн төлөлт нь доголдсон зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах боломжийг банкнуудад олгох шийдвэрийг гаргалаа. Гадаад шалтгаантай үнийн дарамтууд багасан инфляц буурах хандлага үргэлжилж байгаа орчинд мөнгөний бодлогын төлөв удаан хугацаанд хатуу хэвээр хадгалагдах нь эх үүсвэрийн хүү, зээлийн нийлүүлэлтээр дамжин хувийн хөрөнгө оруулалтыг сааруулах, дунд, урт хугацааны тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг. Түүнчлэн орон нутагт өвөлжилт,

<sup>13</sup> Мах, гурил, сүү, хүнсний ногоотой холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг улаан өнгөөр тэмдэглэв.



хаваржилт хүндэрсний улмаас малчдын зээлийн эргэн төлөлт доголдох, төлбөрийн чадварын хүндрэлд орох эрсдэл нэмэгдсэн байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан инфляцыг дунд хугацаанд тогтворжуулж, эдийн засаг, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Мөнгөний бодлогын хороо дээрх бодлогын шийдвэрүүдийг гаргалаа.

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 11 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. Импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарч, өнгөрсөн онд өндөр өсөлттэй байсан импортын болон дотоодын хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжиж байгаа нь инфляц буурахад голлон нөлөөлөв. Харин зудын нөхцөл байдал хүндэрч, хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжлэн эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс удаашрах хандлагатай болсон. Иймд улирлын шинж чанартай ажилладаг эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагаа идэвхждэг улиралд санхүүгийн нөхцлийг сулруулж, бодит эдийн засгийг дэмжих, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах зорилгоор бодлогын хүүг бууруулахаар шийдвэрлэв.
- Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2 дугаар улирлын ээлжит хурал 2024 оны 6 дугаар сарын 25, 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд хуралдаж, бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргав. Инфляц буурах хандлага үргэлжилж, энэ оны инфляцын төсөөллийг өмнөхөөс бууруулсан хэдий ч ирэх онд дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, гадаад үнүүд өсөх зэрэг нөлөөгөөр инфляц алгуур нэмэгдэж, зорилтын дээд интервалын орчимд хэлбэлзэхээр байв. Мөн гадаад суурь хүү буурах хугацаа хойшилж, геополитикийн нөхцөл байдал, олон улсын зөрчилдөөн зэрэгтэй холбоотой гадаад суурь эрсдэлүүд хадгалагдсан хэвээр байгаа нь бодлогын хүүг хэвээр хадгалах шаардлагыг нэмэгдүүллээ. Энэхүү шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэй болно.

## **1.2. Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоог бэхжүүлж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, нөхцөлүүдийг сайжруулна.**

Төв банкны бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчныг судалж, шаардлагатай өөрчлөлтийг боловсруулах ажлыг Монголбанкны холбогдох газрууд хамтран хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд Монголбанкны үндсэн зорилтыг “үнийн тогтвортой байдал” болгон өөрчлөх агуулгаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны А-26 тоот тушаалаар байгууллаа. Ажлын хэсгийн уулзалтуудаар хуулийн төслийг шинэчлэхтэй холбоотой шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж, хуулийн төслийн шинэчилсэн хувилбарыг боловсруулсан ба хуулийн төсөлд тавигддаг шаардлагын дагуу тандан судалгаа, зардал, үзэл баримтлал, танилцуулга зэрэг баримт бичгийг боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн экспортоос өндөр хамааралтай, далайд гарцгүй, пост-коммунист орон тул эдгээр онцлох шинж чанараар нь дэлхийн 194 орныг хамруулсан тандан судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүн дотроо, дээрх улсууд нь эдийн

засгийн бүтэц, онцлогоосоо хамааран аль төрлийн мөнгөний бодлогын арга хэлбэр, валютын ханшийн дэглэмийг түлхүү баримталж байгаа болон төв банкны үндсэн зорилт нь хэрхэн тодорхойлогдож, хуулиндаа хэрхэн тусгасан байдлыг судаллаа. Энэхүү харьцуулсан судалгааны үр дүнг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, холбогдох санал, зөвлөмжийн дагуу засвар, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн “Инфляцын хүлээлтийн аргамжаа (anchoring) ба инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа” ажлын хүрээнд инфляцын хүлээлт, түүний ач холбогдлын талаарх онол, арга зүй болон түүвэр судалгаа, асуулгын талаарх олон улсын туршлагыг судалсан ба Монгол Улсын хувьд инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны асуулга болон түүврийн тоо зэргийг хэрхэн оновчтой байлгах талаар судалж байна.

### **1.3. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.**

Хэрэглээний зээлийн өсөлт, өрхийн өрийн дарамтыг тогтмол хянах ажлын хүрээнд банкнуудын зээлийн тайлан болон өр, орлогын харьцааны сарын мэдээнд үндэслэн хэрэглээний зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг судлан бодлогын шийдвэр гарган ажиллаж байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 4 дүгээр улирлын ээлжит хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу банкнаас иргэдэд 6 сараас дээш хугацаатай олгосон эсхүл зээлийн сарын төлбөрөө төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих түвшнээс бага байх тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 150 хувь болгон нэмэгдүүлж, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж эхлээд байна.

Түүнчлэн, 2024 он гарсаар орон нутагт өвөлжилт, хаваржилт хүндэрч, малын зүй бус хорогдлын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглээний зээлийн том бүрдэл хэсэг болох малчны зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч болзошгүй боллоо. Тухайлбал, банкны салбар дахь малчны зээлийн үлдэгдэл 2024 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөг буюу хэрэглээний зээлийн үлдэгдлийн 14.6 хувийг бүрдүүлж байна. Үүнтэй холбогдуулан эргэн төлөлт хүндэрсэн малчны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, бүтцийн өөрчлөлт хийх боломжийн талаар судалж Мөнгөний бодлогын хорооны 1-р улирлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн дараах шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:

1. 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө олгосон, эргэн төлөлт нь доголдсон малчны зээлийн хувьд үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар, зээлийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр, нэг удаа сунгахыг банкнуудад зөвшөөрөх;
2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зээлийн ангиллыг хэвээр үлдээх, холбогдох зээлүүдийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй өр, орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалтыг арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд түр түдгэлзүүлэх;
3. Арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэх;

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг дагаад 2023 оноос эхлэн банкны салбарын хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, 2024 оны 5 дугаар сарын байдлаар 10.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 38.4 хувиар өсөөд байна. Иймд банкны хэрэглээний зээлийн хязгаарлалтыг чангатгах чиглэлд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2

дугаар улирлын ээлжит хуралдаанаар банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 55 хувь болгон бууруулах шийдвэрийг гаргав.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний зориулалтыг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр өргөтгөж, зээлдэгчид тавьж байгаа зарим нөхцөл, шаардлагыг сулруулан, ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж байна.

#### **1.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.**

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож байна. Нүүрсний экспортын орлого өндөр хэвээр хадгалагдаж, гадаад валютын орох урсгал нэмэгдсэнээр 2024 оны 2 дугаар улиралд гадаад валютын ханш чангарахад эерэг нөлөө үзүүлээ. 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монголбанк оны эхнээс нийт 52 удаагийн гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан цэвэр дүнгээр 2,992.1 сая ам.доллар нийлүүлсэн. Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 3,111.4 сая ам.долларыг худалдан авч, цэвэр дүнгээр 119.3 сая ам.долларыг гадаад валютын дотоодын заххаас худалдан авав. Түүнчлэн тус хугацаанд Монголбанк банкнуудтай 8.0 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн своп хэлцэл, 24 сая ам.долларын богино хугацаат своп хэлцэл, 621.1 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг тус тус байгуулсан байна. Улмаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 3381.05 төгрөгт хүрч, оны эхнээс 29.67 төгрөг буюу 0.87%-аар, өмнөх оны мөн үеэс 51.09 төгрөг буюу 1.49%-аар тус тус чангарлаа.

#### **1.5. Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой оновчтой хослуулан хэрэгжүүлнэ.**

Монголбанк нь санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг гүйцэтгэхэд өмнө ашиглаж байсан арга, техникүүдийг сайжруулан шинжлэхийн зэрэгцээ шинэ төрлийн арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Тухайлбал, системийн эрсдэлийн зураглал (heatmap) болон санхүүгийн мөчлөгийг улирал бүр шинэчлэн тооцож, зээлийн мэдээллийн сан болон өрхийн секторын микро тоон мэдээллийг ашиглан шинжилгээ хийж, банкны системийн эрсдэлийг тогтмол хянаж байна. Банкны системийн нөхцөл байдлыг шинжилж, үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох шинжилгээний аргачлал, индикаторуудыг олон улсын туршлагад нийцүүлэн хөгжүүлж, бодлогын шийдвэр гаргалтад нэвтрүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, зорилтот төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж

буй төслийн хүрээнд системийн эрсдэлийн үнэлгээний цогц загварын эхний 5 модуль болох Макро эрсдэлт хүчин зүйлсийн модуль, Банкны ашиг, алдагдлын модуль, Дефолт халдварын модуль, Санхүүжилтийн эх үүсвэрийн халдварын модуль болон Олон үет модулиудыг хөгжүүлээд байна. Ингэснээр банкны салбарын ашиг, алдагдалд нөлөөлөгч макро-санхүүгийн голлох үзүүлэлтүүдийн нөхцөлт бус болон нөхцөлт төсөөллийг гүйцэтгэж, улмаар банкны ашиг, алдагдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөхийг шинжлэх боломжтой болсон. Цаашлаад, тухайлсан банкны ашиг, алдагдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний дутагдал, дампуурал зэрэг нь системийн бусад банкнуудад дефолт халдварлал болон санхүүжилтийн эх үүсвэрийн халдварлалаар дамжин хэрхэн нөлөөлөхийг тооцоолж, банкны системийн эрсдэлийг цогц байдлаар үнэлэх боломж бүрдэв. Тус загварын дараагийн 2 модуль буюу системийн эрсдэлийн үнэлгээний модулийг хөгжүүлэх, бодлогын шинжилгээний аргачлал боловсруулах ажлуудыг тус төслийн гэрээнд нэмж тусгаж, хэрэгжүүлэхээр АХБ-тай хамтран ажиллаж байна.

2024 оны макро-санхүүгийн орчинд гарч болзошгүй өөрчлөлтүүд нь банкнуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх хүлээлттэй байгаа, эрсдэлийн цаашдын төлөвийг тодорхойлох зорилгоор Монголбанкнаас “Арилжааны банкнуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г 2024.02.05-02.19-ний хооронд 6 дахь жилдээ зохион байгууллаа. Тус судалгааг арилжааны 12 банкны эрсдэлийн удирдлага эрхэлсэн удирдах албан тушаалтнуудаас асуулгын аргаар авч, судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулав. Энэхүү судалгааны үр дүн нь системийн эрсдэлээс урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн бодлогын шинжилгээнд ашиглагдах ач холбогдолтой бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын тайланд үүний гол үр дүнг тусгаж, олон нийтэд танилцуулна.

Түүнчлэн, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын иргэдийн зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өсөж, тэр дундаа цахим хэтэвч, аппликэйшний (финтек) зээл олголт ихээхэн нэмэгдэж байгаа нь өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх, бага дүнтэй финтек зээлийн ангиллын өөрчлөлтийн мэдээлэл Монголбанкны Зээлийн мэдээллийн санд өндөр давтамжтай орсноор иргэдийн банкнаас зээл авах боломж хаагдах, хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл учирч болзошгүй байна. Үүнтэй холбогдуулан Зээлийн мэдээллийн сангийн тоон өгөгдлийг нэгтгэн боловсруулж, холбогдох тооцоолол, шинжилгээг хийж гүйцэтгэв.

Монгол улсад банкны гадаад валютын хадгаламжийн харьцангуй өгөөж төгрөгийн өгөөжөөс доогуур байгаагийн зэрэгцээ олон улсад эрсдэлгүй хүүгийн түвшин өндөр хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд дотоодын банкнуудын эх үүсвэрийн зардлыг багасгах, өрсөлдөх чадварыг дэмжих, валютын эх үүсвэр гадагшлахаас сэргийлэх зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2 дугаар улирлын ээлжит хуралдаанаар банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 хувиар бууруулж, 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргав.

## **1.6. Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоонд нийцтэй байдлаар Төв банкны олон нийттэй харилцах харилцааг боловсронгуй болгоно.**

*1.6.1 Зах зээлд оролцогчдыг мэдээллээр хангаж, мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд:*

Мөнгөний бодлогын шийдвэр болон цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг Монголбанкны

цахим хуудас болон нийгмийн цахим сүлжээний сувгуудаар тухай бүр олон нийтэд түгээж ажиллав. Үүнд:

- Мөнгөний бодлогын хорооны II улирлын хуралдааны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг зохион байгуулж, мэдэгдлийг цахим хуудсанд шуурхай байршуулав.
- Монголбанкны цахим хуудас болон нийгмийн цахим сүлжээний сувгуудаар цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг II улиралд 36, эхний хагас жилд 59 удаагийн давтамжтайгаар олон нийтэд хүргэж, мөн нийгмийн цахим сүлжээний сувгуудаар түгээв. Шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээллийг албан сувгаас гадна хамтран ажилладаг цахим сайт, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.
- Монголбанкны албан эх сурвалж буюу газар, хэлтсийн захирлуудын ярилцлагыг цахим хуудсанд II улиралд 4 удаа, эхний хоёр улирлын нийлбэрээр 8 удаа нийтлэв.
- Бусад хэвлэл, мэдээллийнхний хүсэлтээр Монголбанкны газар, хэлтсийн захирал болон бусад холбогдох мэргэжилтнүүд II улиралд нийт 5 удаа, оны эхнээс 11 удаа хэвлэлд ярилцлага өгөв.

*1.6.2 Монголбанкны хэвлэлийн хурлыг зохион байгуулах болон статистик, тайлан, товхимлыг олон нийтэд түгээх хүрээнд*

- Монголбанкнаас сар тутам сарын статистик мэдээллийг танилцуулах хэвлэлийн хурлыг II улиралд 1 удаа, оны эхнээс нийт 3 удаа зохион байгуулав. Хэвлэлийн хурлаар сарын статистик мэдээллийг танилцуулахаас гадна цаг үеийн асуудлаарх сэтгүүлчдийн асуултад хариулж, мэдээ, мэдээллийг хүргэв.
- Монголбанкны судалгаа, статистикийн мэдээлэл, статистикийн тайлан, товхимол, инфляцын тайлан, хэвлэмэл бүтээгдэхүүн зэргийг тухай бүр цахим хуудсанд байршуулж, ажиллав.

*1.6.3 Монголбанкны нийгмийн цахим сүлжээний сувгуудыг хөгжүүлэх хүрээнд:*

Монголбанкны албан ёсны нийгмийн цахим сүлжээний сувгууд болох фэйсбүүк, инстаграм, youtube, твиттер хаягуудыг тухай бүр мэдээллээр баяжуулж ажиллав. Мэдээ мэдээллийг нийгмийн цахим сүлжээний сувгуудаар хүргэхдээ видео мэдээлэл буюу рийл, постер зэргийг ашиглан энгийн ойлгомжтой, богино хугацаанд хүргэхэд анхаарч ажиллаж байна.

*1.6.4 Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд:*

Монголбанкны УТГ-ын Хэвлэл, мэдээллийн алба нь хэвлэл, мэдээллийн байгууллагууд, тэр дундаа эдийн засгийн мэдээ, мэдээллийг түлхүү хүргэж буй телевиз, сонин, мэдээллийн сайтуудтай хамтран ажиллаж, мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үүнд, МҮОНТ-ийн “Эдийн засгийн тойм”, Ийгл ТВ-ийн “Тоон тойм” зэрэг хандалт ихтэй хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, Монголбанкны удирдлагуудын ярилцлагыг нийлүүлж, олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэж байна.

*1.6.5 Инфляцыг онилох, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлэх хүрээнд:*

Монголбанкнаас хэрэгжүүлж буй инфляцыг онилох, хүлээлтийг удирдах бодлогын нэн

чухал хэрэгсэл нь инфляцын тайлан болдог. Энэ утгаараа инфляцын тайланд буй мэдээ, мэдээлэл, эдийн засгийн төлөв, төсөөллийг олон нийтэд тухай бүр, энгийн ойлгомжтойгоор хүргэхэд анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд 2023.I улирлын инфляцын тайлангийн дугаараас нийтдээ 7 рийл буюу богино хэмжээний видеог Мөнгөний бодлогын газартай хамтран бэлтгэж, Монголбанкны албан ёсны нийгмийн цахим сүлжээний хаягуудаар олон нийтэд түгээж ажиллав. Тайлант хугацаанд II улирлын инфляцын тайлан нийтлэгдээгүй байгаа тул рийл буюу богино хэмжээний видео хийгээгүй байна.

Эхний 6 сарын байдлаар сар тутмын инфляцын задаргаагаар нийт 5 удаагийн постер бэлтгэж, Монголбанкны албан ёсны нийгмийн цахим сүлжээний хаягуудаар түгээв. Монголбанкны сар тутмын болон мөнгөний бодлогын хорооны ээлжит хэвлэлийн хурлын үеэр гарсан инфляц, эдийн засгийн төсөөллийн талаарх Монголбанкны удирдлагуудын онцлох байр суурийг рийл буюу богино хэмжээний видео болон постер хэлбэрээр бэлтгэн, албан ёсны нийгмийн цахим сүлжээний хаягуудаар түгээв.

## 2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

### 2.1. Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангана.

Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангах үндсэн чиглэлийн хүрээнд гадаадын банк Монгол Улсад нэвтрэх боломж, эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлогын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Гадаадын банк нь Монгол Улсад охин компани үүсгэн байгуулах, салбар, төлөөлөгчийн газар нээх хэлбэрүүдээр нэвтрэх боломжтой. Гадаадын банк охин компани байгуулах замаар Монгол Улсад үйл ажиллагаагаа эрхлэх боломж нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах явдал юм. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А-164/386 дугаар хамтарсан тушаалаар дараах журам, шийдвэрийг боловсруулж, батлаад байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг тогтоох тухай хамтарсан тушаал.

Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А-263 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 200 тэрбум төгрөгөөр тогтоогоод байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд Монголбанкны төлөөлөл «Санхүүгийн үйлчилгээ» бүлгийн дэд хэсэгт ажиллаж байна. Уг Засгийн газар хоорондын хэлэлцээрээр тус улсын банк Монгол Улсын зах зээлд нэвтрэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох болно. Мөн Олон улсын санхүүгийн төвийн тухай хуулийн төслийн талаарх саналаа Монголбанкаас Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанд хүргүүлсэн. Энэхүү хууль батлагдсанаар гадаадын банк Монгол Улсад санхүүгийн тусгай дэглэм бүхий бүсэд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх юм.

Дээрх ажлын хүрээнд “Гадаадын банкны салбарын дотоодын санхүүгийн салбар, эдийн засагт үзүүлэх нөлөө” сэдэвт судалгааны ажлыг 2024 оны 1-2-р улиралд хийж гүйцэтгэлээ. Судалгааны ажилдаа олон улс болон Монгол Улсад хийгдсэн судалгааны ажилтай танилцан, гадаадын банкны дотоодын зах зээлд нэвтрэх боломжит сувгууд, тэдгээрийн онцлогийн талаар судалсан болно. Өнөөгийн байдлаар манай орны хувьд гадаадын банк салбар нэгжээ байгуулсан туршлага байхгүй тул эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, гадаадын банк дотоодын банканд хувь эзэмших (takeover) хэлбэрийг төлөөлүүлэн

авч үзлээ. Тоон шинжилгээ хийхэд гадаадын банкны хувь эзэмшлийн өгөгдлийг Van Horen судлаачийн тооцоолсноор авч ашигласан болно. Цаашлаад 1995-2022 оны улс орнуудын панел өгөгдөлд суурилан тухайн банкны гадаад хувь эзэмшил өөрчлөгдсөнөөр эдийн засаг, санхүүгийн салбар, банкны салбарын ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг POLS (pooled ordinary least squares) аргачлалын тусламжтай шинжлэв. Судалгааны үр дүнд нийт түүврийн хувьд эдийн засгийн өсөлт (ДНБ-ий жилийн өсөлт)-д инфляцын түвшин, ГШХО-ын цэвэр орох урсгалын өсөлт, хүн амын өсөлт, Засгийн газрын зардлын өсөлт, ажилгүйдлийн түвшин, банкны салбарын гадаад эзэмшлийн хувь нь ач холбогдолтой нөлөө үзүүлж байна. Тухайлбал, гадаад эзэмшлийн хувь 1 нэгж хувиар өсөхөд эдийн засгийн өсөлт 0.014 нэгж хувиар нэмэгдэнэ. Харин түүврийг улс орнуудын орлогын ангиллаар хуваан авч үзвэл энэхүү нөлөө өндөр орлоготой орнуудын хувьд 0.016 нэгж хувь байгаа бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж байна. Дунджаас дээгүүр болон доогуур орлоготой орнуудад тус нөлөө эерэг, бага орлоготой орнуудад сөрөг утгатай байгаа ч статистикийн хувьд ач холбогдолгүй үр дүн гарлаа. Санхүүгийн салбарын өсөлтийг судлагдсан байдалд үндэслэн хувийн секторт олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн авч үзлээ. Шинжилгээний үр дүнгээс харахад банкны салбарын гадаад эзэмшлийн хувь өссөнөөр бага орлоготой ангиллаас бусад ангилалд багтсан орнуудад хувийн секторын зээлийн ДНБ-д эзлэх хувийг бууруулдаг байна. Тус үр дүн нь Polovina & Peasnell (2023), Claeys & Hainz (2017) зэрэг судалгааны үр дүнтэй нийцтэй.

## **2.2. Банкнуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох эрсдэлийг дотооддоо үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.**

Монголбанкнаас банкнуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсээр байна. Энэ хүрээнд олон улсын хяналт шалгалтын Базел стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлал, хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг банкнуудын болон банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд туршилтын байдлаар нэвтрүүлж, манай улсын банкны системийн онцлогт нийцүүлэн нутагшуулах ажлыг гүйцэтгэж байна.

Тодруулбал, Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд 2024 оны 1 дүгээр улиралд ICAAP, ILAAP-н журмын төслийг шинэчлэн боловсруулж, SREP-н хүрээнд хяналт шалгалтын арга хэмжээ авах журмын төсөл болон эдгээр аргачлалуудыг шат дараатайгаар нэвтрүүлэх дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх ажлын зураглалыг боловсруулсан. Түүнчлэн банкнуудын боловсруулсан ICAAP, ILAAP-н туршилтын тайланг Монголбанк SREP-н дагуу үнэлж, үр дүнг банкнуудад танилцуулсан. Энэхүү туршилтын хугацаанд Монголбанк болон банкнууд холбогдох аргачлалыг боловсруулах, хүний нөөцийг чадавхжуулах болон хяналт шалгалтын үнэлгээ, арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэх хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байна.

ICAAP, ILAAP-н шинэчлэн боловсруулсан журмын төслийг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А-18/307 тоот албан бичгээр банкнуудад хүргүүлсэн бөгөөд үүний дагуу банкнууд 2023 оны эцсийн байдлаарх ICAAP, ILAAP-н туршилтын тайланг



Монголбанканд ирүүлээд байна. Цаашид банкнуудын 2023 оны тайланг SREP-н дагуу үнэлэх, ICAAP, ILAAP-н журмын төслийг батлуулах, холбогдох бусад журам, заавартай нийцүүлэхээр ажлыг гүйцэтгэнэ.

### **2.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.**

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээгээр амжилттай дүн авах, олон улсын байгууллагын хориг арга хэмжээний жагсаалтанд орохгүй байх зорилгоор Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмж болон Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр (Үндэсний хөтөлбөр)”-ийг Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан. Үндэсний хөтөлбөрийг 2022-2030 оны хооронд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар баталсан бөгөөд нийт 8 зорилгын хүрээнд 194 ажлыг тусгасан. Тус төлөвлөгөөг Үндэсний зөвлөл (ҮЗ), Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ)-ийн гишүүн байгууллагууд, ХАЗ-ийн дэргэдэх ажлын хэсгүүд, мэргэжлийн холбоод, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд (МҮЭ) зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагууд дангаар болон хамтран хэрэгжүүлэх юм.

Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны 2 дугаар улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

*Зорилго 1 болон 2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТС/ҮОХЗДС) үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд:*

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хүлээн авсан, дүн шинжилгээ хийсэн болон шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний талаарх ерөнхий мэдээлэл болон бусад холбогдох мэдээлэл өгөх зорилгоор бүх банкнуудын төлөөллүүдтэй 2024 оны 01 дүгээр сард уулзалт хийв. Түүнчлэн банкнуудын сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор банкнуудын комплаенсийн ажилтнуудад 2024 оны 02 дугаар сард сургалт зохион байгуулж, Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулсан Стратегийн дүн шинжилгээний тайлан болон типологийн тайлангуудыг танилцуулахаас гадна сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийхтэй холбоотой кейс ажиллуулж, кейсийн үр дүнгийн талаар ярилцаж, мэдээлэл солилцон практик чадварыг дээшлүүлж ажиллав.

Санхүүгийн мэдээллийн алба нь их дээд сургуулиудын оюутнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад уриалж сэдэлжүүлэх, дэмжих, бүтээлийг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, тэдний бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оноос эхлэн зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2023 оны хуралд амжилттай оролцсон оюутнуудын судалгааны ажлуудыг эмхэтгэн, товхимол бэлтгэн гаргалаа. Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Судалгаа дүн шинжилгээний

ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас тогтмол зохион байгуулж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр их дээд сургуулиудын оюутнуудын дунд зарладаг “Эрдэм шинжилгээний бага хурал”-ын 2024 оны II дахь шатны шалгаруулалт 2024 оны 5 дугаар сард зохион байгуулагдаж, Монгол Улсын 8 их дээд сургуулийн оюутнуудаас нийт 40 гаруй эрдэм шинжилгээний бүтээлүүд хүлээж авч, эцсийн шатанд 11 бүтээл шалгарлаа.

Түүнчлэн 2024 оны эхний хагас жилд Санхүүгийн мэдээллийн албанаас дангаар болон олон улсын донор байгууллагууд, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй хамтран хууль сахиулах байгууллага, шүүгч, прокуроруудыг мэргэшүүлэх, мэргэжлийн холбоодын хяналт шалгалтын чадавхийг бэхжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн мөнгө угаах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээ мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Эрсдэлийн нөхцөл байдалтай уялдуулан МУТСТ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

МУТСТ тогтолцоог энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарласан цахим контент, хэвлэл товхимол бэлтгэж гаргах, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлууд зохион байгуулах хүрээнд авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийн хяналт шийдвэрлэлт, явц байдлын талаар мэдээ мэдээлэл, мөнгө угаах гэмт хэргийн талаар зохион байгуулсан сургалт, олон улсын арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд өөрийн байгууллагын цахим хуудас болон бусад сайт, өдөр тутмын сонинд нийтлүүлэн, олон нийтэд хүргэсэн.

ҮЗ-ийн гишүүн байгууллага болох Улсын ерөнхий прокурорын газраас Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/-тай хамтран “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” төслийн хүрээнд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа” сэдэвт мөрдөгч, прокуроруудад зориулсан гарын авлагыг боловсруулж гаргасан. Мөн цагдаагийн байгууллагын нутаг дэвсгэр хариуцсан эдийн засгийн мөрдөгч нарт зориулсан Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудлаар Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас гарын авлагын төслийг боловсруулан хянагдаж байна. Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс орон нутагт ажиллаж буй арилжааны банкны салбарын ажилтнуудын МУТСТ талаарх мэдлэг ойлголтыг үнэлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах зорилгоор цахим асуумжийг хүргүүлэн, судалгаа хийж байна.

*Зорилго 3. МУТС/УОХЗДС-тэй тэмцэх дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд:*

Монгол Улсаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт, Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгийн ажиглагч улсын хувьд ажиглагч улсын үйл ажиллагааны тайланг тус тус бэлтгэн хүргүүлдэг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь ХАЗ-ийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын 2024 оны явцын тайлан болон Монгол Улсын 2023 оны үйл ажиллагааны тайланд тусгах мэдээллүүдийг нэгтгэн боловсруулж, 2024 оны 1 дүгээр улиралд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлэгт хүргүүлээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд гадаадын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон холбогдох суурь гэмт хэргийн дүн шинжилгээний мэдээлэл солилцох зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичиг болон Олон Улсын Санхүүгийн мэдээллийн албадын нэгдсэн Эгмонт бүлгийн сүлжээгээр дамжуулан хамтран ажилладаг. Энэхүү хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн алба болон Бүгд Найрамдах Мальта Улсын Санхүүгийн мэдээллийн алба, Канад Улсын Санхүүгийн мэдээллийн албадуудтай мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулан, 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Бүгд Найрамдах Мальта Улс болон Канад Улсын Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлээд байна.

Олон улсын валютын сангаас Татварын ерөнхий газарт хэрэгжүүлж буй «Мөнгө угаахтай тэмцэх болон татварын чадавхыг хөгжүүлэх» төсөлд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас оролцож, мэдээлэл солилцон хамтран ажиллаж байгаа бөгөөд ээлжит уулзалтыг 2024 оны 02 дугаар сард хийв. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн алба болон Авлигатай тэмцэх газрын төлөөлөл НҮБ-ын гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх албаны мэргэжилтэн, Папуа Шинэ Гвинейн Тусгаар Улсын үнэлгээчидтэй хамтран 2024 оны 3 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд Самаогийн Тусгаар Улсын Апиа хотод тус улсын НҮБ-ын авлигын эсрэг конвенцын 2 /урьдчилан сэргийлэх/ болон 5 /хөрөнгө хураах/ дугаар бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

Дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ)-ийн 2024 оны ээлжит хурлыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Хурлаар Монгол Улсын 2024 оны явцын тайланг эцэслэн Ази Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх, Монгол Улсын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн өргөтгөсөн хяналтаас гарах хүсэлтийг гаргах асуудлыг авч хэлэлцэн, холбогдох шийдвэрийг гаргалаа. Мөн ХАЗ-ийн 2024 оны ажлын төлөвлөгөө болон ХАЗ-ийн дэргэдэх 5 ажлын хэсгийн 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар шийдвэрлэж, гишүүн байгууллагуудаас санал авч нэгтгэн, ХАЗ-ийн даргад хүргүүлсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан үндэсний хэмжээнд хэрэгжих “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”, Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний явц, биелэлтийн тайланг Санхүүгийн мэдээллийн алба улирал бүр авч нэгтгэн Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар хэлэлцэх, жил бүр нэгдсэн биелэлтийн тайланг гарган, Үндэсний зөвлөлд танилцуулах үүрэгтэй байдаг. Энэ хүрээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны биелэлтийг гарган, Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргад хүргүүлээ.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллүүд Тагнуулын Ерөнхий газрын төлөөллүүдтэй уулзалт хийж, мэдээлэл солилцоо, эргэх холбоог сайжруулах талаар, мөн цаг үеийн нөхцөл байдлын талаар хэлэлцэн, хамтран ажиллав.

Бүгд Найрамдах Киргиз улсын нийслэл Бишкек хотноо 5 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 40 дэх удаагийн Чуулга уулзалт болон ажлын хэсгийн уулзалтуудад Монгол Улсын төлөөллүүд оролцов.

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг бий болгох төслийн хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Хууль сахиулах ажлын хэсгийн 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох системийг боловсронгуй болгох, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, цаасан мэдээллийн солилцооны тогтолцоог халах, эргэх холбоог (feedback mechanism) бий болгох ажлыг тусган, хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох төслийн хугацаа дууссанаар төслийн нэгжийн үйл ажиллагааг прокурорын байгууллагад шилжүүлэн өгөх, системийг 2024 оны 05 дугаар сараас эрх бүхий байгууллагуудын хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд системд Зөрчлийн хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хөгжүүлэлт хийх, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай “И Монгол академи” УТҮГ-тэй холболт хийж, мэдэгдэл хүргэх систем ашиглах, “Хур” төрийн мэдээлэл солилцооны системийг ашиглах гэрээг тус тус байгуулах, систем хэрэглэгчийн гарын авлага боловсруулах, хэрэглэгчийн болон админы сургалтыг зохион байгуулах, системийг хүлээж авах шаардлагыг тодорхойлох, дүгнэлт гаргах, гүйцэтгэгч компаниас системийг нэвтрүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэх баталгаа гаргуулах, функциональ бус шаардлагын болон системийн дизайн, программ хангамжийн архитектур, эх код (API түвшин) зэрэг баримт бичгүүдийн хүлээж авах бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Мэдээлэл солилцох болон хууль сахиулах үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр мөрдөгдөж буй гадаад хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгийг үнэлж, сайжруулах, мэдээлэл солилцох болон хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын хүрээнд Интерполын Санхүүгийн гэмт хэрэг болон авлигатай тэмцэх төвийн харилцах эрх бүхий алба хаагч /contact point/-аар ЭЦА-ны МУГХТХ-ийн дарга томилогдож, тайлангийн хугацаанд тус төвөөс “Үүрийн гэгээ” арга хэмжээний хүрээнд ирүүлсэн 2 удаагийн албан бус хүсэлтэд холбогдох хариуг өгч ажилласан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжигтэй гүйлгээ, хууль бус хөрөнгө, орлогыг илрүүлэх чиглэлээр цагдаагийн албанаас Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллаж сэжигтэй гүйлгээний мэдээлэл болон мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэргүүдийн тайлан мэдээг улирал бүр ирүүлж байна.

*Зорилго 4. МУТС/УОХЗДС эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд:*

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г эрсдэлийн нөхцөл байдалтай нь уялдуулан шинэчилж байх ажлын хүрээнд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудаас төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг авч нэгтгэн, ХАЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны А/210 тоот тушаалаар батлагдсан Хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, хуулийн этгээдийг мөнгө угаах гэмт хэрэгт ашиглахтай холбоотой гэмт

хэргийн талаарх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хурлын тогтоолуудыг судлан, дүн шинжилгээ хийж байна.

Мөн Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх ажлын хэсгийн гишүүнээр байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан ажлын хэсгийн хуралд оролцон, шаардлагатай мэдээллийг өгсөн.

Хамтын ажиллагааны зөвлөлийн 2024 оны 2 дугаар улирлын ээлжит хурал 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдаж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны 1 дүгээр улирлын биелэлт, ХАЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын батлагдсан төлөвлөгөөний танилцуулга, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг авч хэлэлцлээ. Хурлаар зөвлөлийн гишүүн байгууллагууд хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийг хурдан, шуурхай солилцох боломжийг судлах, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах зэрэг шийдвэрийг гаргав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ээлжит хурал 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдаж, Санхүүгийн мэдээллийн алба, хууль сахиулах байгууллагууд Монгол Улсын 2024 оны Явцын тайлан, олон улсад авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээний нөхцөл байдал, шинээр үүсэж буй аюул занал болон эрсдэл сэдвүүдээр танилцуулга хийж, Үндэсний зөвлөлийн зөвлөмж гаргах, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон.

*Зорилго 5. Мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар МУ/ТС/ҮОХЗДС гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх хүрээнд:*

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2024 оны 2 дугаар сард зохион байгуулагдсан нэгдсэн чуулганаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй улс орнуудын талаарх мэдээллийг шинэчлэн гаргасан. Санхүүгийн мэдээллийн алба нь эдгээр хар болон саарал жагсаалтад багтсан улсуудын мэдээллийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах тухай зөвлөмжийг зохицуулагч байгууллагуудаар дамжуулан нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргүүллээ.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний Зорилт 4.4-ийн 64 дүгээр ажлын хүрээнд үндэсний эрсдэлийн үнэлгээ болон салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүнг хяналт шалгалтын стратеги төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн бус мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэгчид болох Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын Танхим, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээнд суурилан 2024 онд авч хэрэгжүүлэхээр баталсан хяналт шалгалтын стратеги, төлөвлөгөөг авч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор

банкнуудын үйл ажиллагаанд Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, иж бүрэн, хэсэгчилсэн, сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалт нь банкнуудын МУТС-тэй тэмцэх бүтэц зохион байгуулалт, бодлого журам, эрсдэлийн үнэлгээ, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гүйлгээнд тусгайлсан хяналт тавих, гүйлгээг мэдээлэх, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх, корреспондент банкны үйл ажиллагаа гэх зэрэг 20 чиглэлийг хамруулан хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахтай холбоотой санал, зөвлөмжийг тухай бүрт нь хүргүүлж ажиллалаа. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-335 дугаар тушаалаар батлагдсан «Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам»-ын дагуу банкнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг холбогдох асуулгын хүрээнд тайлан, мэдээ, тоон өгөгдөл болон хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулгыг хүрээнд үнэлж, эрсдэлийн үнэлгээний матрицад оруулснаар банк тус бүрд авч хэрэгжүүлэх хяналт шалгалтын стратеги төлөвлөгөөг боловсруулан, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж байна

Санхүүгийн мэдээллийн албанаас нэг арилжааны банкны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээг мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд газар дээрх хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын үр дүнд үндэслэн хуульд заасан холбогдох арга хэмжээг авч ажиллав. Хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээтэй эсэхэд судалгаа хийн, дүгнэлт санал боловсруулан танилцуулсан бөгөөд үр дүнг ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэж байна. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мэргэжлийн холбоодоос хийх хяналт шалгалтын үйл ажиллагаанд хяналт тавих, чанарын үнэлгээ хийх тогтолцоог бий болгох ажлын хүрээнд олон улсын стандартад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын чиг үүргийн тухай хэрхэн тусгасан байдлыг судлах зорилгоор ФАТФ-ын зөвлөмж, журамтай танилцаж, үр дүнтэй хяналт шалгалтын тогтолцоог тодорхойлсон. Мөн олон улсад чанарын үнэлгээ хийх тогтолцоо байдаг эсэх, чанарын үнэлгээг хэрхэн хийдэг талаар судалж байна. Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлж, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах ажлын хүрээнд УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас нийт 2210 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдуулан хяналтын улсын байцаагчийн 93 дүгнэлт гарсан. Хяналт шалгалтын газраас Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн шалгалт хийж, Хяналтын улсын байцаагчийн 18 мэдэгдэл, албан шаардлагыг хүргүүлсэн.

Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршуулсан АНУ, Европын холбоо, ИБУИНВУ-ын ОХУ-ын эсрэг авч буй хориг арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн, үйл ажиллагаандаа ашиглах тухай мэдээллийг ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд болон арилжааны банкнуудад хүргүүллээ.

*Зорилго 8. МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зохистой бүтэц, зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэх.*

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, мэргэжлийн холбоодын үндсэн чиг үүрэгт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн талаар тусгаж, тодорхой болгох ажил тусгасан. Үндэсний зөвлөл энэ асуудлаар зөвлөмж гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байсан. Иймд Хамтын ажиллагааны зөвлөл нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор зөвлөлийн дэргэдэх Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэгт МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааг хариуцан ажиллах хүний нөөц, орон тоог нэмэгдүүлэх, хавсран гүйцэтгэж буй албан хаагчдад нэмэгдэл олгох талаар холбогдох хууль тогтоомжийг судалж, Үндэсний зөвлөлд танилцуулах үүрэг өгсөн. Ажлын хэсэг дээрх асуудлаар дахин нэмэлт мэдээлэл авахаар Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудад хүсэлт хүргүүлэн, ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж, ХАЗ-ийн ээлжит хурлаар танилцуулахаар төлөвлөж байна.

Монголбанкнаас бодлого, журам шинэчлэх хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай тоон болон чанарын мэдээллийг цуглуулах нэгдсэн аргачлал боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А-335 тушаалын хавсралтаар тоон болон чанарын мэдээллийг цуглуулах аргачлал болон загварыг боловсруулан батлуулсан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-243 дугаар тушаалаар МУТСТ үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матрицыг шинэчлэн баталсантай холбогдуулан тоон мэдээлэл цуглуулах маягтыг шинэчлэн боловсруулж батлуулав. Банкнудын МУТСТ үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матрицыг тогтмол шинэчлэн сайжруулахтай холбоотойгоор Монголбанканд 2024 оны 3 дугаар сард ирж ажилласан АНУ-ын Сангийн Яамны Техникийн туслалцааны газрын (ОТА) зөвлөх, Дэлхийн банкны төслийн Зөвлөх нараас техник туслалцаа аван, эрсдэлийн үнэлгээний матрицыг сайжруулан боловсруулах ажлыг 2023 оны 3 болон 4 дүгээр улиралд хэрэгжүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-243 дугаар тушаалаар батлуулав.

Үндэсний хөтөлбөрийн 5.1 дэх зорилтод тусгагдсан ажил болох “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 4.3 дахь заалтыг ФАТФ-ын зөвлөмжид заасан шаардлагын дагуу өөрчлөхтэй холбоотой ажлыг зохион байгуулж, хуулийн этгээдийн 25 хувь болон түүнээс дээш хувийг өмчилж байгаа этгээдийг эцсийн өмчлөгчөөр тогтоохтой холбоотой зохицуулалтыг гаргахаар журмын төслийг боловсруулсан. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны газрын (ОТА) зөвлөх ноён Шон Смит 2024 оны 3 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Монгол Улсад ирж Монголбанкны Хяналт шалгалтын газрын хянан шалгагч, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч нарт МУТСТ чиглэлийн хяналт шалгалтыг хөгжүүлэх, удирдах чиглэлээр зөвлөгөө өгөх, туршлага хуваалцахад чиглэсэн сургалтыг зохион байгууллаа.

Мөн Монголбанк АНУ-ын Нью Йорк Мэллон банктай холбогдож, Монгол Улсын МУТСТ чиглэлийн хяналт шалгалтын тогтолцоог танилцуулж, уулзалтанд оролцсон банкнуд өөрсдийн банкны тогтолцоогоо тус банкны төлөөлөлд танилцууллаа. Улмаар Монгол

Улсын банкнууд АНУ-д дансаа нээх нөхцөл бүрдэж, гадаад төлбөр тооцоог шууд гүйцэтгэж байна. МУТСТ үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд Базелийн стандарт, ФАТФ-ын Зөвлөмж, Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн акт, хяналт шалгалтын арга хэлбэрийн талаар банкны удирдлага, чиг үүрэг бүхий ажилтнуудад мэдээлэл, сургалт хүргэх, мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан “Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ын 6 дугаар заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө”-д заасны дагуу МУТСТ чиглэлийн хүрээнд банкнуудад сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Банк бүрийн сургалтын хэрэгцээ шаардлага харилцан адилгүй байдлыг харгалзан, банкнуудын МУТСТ чиглэлээр авах сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүний дагуу банкнуудын комплаенсын хэлтэс, дотоод аудит, удирдлагын багт зориулсан сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкаас банкнуудын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж байгаад иж бүрэн, хэсэгчилсэн, сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна. Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журмын дагуу банкнуудын эрсдэлийн үнэлэх тайлан, мэдээ, мэдээллийг цуглуулав. Ирүүлсэн мэдээлэлд үндэслэн, эрсдэлийн матрицад оруулан үнэлсэн бөгөөд, банк тус бүрд авч хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг гаргаж, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Цагдаагийн Ерөнхий газраас хэрэгжүүлсэн “Хяналт-2” хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж цахим залилан, мөрийтэй тоглоом, криптовалюта ашиглан үйлдэгдэж байгаа гэмт хэргийн эсрэг төлөвлөгөө боловсруулан банкнуудтай хамтран хэрэгжүүлэх ажлыг Монголбанкаас зохион байгууллаа. Үүний үр дүнд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв байгуулагдсан бөгөөд цагдаагийн байгууллага болон банкнууд гэмт хэргийн мэдээллийг цаг алдалгүй, шуурхай солилцох, аж ахуй нэгж, иргэд хохирогч болсон тохиолдолд цагдаагийн байгууллагад хандаж шуурхай арга хэмжээ авах бололцоо бүрдлээ.

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн бүтцэд “Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хариуцах алба” байгуулах ажлыг төлөвлөн, 2024 оны улсын төсөвт хяналтын 17 прокурорын бүтэц орон тоог шинээр батлуулсан. Цагдаагийн байгууллагын хар тамхи, байгаль орчин, кибер, залилах гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүдэд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах, санхүүгийн шинжилгээ хийж мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүгийн тусгай мэдлэг бүхий 2 орон тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон төсвийн тооцоолол судалгааг гарган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг үнэн зөв мэдүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг түргэн шуурхай авах технологийн дэд бүтцийг боловсронгуй болгоход шаардлагатай нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкнаас Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж буй “Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг засаг захиргааны анхан шатны нэгжид шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх» төслийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санг сайжруулах, улсын бүртгэгчдийг



чадавхжуулах, сургалтад хамруулахаар төлөвлөн тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан.

**2.4. Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж, дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэнэ.**

Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээл, иргэдэд олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх нөхцөлийг уян хатан болгох ажлыг эхлүүлж Монголбанкны Ерөнхийлөгчийн А-216 дугаар тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулж, банкнаас жижиг, дунд бизнес эрхлэгчид болон иргэдэд олгосон зээлийн ангиллыг дээшлүүлэхдээ Монголбанкнаас тухай бүр зөвшөөрөл авдаг байсныг өөрчилж, банк хязгаарлалттай эрхийн хүрээнд дотооддоо дээшлүүлэх боломжийг банкнүүдэд олгож, активын ангиллыг уян хатан болголоо.

### 3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

#### **3.1. Хил дамнасан худалдааны цахим хөтөлбөр, тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

Төлбөрийн системийн оролцогч болох ККТТ ХХК-иас 2023.04.24-ний өдрийн 2023/056 дугаар “Санал хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “QR кодын мессежний бүтэц, заавар”-т оруулах өөрчлөлтийг тусгасан шинэчилсэн төслийг хэлэлцэн боловсруулж, “QR кодын мессежний бүтэц, заавар”-г Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024.06.18-ны өдрийн А-149 тоот тушаалаар шинэчлэн баталуулж нийт төлбөрийн системийн оролцогч нар болон олон нийт (Монголбанкны цахим хуудас)-д хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойн хүрээнд Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн Төв банк (SEACEN)-уудын төлбөр тооцооны систем хариуцсан удирдах албан тушаалтнуудын оролцоотойгоор Төлбөр тооцооны системийн талаарх 23 дахь удаагийн хуралдааныг Монголбанк нь 2024 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулллаа. Хурлыг ТТГ-ын захирал Э.Анар нээж, БЗҮАХ-ийн захирал А.Батсайхан Монгол Улсын төлбөр тооцооны системийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагын талаар танилцууллаа. Оролцогчид олон улсын түвшинд төлбөрийн системийн өөрчлөлт, шинэчлэл, цахим шилжилт, хил дамнасан төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэг асуудлын талаар хийгдсэн шинэлэг технологи, олон улсын байгууллагаас хийсэн судалгааны ажил, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эдгээрийн бодлого зохицуулалтын орчин, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар санал солилцож, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн. Хуралдааны үеэр Төв банкнууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк төдийгүй бусад судлаачдын дунд хийгдэж байгаа онцлох судалгааны нэг болох “Төв банкны цахим мөнгө (ТБЦМ)-ний талаарх илтгэлийг Япон улсын Дижитал валютын форумоос танилцуулсан. Илтгэлд ТБЦМ нь технологид суурилсан, баялгаар баталгаажуулахгүй крипто-валют бий болж, түүгээр төлбөр тооцоо гүйцэтгэх тул зөвхөн төлбөрийн системд шинээр нэвтрүүлэх ажил биш Төв банкны санхүү бүртгэлийн систем, мэдээллийн технологи, мөнгөний бодлогын хэрэгжилтэд томоохон нөлөө үзүүлэхийг судалгаагаар харуулсан.

Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс оролцогч болон операторын үйл ажиллагааны тайланд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдалд холбогдох арга хэмжээ авч ажиллалаа. Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээний зөвшөөрөлтэй 9 байгууллагаас ирүүлж буй цахим мөнгөний тайланд хяналт тавьж ажиллалаа. Тайлант хугацаанд цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд хууль, журмын заалтуудыг бүрэн хангаж ажилласан байна. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зөвшөөрөл хүссэн 7 байгууллагаас ирүүлсэн системийн операторын үйлчилгээ үзүүлэх, аутсорсингийн үйлчилгээ авах, цахим мөнгө зэрэг зөвшөөрлийн материалыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянан шалгаж 1 байгууллага шалгуур, шаардлагыг хангасан тул карт гаргах, хүлээн авах зөвшөөрөл, 1 байгууллагад аутсорсингийн зөвшөөрөл, 2 байгууллагад цахим мөнгө гаргах зөвшөөрлийг хугацаагүй сунгаж, 1 байгууллагад цахим мөнгө гаргах зөвшөөрөл олгосон

ба 1 байгууллагын төлбөр тооцооны төлөөлөгч, 1 байгууллагын системийн операторын үйлчилгээ үзүүлэх, 1 байгууллагын аутсорсингийн үйлчилгээ авах, 1 байгууллагын цахим мөнгөний зөвшөөрлийн материалуудыг тус тус хянаж байна.

Зайнаас тавих хяналтын хүрээнд тасралтгүй ажиллагааны тайлан, хөдөлгөөнт банкны тайлан, төлбөрийн системийн тайлан болон цахим мөнгөний хяналтын тайланг тус тус боловсрууллаа. Банкнуудын гадаад гүйлгээний сарын тоон мэдээ, тэдгээрт хамаарах чанарын мэдээллийг Монголбанкны тайлангийн цахим системээр тогтмол авч байна.

Монгол Улсын төлбөрийн картын хэрэглээ, хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгө гаргах үйл ажиллагаа зэргийг багтаасан төлбөрийн системийн тоон үзүүлэлтийн нэгдсэн тайланг улирал бүр бэлтгэн Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна. Монголбанк нь төлбөрийн системийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгүүдийг зохицуулах, хянах талаар тусгаж, төлбөрийн системд хяналт тавих үүрэгтэй ба үүний дагуу хийсэн ажлаа тайлагнаж 2023 оны төлбөрийн системийн хяналтын тайланг боловсруулсан.

Цахим мөнгө гаргах зөвшөөрөлтэй Мобифинанс ББСБ ХХК, Супер ап хэтэвч ХХК, Ардкредит ББСБ ХК, Токи ББСБ ХХК, Инвескор хэтэвч ББСБ ХХК, Хайпэй ХХК, Нэт капитал финанс корпораци ББСБ ХХК, Дата бэйнк ХХК нь цахим мөнгөний үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, гэрээ, журам, зааврын дагуу хэрэгжүүлж байгааг газар дээр нь шалгаж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулахад анхаарч ажиллалаа. ХХБ-ны систем ажиллуулах үйл ажиллагаа болон ҮЦТХТ ХХК-ийн үйл ажиллагаа, холбогдох гэрээ, журам, зааврын хэрэгжилт, үндсэн болон нөөц төвд иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэв. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

### **3.2. Их өгөгдлийн хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн хөгжлийг дэмжин ажиллана.**

Ногоон хөгжлийн зорилтуудыг хангах, Тогтвортой санхүүжилтийн замын зурагт тусгагдсан банкны салбарын ногоон зээлийн багцыг 10 хувьд хүргэх зорилтыг хангахад ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх нь чухал юм. Энэ хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн үндсэн ойлголтын талаар Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) болон бусад олон улсын байгууллагаас гаргасан гарын авлага, судалгааны ажилтай танилцаж, бусад улсын туршлагыг судлах ажлууд хийгдэж байна.

Судалгааны чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэсэн.

- Банкнуудын ногоон зээлийн тайланг 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн улирлын давтамжтай банкнуудаас аван нэгтгэж олон нийтэд танилцуулж байна. Ногоон зээлийн багцын үлдэгдэл 2024 оны 3 дугаар сарын байдлаар 875.3 тэрбум төгрөгт хүрч нийт банкны зээлийн үлдэгдлийн 3.0 хувийг эзэлж байна.
- Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос ирүүлсэн Бичил Жижиг Дунд Үйлдвэрлэлийг (БЖДҮ) дэмжихэд чиглэсэн Байгаль орчин, Нийгэм, Засаглал, Хүнсний аюулгүй байдал гэсэн 4 сэдвийг хамарсан (БОНЗ) үнэлгээний шалгуур үзүүлэлтээр хэмжих маягтыг Монголбанкны их өгөгдлийн системээр дамжуулан

хүлээн авах туршилтыг хийж гүйцэтгэсэн.

- Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи” 2024 оны 6 дугаар сард батлагдсан. Үүнтэй холбогдуулан хуучин батлагдсан “Ногоон таксономи”-ыг “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-руу шилжилжүүлэх ажлыг арилжааны банкнууд болон ТОС холбоотой хамтран гүйцэтгэж байна.
- Банкнуудын ногоон зээлийн хүйсээр ангилсан тайланг Азийн хөгжлийн банкны хүсэлтээр 2022 болон 2023 оны эцсийн байдлаар нэгтгэн тайлагнахаар болж тайланг нэгтгэн боловсруулж байна.

**3.3. Тогтвортой хөгжлийн зорилтын таксономид органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхой тусгаж, төрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын тодорхой хэсгийг тухайн таксономитой уялдуулан ногоон, тогтвортой зээл гаргадаг болох чиглэлээр санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллана.**

Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономийн 12 салбарын нэг “Тогтвортой хөдөө аж ахуй” салбарын 2 дэд ангилалд дараах байдлаар органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тусган оруулсан:

6.2 Газар тариалан ба түүнд хамааралтай үйл ажиллагаа:

6.2.1 Тогтвортой ургац, жимс, болон хүнсний ногооны болон тогтвортой газар тариалан

6.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон хоол, хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт:

6.3.1 Тогтвортой хүнсний боловсруулалт, үйлдвэрлэл

Эдгээр дэд салбаруудын зорилгын тодорхой тусган оруулсан:

“6.2.1 Тогтвортой ургац, жимс, болон хүнсний ногооны болон тогтвортой газар тариалан” - Уур амьсгал, биологийн олон янз байдал, байгаль орчин, орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан байгалийн нөөцийг сүйтгэх, хомсдуулахаас зайлсхийсэн орон нутгийн органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (пестицид, бордоо, хуванцрыг ашиглахгүй байх болон багасгах) зорилготой.

“6.3.1 Тогтвортой хүнсний боловсруулалт, үйлдвэрлэл” - Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрүүдийг экологид ээлтэй, эргэлтийн эдийн засгийн зарчмаар ажиллуулах, Тогтвортой үйлдвэрлэл: Тогтвортой хүнсний үйлдвэрлэл нь хүнсний хангамжийн сүлжээнд байгаль орчин, нийгмийн хариуцлагын өндөр стандартыг мөрдүүлэх замаар хүнсний үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг арилгах зорилготой.

Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийг “Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи”-д нийцүүлэх, холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын дагуу УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжиж буй “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хөтөлбөр”-ийн нөхцөлүүдэд ногоон зээлийг дэмжсэн зохицуулалтыг тусгахаар ТоС Холбоо болон

Ногоон зээлийн мэргэжлийн зөвлөлөөс санал авч, цаашид хамтран ажиллах хүрээг тодорхойлсон.

### **3.4. Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.**

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор 2023 онд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги” болон “Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

*“Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хүрээнд:*

- 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулсны үр дүнд 4138 хүн сургалтад хамрагдлаа. Үүнээс дурдвал харилцагчид зөвлөх банкны ажилтныг чадавхжуулах онол, практик хосолсон сургалтын “Модуль 1” сургалтыг Төрийн банкны нийт 120 ажилтанд, ХУД-ийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран 250 гаруй иргэдэд, Эрүүгийн цагдаагийн кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөрдөн байцаагч нарт, “Жигүүр” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 5, 29, 96, 148, Глобал инноваци сургуулиудын ахлах ангийн 55 бүлгийн 1354 сурагчдад сургалт орсон байна.
- Санхүүгийн боловсролын мэдлэг мэдээллийг түгээх гол дэд бүтэц болдог сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг Улаанбаатар хотод Хаан банк, Транскапитал ББСБ-ын ажилтнууд болон Баян-Өлгий, Орхон, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад тус тус зохион байгуулж нийт 210 сургагч багш бэлтгэв. Сургагч багшаар орон нутгийн банкны салбарын төлөөллүүд олон мянган харилцагчдынхаа санхүүгийн мэдлэгт анхаарал тавьж ажиллахаар болж албан ёсны сургалтад хамрагдав. Монголбанкны Олон нийтийн санхүүгийн боловсролын төвөөс санхүүгийн суурь мэдлэг олгох үндсэн сэдвүүдээс гадна хичээлийн агуулга, заах арга зүй, сургалт зохион байгуулах ур чадваруудыг дээшлүүлэх хөтөлбөрөөр сургалт зохион байгуулав.
- “Дэлхийн Мөнгөний Долоо Хоног-2024” аяны нээлтийн үйл ажиллагааг 3-р сарын 20-ны өдөр Баян-Өлгий аймгийн Өлгий хотод амжилттай зохион байгууллаа. Олон Улсын Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ээс жил бүр зохион байгуулдаг тус аян нь хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлж, түүний ач холбогдлыг олон нийтэд таниулах зорилготой. Энэ жилийн аяны үйл ажиллагаа нь “Мөнгөө эрсдэлээс хамгаалж, ирээдүйгээ баталгаажуулъя” уриан дор 2024 оны 3 дугаар сарын 20-ноос 4 дүгээр сарын 10-ны өдрүүдэд орон даяар хэрэгжиж аяны хүрээнд шууд бусаар нийт 328,628 хүнд, шуудаар нийт 47,958 хүнд мэдээлэл түгээж хүрч ажиллав.
- ЕБС-ийн ахлах ангид ордог “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг сайжруулах, бусад ангийн хичээлийн судлагдахуунд санхүүгийн мэдлэг, мэдээлэл бүхий жишээ оруулах санаачилгыг агуулсан. Улмаар Монголбанк, Боловсролын ерөнхий газартай

хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, хамтарсан төлөвлөгөө гарган ажиллахаар тогтов.

- Цахим орчинд мэдээлэл түгээх ажлын дагуу [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn) хуудсанд баяжуулалт хийж, [www.facebook.com/sankhuuginbolovsrol](https://www.facebook.com/sankhuuginbolovsrol) пэйж хуудас, [twitter.com/SankhBolovsrol](https://twitter.com/SankhBolovsrol) твиттер хуудсанд хоёрдугаар улирлын байдлаар нийт 39 мэдээ, постер байршуулав. Мөн “Санхүүгийн боловсрол гэж юу вэ?” цуврал подкастын ээлжит дугаарыг “Хувь хүний санхүү” сэдвээр ХБНГУ-ын Шпаркассе банкны Монгол дахь сангийн суурин төлөөлөгч Маркус Лохтой хийв. Тус цуврал подкастаар “Цахим залилан”, “Төв банк юу хийдэг вэ?”, “Төв банкны ажилтнууд юу хийдэг вэ” сэдвээр подкастуудыг бэлтгэн YouTube сувагт байршуулав. Монголбанкинд иргэдээс ирсэн санал, хүсэлтэд тогтмол хариу өгсөн.
- Иргэдэд санхүү, эдийн засгийн мэдлэг түгээх хэрэгслийн нэг болох гарын авлагыг 2024 онд нийт 15,000 ширхэгийг бэлтгэн хэвлүүлж иргэд, олон нийтэд түгээн ажиллав.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Техникийн хорооны 21 дэх хурал 2024 оны 5 дугаар сарын 22-24 ний өдрүүдэд Коста Рика улсын Сан Жозе хотноо зохион байгуулагдав. Техникийн хорооны дугуй ширээний болон ажлын хэсгийн уулзалтуудад Монголбанкны төлөөлөл оролцож өөрсдийн санхүүгийн боловсролын бодлого, хөтөлбөрийн талаарх туршлагаа бусад орны гишүүдтэй хуваалцаж цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл солилцов.
- Татварын ерөнхий газар, МҮХАҮТ, Монголтакс ТМЗ ХХК хамтран 2024 оны 5-р сарын 8-ны өдөр зохион байгуулсан “Таны ирээдүй - татварын боловсрол” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгт санхүүгийн боловсролын ач холбогдлын талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэгт панелистаар оролцов.

*“Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд:*

- Тус стратеги нь хүүхэд/залуучууд, сэтгүүлчид, олон нийт/санхүүгийн хэрэглэгчид, БЖДҮҮ эрхлэгчид гэсэн 4 чиглэлээр хэрэгжих ба зорилтот бүлэг тус бүрд чиглэсэн сэдвүүдийг батлав. Улмаар батлагдсан сэдвүүдийн хүрээнд гарын авлага боловсруулж эхлээд байна.
- БЖДҮҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг Монголбанк, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар 2021 онд баталсан ба энэ хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮ газар болон Нийслэлийн ЖДҮҮ-г дэмжих төвтэй хамтарч ажиллаж Нийслэлийн ЖДҮҮ-г дэмжих төвийн мэргэжилтнүүдэд санхүү, эдийн засгийн мэдлэг олгох сургалтыг 40 хүнд оров.
- Сэтгүүлчдэд эдийн засгийн мэдлэг олгох, тэдний эдийн засгийн чиглэлээр нийтлэл, мэдээлэл бэлтгэх чадварыг хөгжүүлэх ажлын хүрээнд Орхон аймаг дахь Монголбанкны хэлтэст сургалт зохион байгуулж, Улаанбаатар хот болон Орхон аймгийн нийт 30 орчим сэтгүүлчид оролцов.

- Монголбанкны Дэд Ерөнхийлөгч, Афлатон Интернэйшнл олон улсын байгууллагын гүйцэтгэх захирал нар 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр цахимаар уулзаж, хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус санамж бичгийн хүрээнд Монгол Улсын хүүхэд залуучуудад санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг хөгжүүлэх, санхүүгийн боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, харилцаа холбоог өргөжүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тусгаад байна.
- Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны хуулийн 41-р зүйл, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.6, Монголбанкны 2024 оны дотоод ажлын төлөвлөгөөг тус тус үндэслэн Монголбанкны зүгээс үндсэн зорилгоо хангах хүрээнд 2023 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийн хураангуй “Монголбанкны 2023 оны онцлох үйл явдлын товчоон” товхимлыг 500 ширхэгийг хэвлүүлэн, түгээв.
- Монголбанкны 2024 оны дотоод ажлын төлөвлөгөө болон ОНСБТ-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөний дагуу “Монголбанкны 2023 оны жилийн тайлан” 300 ширхэгийг Монгол хэлээр хэвлүүлэн, түгээв.
- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү эдийн засгийн дээд сургуулийн ректорын хамтарсан А-78/А89 дугаар тушаалаар Эдийн засаг, санхүүгийн тайлбар толь шинэчлэх Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- Банкны тухай хуульд 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу арилжааны банкнууд хувьцаат компани болж, банкны сайн засаглалыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлсэн. Үүний дагуу банкны хувьцаа эзэмшигчид буюу санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашиг болон ёс зүй, хариуцлагын асуудлууд хөндөгдөж эхэлсэн тул “Банкны хувьцаа эзэмшигчийн эрх болон үүрэг” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг гүйцэтгэв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-6 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран төслийн зөвлөхөөс өгсөн санал, зөвлөмжийг үндэслэн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх асуулгаар боловсруулсан болно. Хуулийн төсөл нь “санхүүгийн хэрэглэгч” буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан хувь хүн болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн болно. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулагч байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг хамааруулсан. Өөрөөр хэлбэл тус хууль нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаас, даатгалын компаниуд, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг этгээдүүдэд хамаарна. Хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг ханган

2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/990 дүгээр албан бичгээр хууль санаачлагч болох Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Түүнчлэн, Монголбанкны 2024 оны дотоод ажлын төлөвлөгөөнд чанаргүй зээлийг бууруулах зорилгоор УИХ-аас 2021 онд батлагдсан банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн танилцууга болон шинээр боловсруулагдаж байгаа Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон үзэл баримтлалын талаар дэлгэрэнгүй танилцуулга, сургалтыг орон нутагт зохион байгуулахаар бэлтгэн ажиллаж байна. Санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэднийг санхүүгийн эсрдэлийг бууруулах үр дүнтэй арга нь иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, улмаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Ийнхүү хууль тогтоожийг сурталчлан таниулж иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлснээр иргэдийн мэдвэл зохих хууль тогтоомжийн талаарх мэдлэг дээшилж, өөрсдийн хууль ёсны эрх ашиг хамгаалах, санхүүгийн аливаа төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьчилан сэргийлж, орчин үед улам бүр ихсэж байгаа цахим болон санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад чухал нөлөөтэй.

Иймээс энэхүү сургалтаар Монголбанк, банкны ажилтнууд, иргэдэд банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд таниулах замаар иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн болон бусад оролцогчдын эрх, үүргийг сурталчлан таниулах, улмаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх болон зохистой хандлагыг нэмэгдүүлэн төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

### **3.5. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлж, зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.**

Монголбанкнаас Зээлийн мэдээллийн тухай хуулийг шинэчлэх хуулийн төслийн санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг олон улсын чиг хандлага, стандартад нийцүүлэх ажлыг Дэлхийн банктай хамтран гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд Ажлын хэсгээс зээлжих зэрэглэлийг тогтоох зорилго бүхий зээлдэгчийн зээлийн эргэн төлөлт зэрэгт үндэслэсэн оноог тооцох (кредит скоринг) тогтолцоог нэвтрүүлэх банк эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулж дуусаад байна. Улмаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох санал авах ажиллагааг эхлүүлэхээр бэлдэж байна.




## ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА

### I. ИНФЛЯЦ

Хавсарсан шокуудын нөлөөгөөр 2022 оны дунд үе хүртэл эрчтэй нэмэгдсэн инфляц сүүлийн 2 жилийн хугацаанд алгуур саарч байна. Үүнд, тээвэр, логистикийн хүндрэл багасаж, худалдааны түнш орнуудын инфляц саарсан болон төгрөгийн ханш тогтворжсон нь том нөлөөтэй байлаа. Түүнчлэн, мөнгөний бодлогын төлөвийг хатуу хэвээр хадгалж, илүүдэл эрэлт үүсгэлгүй хязгаарласан нь инфляцын өөрчлөлтөд чухал нөлөөтэй байв. Ийнхүү ХҮИ-ээр хэмжигдэх инфляц сүүлийн 2 жилийн хугацаанд сард дунджаар 0.5 нэгж хувиар буурч 7 дугаар сарын байдлаар 5.5 хувьд хүрч “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл”-д тусгагдсан инфляцыг 2024 онд 6+/-2 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг хангаж байна (Зураг 18).

Зураг 18. Улс болон Улаанбаатар хотын инфляц | Зураг 19. Жилийн инфляцын<sup>14</sup> задаргаа<sup>15</sup>



Эх сурвалж: УСХ, Монголбанк

**Зураг 19-д харуулснаар 6 дугаар сарын байдлаар инфляцын хөдөлгөөнд голлох нөлөө үзүүлсэн хүчин зүйлсийг дараах хэсэгт тайлбарлая.**

Энэ онд өвөлжилт хүндэрч малын зүй бус хорогдол огцом нэмэгдсэн хэдий ч **дотоодын мах, махан бүтээгдэхүүний** үнэ харьцангуй тогтвортой байж инфляцад үзүүлэх нөлөө багасав. Мөн инфляцад том нөлөөтэй байсан импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт алгуур саарсаар тайлант сард нийт инфляцын 1.8 нэгж хувийг бүрдүүлж байна. Худалдааны түнш орнуудын инфляц буурч, төгрөгийн ханш тогтворжсон нь үүнд нөлөөллөө.

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тогтвортой байгаагийн зэрэгцээ ОХУ-аас АИ-92 шатахууныг хөнгөлөлттэй үнээр авах гэрээний үр дүнд **шатахууны үнэ** өөрчлөлтгүй байлаа. Ийнхүү шатахууны бүлгийн үнэ зөвхөн дизель түлшний үнийн хөдөлгөөнөөс хамааран инфляцад үзүүлэх нөлөө +/-0.1 орчим ялимгүй хэлбэлзэж байна.

<sup>14</sup> Инфляцыг мах, махан бүтээгдэхүүн, махнаас бусад хүнс, шатахуун, төрийн зохицуулалттай үйлчилгээ болон бусад гэсэн хэсгүүдэд хуваасан. Бусад хэсгийг дотор нь импортын бараа, бусад дотоодын бараа болон үйлчилгээ зэрэг бүлэгт хувааж тооцов.

<sup>15</sup> Бусад дотоодын бараад хатуу түлшийг оруулж тооцов.

*Хүснэгт 2. Жилийн инфляцын хөдөлгөөнд голлох нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд, (6 дугаар сарын байдлаар)*

Бүлэг	Жилийн инфляц	Жилийн инфляцад эзлэх хувь
Нийт импортын бараа, бүтээгдэхүүн	4.0%	1.8%
Хүнсний импортын бараа	1.0%	0.1%
Хүнсний бус импортыг бараа	5.3%	1.8%
Шатахуун	-0.5%	0.0%
Дотоодын мах, махан бүтээгдэхүүн	-1.0%	-0.1%

Эх сурвалж: Монголбанк

## II. БОДИТ СЕКТОР

### 2.1. Нийт нийлүүлэлт


Эдийн засаг 2024 оны эхний хагаст жилийн 5.6 хувиар өслөө (Зураг 20). Уул уурхайн үйлдвэрлэл, тээврийн салбарын өсөлт өндөр хадгалагдсан нь нийт өсөлтийн тал хувийг бүрдүүлэв. Мөн хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжилийг даган татварын орлого бүрдүүлэлт сайн байлаа. Харин цаг уурын таагүй нөхцөл байдлаас үүдэн малын хорогдол өндөр байснаар хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл огцом унав.

*Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл:*

Оны эхний хагас жилд уул уурхайн салбарын үйлдвэрлэл 15.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд, нүүрсний эрэлт хадгалагдаж, өнгөрсөн оны мөн үеэс 12.8 сая тонноор илүү буюу 47.8 сая тонн нүүрс олборлосон нь гол нөлөөтэй байв. Мөн уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспортын өсөлтийн даган тээврийн салбар 24.7 хувиар нэмэгдэж, нийт өсөлтөд 1.0 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлжээ.

Хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил өндөр байсан тул татварын орлого бүрдүүлэлт сайн байлаа. Ийнхүү бүтээгдэхүүний цэвэр татварын орлого оны эхний хагаст 15.0 хувиар нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийн 2.3 нэгж хувийг дангаараа бүрдүүлэв. Харин зудын хүндрэлээс үүдэн хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эхний хагаст 26.7 хувиар унаж, эдийн засгийн өсөлтөд 3.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна. Үүнд, том малын зүй бус хорогдол 2010 оноос хойших хамгийн муу түвшинд хүрч, оны эхнээс нийт малын 12.5 хувь буюу 8.1 сая толгой мал хорогдсон нь нөлөөлсөн байна.

Зураг 20. ДНБ-ий жилийн өсөлт, эдийн засгийн салбараар




Эх сурвалж: YCX

## 2.2. Нийт эрэлт

Нийт эрэлт 2024 оны эхний хагас жилд 5.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг 1) өрхийн хэрэглээ, 2) төрийн байгууллагын хэрэглээ голлон бүрдүүлэв (Зураг 21).

Зураг 21. ДНБ-ийн жилийн өсөлт, эрэлт талаас



Эх сурвалж: YCX

Дараах хэсэгт нийт эрэлтийг дэлгэрүүлж тайлбарлая:

Өрхийн хэрэглээ 2024 оны эхний хагаст 16.9 хувиар өсөж, нийт өсөлтийн 12.1 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Өрхийн бодит орлого тайлант оны эхний хагаст жилийн 19.4 хувиар өссөний зэрэгцээ инфляц саарч байгаа нь хэрэглээг дэмжиж байна. Өрхийн хэрэглээг бүтцээр нь задалбал хүнсний хэрэглээ төдийлөн нэмэгдээгүй, харин хүнсний бус хэрэглээ

өсөлтийг голлон тайлбарласан хэвээр байна. Тодруулбал, хүнсний бус хэрэглээ 2024 оны эхний хагаст 36 орчим хувиар өсөхөд тээврийн хэрэгсэл, хувцас, бөс бараа, орон сууцны хэрэглээ голчлон нөлөөлжээ.

Төрийн байгууллагын хэрэглээ 2024 оны эхний 6 сард өмнөх жилээс 46.9 хувиар нэмэгдэж, өсөлтийн 9.3 нэгж хувийг бүрдүүлэв. Тухайлбал, бараа үйлчилгээний зардал 2 дахин нэмэгдсэн байна.

Хөрөнгийн нийт хуримтлал 17.6 хувиар тэлж, нийт эрэлтийн өсөлтөд 6.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Малын хорогдол үндсэн хөрөнгийн хуримтлалд буурах нөлөөг үзүүлж буй ч машин тоног төхөөрөмж, орон сууцны барилга өсөлттэй байгаа тул эхний хагас жилд нийт эрэлтэд 0.2 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг үзүүлсэн байна. Харин нийт бараа материал, уул уурхайн бүтээгдэхүүний үлдэгдэл (овоолго) их байгаа нь материаллаг эргэлтийн хөрөнгийг дэмжиж нийт өсөлтөд 6.0 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлэв.

Цэвэр экспорт 2024 оны эхний хагаст нийт өсөлтөд 21.9 хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ тайлант хугацаанд өссөн хэдий ч зэс, алтны экспортын биет хэмжээ багассанаас шалтгаалан экспорт бодит дүнгээр бууралттай байв. Түүнчлэн, хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт 2024 оны эхний хагаст тэлж нийт эрэлтэд 20.5 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна (Зураг 21).

### III. УЛСЫН ТӨСӨВ

Орлогын бүх дэд бүлгүүд эдийн засгийн идэвхжилийг даган өмнөх оноос эрчтэй өссөн хэвээр байна. Тодруулбал, чулуун нүүрсний экспорт оны эхний хагасын байдлаар 39.4 сая тоннд хүрч, АМНАТ-ын орлого өмнөх оноос 21.7 хувиар буюу 376 тэрбум төгрөгөөр<sup>16</sup> нэмэгдсэн бол ААНОАТ өмнөх оноос 1.6 их наяд төгрөг буюу 73.5 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 3. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Их наяд төгрөг	2023	2024	2024.6
	Гүй.	Бат.	Гүй.
<b>Нийт орлого</b>	<b>24.3</b>	<b>27.7</b>	<b>14.9</b>
Сангуудын орлого	1.1	1.9	0.7
<b>Тэнцвэржүүлсэн орлого</b>	<b>23.2</b>	<b>25.9</b>	<b>14.2</b>
Татварын орлого	21.5	24.0	13.3
Татварын бус орлого	1.8	1.9	0.9
<b>Нийт зардал</b>	<b>22.5</b>	<b>27.4</b>	<b>12.9</b>
Анхдагч зардал	21.3	26.2	12.3
Хүүний зардал	1.1	1.2	0.6
<b>Нийт тэнцэл</b>	<b>1.5</b>	<b>0.4</b>	<b>2.0</b>
ДНБ-д эзлэх хувь	3.1%	0.5%	2.8%
<b>Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл</b>	<b>0.8</b>	<b>-1.5</b>	<b>1.3</b>
ДНБ-д эзлэх хувь	1.3%	-2.0%	1.7%
<b>Анхдагч тэнцэл</b>	<b>1.9</b>	<b>-0.3</b>	<b>1.9</b>
ДНБ-д эзлэх хувь	3.1%	-0.4%	2.5%

Эх сурвалж: Сангийн яам

Эхний 6 сарын төсвийн зардал оны мөн үеэс 42.9 хувиар буюу 3.9 их наяд төгрөгөөр өндөр байв (Хүснэгт 3). Үүнээс урсгал зардал 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 2.2 их наяд төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Үүнд цалингийн зардал<sup>17</sup> 1.0 их наяд орчим төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Тайлант хугацаанд гадаад зээл, гадаад дотоод үнэт цаас эргүүлэн төлөхөд нийлбэр дүнгээр 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдав. Үүнээс 1.1 их наяд төгрөгийг гадаад зээлээр, үлдсэн дүнг Монголбанканд байрших харилцах дансны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна (Хүснэгт 4).

<sup>16</sup> 2023 онд үргэлжилж байсан нүүрсний экспортын хандлага үргэлжилж байгаа тул АМНАТ орлого өндөр өсөлттэй байна.

<sup>17</sup> Цалингийн зардал нь нийт бараа үйлчилгээний зардлыг 40-50 орчим хувийг бүрдүүлэгч гол хэсэг байна.

## Хүснэгт 4. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг		2024 он	
		Жилийн төлөвлөгөө	Эхний 6 сард
<b>1</b>	<b>Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ</b>	<b>5357</b>	<b>18</b>
1.1	Үнэт цаас эргэн төлөхөд	1955	666
	Дотоод	562	93
	Гадаад	1393	573
1.2	Зээл эргэн төлөхөд	1332	604
	Дотоод	0	0
	Гадаад	1332	604
1.3	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд	2071	-1287
<b>2</b>	<b>Эх үүсвэрийн бүрдэл</b>	<b>5357</b>	<b>-18</b>
2.1	Шинээр гаргасан үнэт цаас	3713	0
	Дотоод	3713	0
	Гадаад	0	0
2.2	Шинээр авсан зээл	1580	1105
	Дотоод	0	0
	Гадаад	1580	1105
	Төслийн зээл	1225	1105
	Хөтөлбөрийн зээл	355	0
2.3	Тогтворжуулалтын сан	0	0
2.4	Монголбанкинд байрших дансны цэвэр өөрчлөлт	64	-1123


Эх сурвалж: Сангийн яам

## IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

## 4.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв

Цаг агаарын таагүй нөхцөл байдлаас үүдэн хөдөө аж ахуйн салбар огцом унасан хэдий ч энэ онд нийт үйлдвэрлэл 5.5 хувиар өсөх хүлээлттэй байна (Зураг 22). Уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбар энэ онд өсөлтөд чухал нөлөөтэй байх төлөвтэй боллоо. Мөн хөдөө аж ахуй (ХАА)-гаас бусад салбарын идэвхжил нэмэгдсэний зэрэгцээ дотоод эрэлт сайжирч, импортын өсөлт өндөр байгаагаас шалтгаалан татварын орлого бүрдүүлэлт сайн байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Харин өвөлжилт хүндэрч малын хорогдол 2010 оноос хойших хамгийн муу түвшинд хүрснээр ХАА салбар огцом унаж, өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Зураг 22. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (нийт нийлүүлэлт болон нийт эрэлт)



Эх сурвалж: YCX, Монголбанк

Нийт эрэлтийн өсөлт 2024 онд 5.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байна. Өсөлтийн гол хэсгийг өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ бүрдүүлэх төлөвтэй. Өрхийн хэрэглээг бодит орлогын өндөр өсөлт дэмжих бол төсвийн тэлэлт төрийн байгууллагын хэрэглээг нэмэгдүүлж байна. Нүүрсний экспорт энэ оныг дуустал өндөр байж, 78 сая тоннд хүрэхээр хүлээгдэж байгаа болон Оюу толгойн зэсийн экспорт нэмэгдэж байгаа нь энэ оны бодит экспортын өсөлтийг тайлбарлаж байна. Гэвч суудлын автомашин, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн импорт өсөж байгаагаас шалтгаалан 2024 онд импорт эрчтэй нэмэгдэж, нийт эрэлтэд томоохон сөрөг нөлөөг үзүүлэхээр байна.


Эдийн засгийн өсөлтийн дунд хугацааны төсөөллийг авч үзвэл 2025-26 онуудад 30 хувийн итгэх интервалд харгалзан 4.5-9.7 хувь, 2.0-7.8 хувийн орчимд байхаар байна (Зураг 24). Ирэх онд Оюу толгойн цэвэр зэс 60 гаруй хувиар, алтны агууламж 2.4 дахин нэмэгдэхээс гадна нүүрсний олборлолт энэ оны өндөр түвшинд хадгалагдаж, уул уурхайн салбарын өсөлт 18.5 хувьд хүрэхээр байна. Үүний дам нөлөө уул уурхайгаас өндөр хамаарал бүхий салбаруудын өсөлтийг тэтгэхээс гадна төсвийн төлөв сулрах, цаг агаарын нөхцөл байдал олон жилийн дунджийн орчимд хүрэх зэргээс шалтгаалан хөдөө аж ахуй, барилга, бүтээгдэхүүний цэвэр татвар (БЦТ) зэрэг салбаруудын өсөлт сайжирч, нийт эдийн засгийн өсөлт 7.3 хувьд хүрэхээр төсөөллөө. Харин 2026 оноос хөрөнгө оруулалт саарч, төсвийн төлөв чангарах, худалдааны нөхцөл муудаж, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх зэрэг нь өсөлтийн төлөвт сөргөөр нөлөөлнө.

#### 4.2. Инфляцын төлөв

Инфляц 2024 оны эцэст 6 хувийн орчимд хадгалагдах төсөөлөлтэй байна (Зураг 23). Инфляц сүүлийн 8 улирал дараалан буурч байгаа ч цаашдын төлөвийг авч үзвэл 1) зарим бараа бүтээгдэхүүний өмнөх онд өндөр өссөн суурь үеийн нөлөө арилах, 2) өрхийн цахилгаан, дулааны үнэ 11 дүгээр сараас эхлэн өсөх, 3) төсөв тэлж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэх зэргээс шалтгаалан үргэлжлэн буурахааргүй байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ ирэх саруудад улирлын онцлогоо даган буурах, махнаас бусад

дотоодын хүнсний үнийн өсөлт бага байгаагаас хүнсний инфляц оны сүүлийн саруудад 6.5-6.6 хувийн орчимд хадгалагдах төлөвтэй байна. Хүнсний бус инфляц ирэх саруудад алгуур нэмэгдэхээр байгаа бөгөөд үүнд, төгрөгийн ханш алгуур суларч, импортын барааны инфляц өсөх, цахилгаан, дулааны төлбөр нэмэгдэх зэрэг нь гол нөлөөг үзүүлж байна.

Зураг 23. Инфляцын богино хугацааны төсөөлөл, бүрэлдэхүүн хэсгүүдээр<sup>18</sup>



Эх сурвалж: УСХ, Монголбанк


Ирэх онд инфляц 30 хувийн итгэх интервалд 6.8-8.8 хувьд хүрч нэмэгдэх төсөөлөлтэй байна (Зураг 24). Дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ өсөж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, төгрөгийн ханш алгуур сулрах зэрэг нь импортын болон дотоодын хүнсний инфляцыг өсгөхөөр байна. Хүнсний бус инфляцын хувьд уул уурхайн бус салбарын идэвхжил сайжирч эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэх, гадаад үнэ өсөх, өрхийн цахилгаан, дулааны үнийн өсөлтийн суурь нөлөө зэргээс шалтгаалан хүнсний бус инфляц ирэх онд нэмэгдэхээр байна.

Инфляц 2026 онд алгуур буурч 4.8-7.0 хувьд<sup>19</sup>, зорилтын голчийн орчимд тогтворжихоор байна. Үүнд, төсвийн төлөв чангарч, хөрөнгө оруулалтууд буурах нөлөөгөөр уул уурхайн бус салбарын идэвхжил суларч, эрэлтийн гаралтай инфляцын дарамт багасах, гадаад үнэ 2026 оны сүүл хагаст буурах зэргээс шалтгаалан хүнсний бус инфляц саарахаар байна. Дэлхийн хүнсний үнэ үргэлжлэн өсөх хэдий ч дотоодын хүнсний ханган нийлүүлэлт хэвийн байж, аливаа төрлийн шок үүсэхгүй гэж үзсэнээр хүнсний инфляц алгуур буурах төсөөлөлтэй байна.

<sup>18</sup> Үйлчилгээний бүлэгт төрийн зохицуулалттай үйлчилгээ багтана.

<sup>19</sup> 30 хувийн итгэх интервал

Зураг 24. Эдийн засгийн өсөлт, инфляцын дунд хугацааны төсөөлөл



\*4 улирлын нийлбэр ДНБ-ний өсөлт  
Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

### 4.3. Төсвийн бодлогын төлөв

Эдийн засгийн идэвхжил, тэр дундаа уул уурхайн салбарын өсөлт 2023 онд өндөр байсантай холбоотойгоор төсвийн орлого бүрдүүлэлт сайжирч, төсвийн чанга төлөв 2023 онд хадгалагдлаа. Харин энэ онд төсвийн тодотголоор төсвийн зардал батлагдсан дүнгээс 3.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж, төсвийн төлөв сулрах хүлээлттэй байна. Цаашид төсвийн зардал 2025 оны төсвийн өргөн барьсан санал, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан 2026 оны төсвийн төсөөлөлд туссан дүнгээр батлагдвал төсвийн төлөв 2025 онд 0.5 нэгж хувиар суларч, 2026 онд -0.5 нэгж хувиар чангарах тооцоололтой байна (Зураг 25).

Хөдөө аж ахуйгаас бусад салбаруудын үйл ажиллагаа идэвхжиж, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт сайн байгаагаас шалтгаалан энэ онд тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 22.8 хувиар нэмэгдэж, төсвийн алдагдал ДНБ-ий 2.0 хувьд, нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байхаар байна. Ирэх онд эдийн засгийн өсөлт сайжирч, экспортын төсөөлөл нэмэгдэж байгаагаас улбаалан уул уурхайтай холбоотой төсвийн орлого нэмэгдэхээр байгаа бол 2026 онд эрдэс түүхий эдийн үнэ буурч, төсвийн орлогын өсөлт саарахаар байна. Импорттой холбоотой орлогын хувьд дизель түлшний онцгой албан татвар 2025 оноос хэвийн түвшиндээ очихтой холбоотойгоор<sup>20</sup> импортын орлого ирэх оноос нэмэгдэхээр байна. Улмаар ирэх онуудад төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал ДНБ-ий -2.0 хувьд хүрэх, суурь тэнцэл ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байх хүлээлттэй байна.

Энэ онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дагуу энэ оноос төсвийн тусгай шаардлагад өөрчлөлт орсон. Тухайлбал, нэгдсэн төсвийн нийт зарлагын хувьд хязгаарладаг байсныг урсгал зарлагын хэмжээгээр хязгаарладаг болсон<sup>21</sup>. Мөн засгийн газрын өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр тооцдог байсныг өөрчлөн нэрлэсэн дүнгээр тооцохоор болсон. Үүнээс гадна нэгдсэн төсвийн суурь зарлага болон


<sup>20</sup> Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай хуулийн 1 дэх зүйлд зааснаар дизелийн түлшний онцгой албан татварыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл тэглэсэн.

<sup>21</sup> Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх



суурь тэнцэл<sup>22</sup> гэх ойлголтыг шинээр нэвтрүүлж, суурь тэнцэл ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэх хязгаарлалтыг нэмсэн бөгөөд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, суурь тэнцлийн хувьд хоёр төрлийн хязгаарлалттай болсон байна.

Зураг 25. Төсвийн импульс




Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

#### 4.4. Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлөв


**Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн хоёр жил орчим хугацаанд эрчимжих хандлагатай байв.** Өнгөрсөн оны сүүлийн улирлуудад валютын орох урсгал нэмэгдсэнтэй холбоотойгоор банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжих гол хүчин зүйл болов. Харин энэ онд нэг талаас ГЦА-ын өсөлт саарсан боловч нөгөө талаас зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж байна. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 30.4 хувьд хүрэхэд гадаад цэвэр актив (ГЦА) 14.0 нэгж хувь, зээлийн өсөлт 25.8 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлжээ. Нөгөө талаас эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор төсвийн орлого сайжирч, нэгдсэн төсвийн тэнцэл энэ оны эхний 7 сарын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай байгаагаас Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна.

<sup>22</sup> Нэгдсэн төсвийн суурь зарлага=Нийт зарлага-Үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардал  
Төсвийн суурь тэнцэл=Тэнцвэржүүлсэн орлого-Суурь зарлага

Зураг 26. М2 мөнгөний өсөлт, актив



Зураг 27. М2 мөнгөний өсөлт, пассив



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр голлон бүрдүүлж байна (Зураг 27). Тодруулбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 29.6 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж бүрдүүлж байгаа бол гадаад валютын харилцах, хадгаламж 0.4 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд, сүүлийн улирлуудад гадаад валютын ханш харьцангуй тогтвортой байгаагаас гадна инфляц буурч, төгрөгийн бодит өгөөж эерэг түвшинд байгаа нь нөлөөлж байна. Улмаар сүүлийн жил гаруй хугацаанд төгрөгийн хадгаламж эрчтэй нэмэгдсэн бол гадаад валютын эх үүсвэрийн өсөлт нам түвшинд хадгалагдлаа.

Банкны системийн эх үүсвэрийн долларжилт буурах хандлага үргэлжилж, 2024 оны 7 дугаар сард 23.6 хувьд хүрчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6.8 нэгж хувиар бага дүн юм. Харин ханшийн нөлөөг хасаж тооцвол эх үүсвэрийн долларжилт 19.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 нэгж хувиар буурав (Зураг 28).


Нийт зээлийн өсөлт<sup>23</sup> сүүлийн 6 улирлын турш эрчимжих хандлагатай байна. Тухайлбал, үнэт цаасжуулсан ипотекийн зээлийг оруулсан нийт зээлийн өсөлт өнгөрсөн оны 7 дугаар сард 11.2 хувьд хүрээд байсан бол энэ оны 7 дугаар сард 29.3 хувьд хүрч нэмэгджээ. Зориулалтаар нь авч үзвэл, хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 39.0 хувьд, ипотекийн зээлийн өсөлт<sup>24</sup> 25.9 хувьд, бизнесийн зээлийн өсөлт 25.8 хувьд хүрч, зээлийн өсөлт бүх төрлийнхөө хувьд нэмэгдэв. Үүнд, өнгөрсөн оны 6 дугаар сард болон энэ оны 4 дүгээр сард нийт хоёр удаа төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр өссөн, ипотекийн зээлийн санхүүжилтийн дүн нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил сайн<sup>25</sup> байгаагаас гадна Засгийн газрын хүүний хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь зээлийн өсөлтийг дэмжиж байна. Валютын төрлөөр нь авч үзвэл банкны системийн төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 36.6 нэгж хувиар нэмэгдэж, зээлийн долларжилт сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд 6 хувийн орчимд тогтвортой байна.

<sup>23</sup> (Зээл+ИЗББ)-н өсөлт


<sup>24</sup> (Ипотек+ИЗББ)-н өсөлт

<sup>25</sup> 2024 оны эхний хагаст эдийн засаг 5.6 хувиар өссөн бөгөөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын өсөлт 9.4 хувьд хүрэв.

Зураг 28. Банкны системийн долларжилт



Зураг 29. Нийт зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт алгуур саарах төлөвтэй байна. Үүнд, төлбөрийн тэнцлийн төсөөлөлтэй уялдан банкны системийн ГЦА-ын өсөлт саарахаар байгаа нь голлон нөлөөлж байна ( Зураг 26). Нөгөө талаас төсвийн зардал нэмэгдэн төсвийн төлөв суларч, Засгийн газрын дотоод санхүүжилтийн шаардлага нэмэгдэхээр байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Ирэх онуудад мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг ЗГЦЗ болон зээлийн өсөлт голлон тэтгэхээр байгаа бол ГЦА-ын мөнгөний нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө буурч, улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарах төлөвтэй байна. Зээлийн өсөлтийн хувьд энэ онд болон ирэх онд өндөр түвшинд хадгалагдах бол 2026 онд эдийн засгийн идэвхжил, төлбөрийн тэнцэлтэй уялдан саарах хүлээлттэй байна.

Цаашид геополитикийн эрсдэл, гадаад худалдааны нөхцөлтэй холбоотойгоор төлбөрийн тэнцэл, төсвийн төлөв болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, арилжааны банкуудын зээлийн нөхцөл, шалгуур хэрхэн өөрчлөгдөхөөс зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн төлөв хамаарна.

#### ШИГТГЭЭ 4. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээ

Хөрөнгийн урсгалын матриц шинжилгээний аргачлал нь эдийн засгийн 4 сектор буюу Засгийн газар, хувийн сектор, гадаад сектор болон санхүүгийн салбар хооронд тодорхой хугацаанд шилжиж буй хөрөнгийн урсгалыг шинжилдэг. Энд 2023 оны байдлаар сектор бүрт үүссэн хөрөнгийн илүүдэл болон дутагдлыг тодорхойлж, дутагдалтай салбарууд нь алдагдлаа хөрөнгийн илүүдэлтэй бусад салбаруудын хөрөнгөөр хэрхэн санхүүжүүлж, нөөцийн шилжилт хэрхэн хийгдсэнийг санхүүгийн бус болон санхүүгийн тэнцлээр харуулах юм. Санхүүгийн бус тэнцлээр засгийн газрын болон хувийн хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалтын балансыг ерөнхий байдлаар харуулж эдийн засагт хэдий хэмжээний хөрөнгийн дутагдал бий болж, гадаад эх үүсвэрээр санхүүжүүлснийг тодорхойлно. Гадаад санхүүжилт нь эдийн засгийн потенциалыг ирээдүйд нэмэгдүүлэх ач холбогдолтой боловч хэт их байх нь эргээд ирээдүйн хэрэглээг хумих, өрийн дарамтанд орох зэргээр эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг.

Харин санхүүгийн тэнцлийн хувьд хөрөнгийн дутагдлыг гадаад, дотоод ямар эх үүсвэрээр яаж санхүүжүүлсэн бэ гэдгийг сектор бүрийн хувьд санхүүгийн зуучлагчдын балансаар дамжуулан дэлгэрэнгүй авч үздэг.

**А. Санхүүгийн бус тэнцэл**<sup>26</sup>: Эдийн засгийн харьяатууд 2023 онд 64.8 их наяд төгрөгийн цэвэр орлоготой ажилласнаас, орлогынхоо ихэнх хэсэг буюу 63 орчим хувийг (40.5 их наяд төгрөг) хэрэглээндээ зарцуулав. Улмаар нийт хадгаламж<sup>27</sup> 24.3 их наяд төгрөгт хүрч, үүнээс 23.9 их наяд төгрөгийн нийт хөрөнгө оруулалтыг санхүүжүүлснээр илүүдэл 420 тэрбум төгрөгийг гадаад секторт байршуулжээ. Ийнхүү, дотоод эдийн засагт хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү 16 жилийн дараа эерэг гарч, урсгал тэнцэл уг дүнгээр (ДНБ-ий 0.6 хувь) ашигтай гарчээ.

Засгийн газар болон хувийн сектороор нь ангилан авч үзвэл, Засгийн газар орлогынхоо 67 хувийг хэрэглэсэн бол хувийн сектор орлогынхоо 61.3 хувийг хэрэглэсэн байна.

**Засгийн газар** өнгөрсөн онд 13.7 их наяд төгрөгийг татварын цэвэр орлого хэлбэрээр бүрдүүлж, үүний 67 хувьтай тэнцэх буюу 9.2 их наяд төгрөгийг хэрэглээндээ зарцуулсан бол 3.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гаргажээ. Ийнхүү Засгийн газрын хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү 763 тэрбум төгрөг байв.

**Хувийн сектор**: Хувийн секторын цэвэр орлого 2023 онд 51.1 их наяд төгрөг байж, үүнийхээ 61.3 хувийг буюу 31.4 их наяд төгрөгийг хэрэглэсэн байна. Харин хөрөнгө оруулалтад 20.1 их наяд төгрөгийг зарцуулснаар, хувийн секторт хадгаламжаасаа 343 тэрбум төгрөгөөр илүү санхүүжилт шаардлагатай болжээ.

<sup>26</sup>  $[GNDI = C + I + (X - M) + Y_f + Y_r] \Rightarrow [GNDI - C - I = CAB] \Rightarrow [S - I = CAB] \Rightarrow [(S_g - I_g) + (S_p - I_p) = CAB]$ .

Энд  $Y$  – Үндэсний цэвэр орлого,  $X$  – Нийт экспорт,  $M$  – Нийт импорт,  $Y_f$  – Төлбөрийн тэнцлийн анхдагч орлого,  $Y_r$  – Төлбөрийн тэнцлийн хоёрдогч орлого,  $GNDI$  – Үндэсний нийт цэвэр орлого,  $C$  – Эцсийн хэрэглээ,  $I$  – Нийт хөрөнгө оруулалт,  $CAB$  – Урсгал тэнцэл,  $S$  – Дотоодын нийт хуримтлал,  $S_g$  – Засгийн газрын хуримтлал,  $I_g$  – Засгийн газрын хөрөнгө оруулалт,  $S_p$  – Хувийн секторын хуримтлал,  $I_p$  – Хувийн секторын хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

<sup>27</sup> Цэвэр орлого-Хэрэглээ

## Хүснэгт 5. Эдийн засгийн секторууд хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээний матриц, тэрбум төгрөгөөр

Гүйлгээ/Салбарууд	Дотоод эдийн засаг	Дотоод эдийн засгийн салбарууд						Гадаад сектор	ХӨНДЛӨН ШАЛГАЛТ
		Засгийн газар	Хувийн сектор	Санхүүгийн сектор	Үүнээс				
					Төв банк	Банк	Бусад санхүүгийн байгууллага		
<b>ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО (I)</b>	<b>64824</b>	<b>13676</b>	<b>51148</b>					<b>0.0</b>	
Эцсийн хэрэглээ (II)	40524	9162	31362					0.0	
Нийт хөрөнгө оруулалт (III)	23880	3751	20129					0.0	
Экспорт	53750						-53750		
Импорт	-46966						46966	0.0	
Хүчин зүйлсийн орлого	-7742						7742	0.0	
Шилжүүлэг (цэвэр)	1379						-1379	0.0	
<b>A. САНХҮҮГИЙН БУС ТЭНЦЭЛ (I-II-III)</b>	<b>420</b>	<b>763</b>	<b>-343</b>				<b>-420</b>	<b>0.0</b>	
<b>1. ГАДААД САНХҮҮЖИЛТ</b>	<b>6648</b>	<b>1215</b>	<b>7734</b>	<b>-2301</b>			<b>-2301</b>	<b>-6648</b>	<b>0.0</b>
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>4979</b>	<b>123</b>	<b>7270</b>	<b>-2414</b>			<b>-2414</b>	<b>-4979</b>	<b>0.0</b>
ГШХО	7530		7530					-7530	0.0
Санхүүгийн ХО	-3078	123	-727	-2414			-2414	3078	0.0
Хөрөнгийн данс	468		468					-468	0.0
Гадаад цэвэр зээл	<b>1633</b>	<b>1092</b>	<b>-532</b>	<b>113</b>			<b>113</b>	<b>-1633</b>	<b>0.0</b>
Бэлэн валют, харилцах	-69		-69					69	0.0
<b>2. ДОТООД САНХҮҮЖИЛТ</b>		<b>-2184</b>	<b>-6511</b>	<b>8695</b>	<b>6535</b>	<b>-110</b>	<b>2270</b>		<b>0.0</b>
Дотоод зээл		-3278	5344	-2065	1692	-4689	932		0.0
Засгийн газрын цэвэр зээл		-3278	0	3278	1561	266	1451		0.0
Зээл, үнэт цаас			5344	-5344	131	-4955	-519		0.0
Нийт мөнгө			-7611	7611	71	7268	271		0.0
Санхүүгийн байгууллага хоорондын хөрөнгийн урсгал					5310	-5241	-69		0.0
Төв банк					3718	4319	601		0.0
Банк					1344	-922	-422		0.0
БСБ					248		-248		0.0
Бусад цэвэр зүйлс		1095	-4025	-3150	-538	25551	1137		0.0
<b>3. ГЦАКТИВЫН ӨӨРЧЛӨЛТ (-)</b>	<b>6457</b>			<b>6457</b>	<b>6529</b>	<b>-72</b>	<b>0</b>	<b>-6457</b>	<b>0.0</b>
Гадаад актив (+)	5513			5513	5095	418	0	-5513	0.0
Гадаад пассив (ОУВС-гийн зээл орсон) (-)	-944			-944	-1434	490	0	944	0.0
<b>Б. САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ (1+2-3)</b>	<b>191</b>	<b>-969</b>	<b>1222</b>	<b>-63</b>	<b>6</b>	<b>-38</b>	<b>-31</b>	<b>-191</b>	<b>0.0</b>
<b>В. АЛДАА БА ЗАЛРУУЛГА</b>	<b>-611</b>	<b>-205</b>	<b>-879</b>	<b>63</b>	<b>-6</b>	<b>38</b>	<b>31</b>	<b>611</b>	<b>0</b>
<b>БОСОО ШАЛГАЛТ (А+Б+В)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

Тэмдэглэгээ: Гадаад болон дотоод санхүүжилтийн хувьд (+) тэмдэгтэй байгаа нь өр төлбөр болоод хөрөнгө нэмэгдсэнийг<sup>28</sup> илэрхийлнэ. Харин гадаад цэвэр активын хувьд (+) тэмдэг нь гадаад актив нэмэгдэх, гадаад өр төлбөр буурсан болохыг илтгэнэ<sup>29</sup>. Төлбөрийн тэнцэл, нэгдсэн төсөв болон мөнгөний тоймын статистик хоорондын зөрүү, алдаа, орхигдуулга, валютын ханишийн зөрүү зэрэг нь цэвэр алдаа ба залруулгыг тайлбарлана.

<sup>28</sup> Хөрөнгө болон өр төлбөр буурсан бол (-) тэмдэгтэй байна.

<sup>29</sup> (-) тэмдэг нь гадаад актив буурах/ гадаад өр төлбөр нэмэгдсэн болохыг илэрхийлнэ.

## **Б. Санхүүгийн тэнцэл.**

**1. Гадаад санхүүжилт:** Дотоод эдийн засгийн салбарууд гадаад сектороос нийт 6.6 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгийн урсгалыг хүлээн авснаас хувийн сектор 7.7 орчим их наяд төгрөгийг бүрдүүллээ. Нийт гадаад санхүүжилтийн дүн дотоодын санхүүгийн бус тэнцлээс их байгаа нь төлбөрийн тэнцлийн ашигтай холбоотой бөгөөд энэ нь гадаад цэвэр активыг нэмэгдүүлнэ.

Хувийн сектор гадаад зах зээлээс **цэвэр дүнгээр** нийт 7.7 орчим их наяд төгрөгийн эх үүсвэр татсаны дийлэнх нь ГШХО хэлбэртэй байна. Тухайлбал, хувийн сектор 7.5 их наяд төгрөгийн ГШХО татсан бөгөөд үүний 99 орчим хувь нь Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчийн зээлтэй холбоотой хүүний аккруэль байна. Түүнчлэн хувийн сектор цэвэр дүнгээр 532 тэрбум төгрөгийн гадаад зээлийг татан төвлөрүүлэв.

**Засгийн газар** гадаад эх үүсвэрээс цэвэр дүнгээр 1.2 их наяд төгрөгийн хөрөнгийг татжээ. Үүнд, цэвэр дүнгээр гадаад зээлээр 1.1 их наяд төгрөг, гадаад бондоор 123 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ.

**2.** Дотоод санхүүжилтийн хэсэгт сектор хоорондын санхүүгийн хөрөнгийн урсгалыг харуулдаг. Дотоод эдийн засагт **Засгийн газар болон хувийн сектороос** цэвэр дүнгээр хөрөнгө шилжсэн бол **санхүүгийн сектор** хөрөнгө хүлээн авсан байна. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 763 тэрбум төгрөгийн ашигтай гарсан тул Засгийн газар энэхүү ашиг болон гадаад зээлээр татан төвлөрүүлсэн хөрөнгөө санхүүгийн секторт байршуулав. Түүнчлэн, ирээдүй өв сан болон тогтворжуулалтын сантай холбоотой 1.1 их наяд төгрөгийг дотоод эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн байна.

Хувийн сектор санхүүгийн сектороос 5.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг зээл, үнэт цаас хэлбэрээр авсан бол 7.3 их наяд төгрөгийн хөрөнгийг арилжааны банкуудад харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулжээ. Түүнчлэн, санхүүгийн сектор дотроо цэвэр дүнгээр арилжааны банкнаас 5.2 их наяд төгрөгийн хөрөнгө (үүний 3.1 их наяд нь ТБҮЦ), бусад санхүүгийн байгууллагаас 69 тэрбум төгрөг Төв банк руу шилжжээ.

**3. Санхүүгийн секторын гадаад цэвэр активын өөрчлөлт** 6.5 их наяд төгрөг байгаа нь Төв банк болон арилжааны банкнуудын гадаад цэвэр актив тус дүнгээр нэмэгдсэнийг илэрхийлнэ. Тухайлбал, арилжааны банкны хувьд гадаад цэвэр актив 72 тэрбум төгрөгөөр буурсан нь энэ дүнгээр арилжааны банкуудын гадаадад байршуулсан хөрөнгө цэвэр дүнгээр буурсныг илтгэнэ. Харин Төв банкны гадаад цэвэр актив 6.5 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд гадаад актив 5.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж, гадаад пассив 1.4 их наяд орчим төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

### **Дүгнэлт:**

Дотоод эдийн засагт хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү буюу урсгал тэнцэл 2023 онд 420 тэрбум төгрөгийн ашигтай буюу сүүлийн 16 жилд анх удаа эерэг дүнтэй гарсан байна. Өөрөөр хэлбэл, дотоодын хадгаламж хөрөнгө оруулалтдаа хүрэлцэн, уг хэмжээний илүүдэл хөрөнгийг гадаадад байршуулсан буюу эдийн засагт гадаад санхүүжилтийн шаардлага бага байв. Түүнчлэн, 2023 онд төсвийн тэнцэл ашигтай байснаас гадна арилжааны банкуудын төгрөгийн эх үүсвэр эрчтэй нэмэгдсэн нь бусад дотоодын секторуудаас санхүүгийн секторт шилжих хөрөнгийн урсгалыг нэмэгдүүллээ.

#### **4.5. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв**

**Гадаад валютын орох, гарах урсгал энэ онд тэнцвэржих төлөвтэй боллоо.** Экспортын орлого 2024 онд өмнөх оноос 1 тэрбум ам.доллаар нэмэгдэх хэдий ч импортын барааны зардал 2.7 тэрбум ам.доллаар тэлэх төсөөлөлтэй байна. Гадаад эрэлт таатай байж, нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны түвшнээс давахын<sup>30</sup> зэрэгцээ олон улсын зах зээлд зэс, алтны үнэ өсөж байгаа нь экспортын орлогыг тэтгэж байна.

Нөгөө талаас, уул уурхайн экспортын өсөлт, эдийн засгийн идэвхжилтэй уялдан импортын өсөлт бүх дэд бүлгийн хувьд эрчимжиж байна. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспортын биет хэмжээ өндөр байгаа нь дизель түлшний импортыг нэмэгдүүлэхээс гадна том оврын машин, механизмын импортын эрэлтийг өдөөж байна. Цаашлаад төсвийн зардал нэмэгдэж буй нь хэрэглээний болон хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлж, эхний 7 сарын байдлаар нийт импорт жилийн 27 хувиар өслөө. Оны үлдсэн хугацаанд экспорт болон импортын одоогийн төлөв хадгалагдах хүлээлттэй байгаа тул урсгал дансны алдагдал өмнөх оноос 2 орчим тэрбум ам.доллаар тэлэхээр байна.

Санхүүгийн дансны ашиг энэ онд өмнөх оноос 300 орчим сая ам.доллаар нэмэгдэхээр байна. Тухайлбал, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт болон Голомт банкны олон улсын зах зээлд гаргасан гадаад бондын эх үүсвэр энэ оны санхүүгийн дансны орох урсгалыг бүрдүүллээ.

**Төлбөрийн тэнцэл ирэх онд тэнцлийн орчимд байж, ГВАН 2024 оны түвшинд хадгалагдах суурь төсөөлөлтэй байна.** Суурь төсөөллөөр экспортын орлого нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал өмнөх оноос 400 гаруй сая ам.доллаар сайжрах хүлээлттэй. Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл жигдэрснээр зэсийн экспортын биет хэмжээ нь 2024 оноос 20 хувиар нэмэгдэж, баяжмал дахь алтны агууламж өмнөх оноос 2 дахин өсөхөөр байгаа нь экспортын орлогыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болохоор байна. Түүнчлэн олон улсад алт, зэсийн үнэ 2024 оны түвшинд хадгалагдахаар хүлээгдэж буй нь экспортын орлогод эерэг нөлөөлнө. Харин нүүрсний биет хэмжээ өмнөх оны түвшинд хадгалагдах таамаглалтай байгаа хэдий ч үнэ буурах хандлагатай байгаа тул нүүрсний экспортын орлого 2025 онд багасахаар байна. Ирэх оны төсвийн зардлын өсөлт, томоохон дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилт нь импортын өсөлтийг ихээхэн дэмжихээр байна.

Санхүүгийн дансны ашиг ирэх онд буурах тооцоололтой байна. Үүнд, шууд хөрөнгө оруулалтын голлох орох урсгалыг бүрдүүлж буй Оюу толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлууд дуусаж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу буурахаар байна. Ирэх онд санхүүгийн дансны орох урсгалыг Засгийн газрын гадаад зээл голлон бүрдүүлэх төлөвтэй. Хэрэв эдгээр гадаад зээлийн санхүүжилт хойшлох, хэмжээ буурах нөхцөл үүссэн тохиолдолд орох урсгал улам хумигдана.

**Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарах эрсдэлүүд бий.** Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ, худалдааны түнш орнуудын нөхцөл байдал хүлээлтээс муудвал төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтын зардал хэт импортод суурилсан шинжтэй байвал урсгал дансны алдагдлыг огцом нэмэгдүүлэх эрсдэлтэй.

<sup>30</sup> Эхний 7 сарын байдлаар чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 46.1 сая тн байгаа нь өмнөх оны мөн үеэс 36 хувиар өндөр үзүүлэлт юм.

#### 4.6. Инфляцын гол эрсдэлүүдэд суурилсан хувилбар төсөөлөл

Инфляц суурь төсөөллөөс өөрчлөгдөж болзошгүй гадаад, дотоод голлох эрсдэлүүдэд үндэслэн; 1) Төсвийн зардал 2025 онд өргөн барьсан төсвийн дүнгээр батлагдах, 2) Аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын цахилгаан эрчим хүчний үнэ өсөх, 3) Нүүрсний үнэ буурах гэсэн хувилбар төсөөллүүдийг боловсрууллаа. Эдгээр нөхцөл байдал үүсвэл инфляц болон эдийн засгийн бусад үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг суурь төсөөлөлтэй харьцуулан тайлбарлав.

**Хувилбар 1.** Ирэх оны улсын төсөв өргөн барьсан дүнгээр батлагдах буюу энэ оны төсвийн тодотголтой хамт батлагдсан 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн дүнгээс 2.9 их наяд төгрөгөөр нэмэгдэх тохиолдолд эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцлоо. Төсвийн зардал тэлэх нь импортыг өсгөж, валютын гарах урсгалыг нэмэгдүүлэх хэдий ч нөгөө талдаа гадаад зах зээлд нийслэлийн бонд арилжаалж, зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байгаа тул төлбөрийн тэнцэлд томоохон өөрчлөлт орохооргүй байна. Төсвийн зардал тэлэх нь хэрэглээ, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар нийт эрэлтийг дэмжиж, эдийн засгийн өсөлт 2025 онд 1.1 нэгж хувиар сайжрах төсөөлөлтэй байна. Эдийн засгийн идэвхжил нэмэгдэх нөлөөгөөр инфляц 2025-2026 оны эцэст суурь төсөөллөөс 1.3 нэгж хувиар, 0.4 нэгж хувиар тус тус нэмэгдэж, бодлогын хүүг өсгөх шаардлага үүснэ (Зураг 30).


**Хувилбар 2.** ААНБ-ын цахилгааны төлбөр 11 дүгээр сарын 1-нээс 30 хувиар нэмэгдэх тохиолдолд бусад үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөхийг тооцлоо. Ийнхүү цахилгааны төлбөр нэмэгдэх нь үйлдвэрлэлийн орцын үнийн өсөлтөөр дамжин бараа, үйлчилгээний үнийг нэмэгдүүлж, инфляц суурь төсөөллөөс 2024-25 оны эцэст 0.8 нэгж хувь, 0.4 нэгж хувиар тус тус өснө<sup>31</sup>.

**Хувилбар 3.** БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл үргэлжилж, эдийн засгийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор нүүрсний үнэ буурах таамаглалыг шинжээчид гаргаад байна. Нүүрсний үнэ хурдтай буурах буюу 2025 онд дундаж үнэ тонн тутамд 85 ам.долларт хүрч суурь төсөөллөөс 10 ам.доллараар буурахад эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцлоо. Нүүрсний үнэ буурснаар төлбөрийн тэнцэл 800 орчим сая ам.доллараар муудаж, ханш сулрах дарамт нэмэгдэх ба төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025-2026 оны эцэст 130-150 орчим төгрөгөөр сул тогтохоор байна. Төгрөгийн ханш суларч, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өссөнөөр инфляц 2025-2026 оны эцэст харгалзан 1.7 нэгж хувь, 1.2 нэгж хувиар тус тус нэмэгдэнэ.

<sup>31</sup> Ургамалсувд ба Алтанзул (2024) нарын судалгааны үр дүнг ашиглан дам нөлөөг тооцов.



Зураг 30. Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөллүүд



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 6. Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөллүүд

Хувилбарууд	Авч үзсэн нөхцөлүүд	Инфляц**			
		2023	2024*	2025*	2026*
Суурь	Суурь төсөөлөл	9.1	6.0	7.7	5.6
X1	2025 оны төсөв өргөн барьсан дүнгээр батлагдах	9.1	6.3	9.0	6.2
X2	Цахилгаан, дулааны үнийн дам нөлөө	9.1	6.8	8.1	5.1
X3	Нүүрсний үнэ буурах	9.1	6.4	9.4	6.4

\*\*Он тус бүрийн 4 дүгээр улирлын дундаж инфляц  
Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

### Хүснэгт 7. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд

								2024	2025	2026
	2018	2019	2020	2021	2022	2023	2024.07*	Төсөөлөл**		
<b>Бодит сектор</b>	жилийн өсөлтийн хувь									
Бодит ДНБ	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	5.6	5.5 <sup>^</sup>	7.3 <sup>^^</sup>	4.8 <sup>^^^</sup>
Уул уурхайн ДНБ	5.4	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4	15.4	17.4	18.5	4.5
Уул уурхайн бус ДНБ	8.2	6.9	-3.7	1.8	8.2	5.4	4.2	3.8	5.5	4.9
Инфляц, хугацааны эцэст	8.1	5.2	2.3	13.8	13.2	7.9	5.5	6.0	7.7	5.6
ДНБ-ний дефлятор	8.0	10.0	3.7	14.4	17.7	19.5	16.0	9.6	7.5	4.8
<b>Нэгдсэн төсөв</b>	их наяд төгрөгөөр									
Нийт орлого	10.1	11.9	10.4	14.3	18.6	24.3	17.6	30.5	34.6	36.6
Тэнцвэржүүлсэн орлого	9.2	10.8	9.4	12.7	17.2	23.2	16.8	28.5	30.3	32.3
Татварын орлого	8.2	9.7	8.5	11.3	15.6	21.5	15.8	26.5	28.0	29.7
Татварын бус орлого	1.0	1.1	0.9	1.4	1.6	1.8	1.0	2.0	2.3	2.6
Нийт зардал ба цэвэр зээл	9.2	11.4	14.0	15.6	18.2	22.5	15.3	30.1	32.1	34.4
Урсгал зардал	7.3	8.2	10.9	12.8	14.2	17.0	12.1	22.4	23.8	25.5
Хөрөнгийн зардал ба зээл	1.9	3.2	3.1	2.8	4.0	5.4	3.1	7.7	8.3	8.9
Хөрөнгийн зардал	1.6	2.8	3.1	3.0	3.8	5.2	2.9	7.8	8.3	8.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0.3	0.4	0.0	-0.2	0.2	0.2	0.2	0.0	-0.1	-0.1
Тэнцвэржүүлсэн тэнцэл	0.0	-0.6	-4.5	-2.9	-1.0	0.8	1.6	-1.6	-1.8	-2.0
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцээс тооцсон)	1.1	0.2	-3.6	-2.1	-0.2	1.9	2.4	-0.5	-0.7	-0.8
Шаардлагатай санхүүжилт	2.7	1.2	7.4	7.0	2.4	4.4	-0.2	3.7	3.6	5.9
Дотоод эх үүсвэр	1.3	-0.3	2.3	2.9	0.7	-1.1	-1.3	1.6	1.9	2.4
Гадаад эх үүсвэр	1.4	1.5	5.1	4.1	1.7	5.4	1.1	2.0	1.7	3.5
	ДНБ-д эзлэх хувиар									
Тэнцвэржүүлсэн орлого	28.3	28.5	25.2	29.1	31.9	33.7	21.1	35.8	32.9	32.1
Нийт зардал ба цэвэр зээл	28.3	30.2	37.3	35.8	33.8	32.6	19.2	37.8	34.9	34.1
Тэнцвэржүүлсэн тэнцэл	0.0	-1.7	-12.1	-6.7	-1.8	1.1	2.0	-2.0	-2.0	-2.0
<b>Мөнгө, зээл</b>	жилийн өсөлтийн хувь									
M2 мөнгө	22.8	7.0	17.5	13.8	6.5	26.8	30.4	25.3	21.7	14.0
Зээл+ИЗББ	24.3	4.5	-4.0	19.5	7.5	22.5	29.2	27.1	22.0	16.3

\*БДНБ-ний өсөлт, ДНБ-ний дефлятор 2024 оны 2 дугаар улирлаар

\*\*2025, 2026 оны төсвийн зардыг 2024 оны төсвийн тодотголтой хамт өргөн баригдсан "2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-д тусгагдсан дүнгээр авав.

<sup>^</sup> - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(4.9) - (7.1)]

<sup>^^</sup> - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(5.3) - (10.0)]

<sup>^^^</sup> - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(2.3) - (7.8)]


Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

## V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


### 5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл

Мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлт сүүлийн улирлуудад эрчимжих хандлагатай байв. Тухайлбал, өнгөрсөн оны 2 дугаар улиралд 13.9 хувьд хүрээд байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт энэ оны 2 дугаар улиралд 31.9 хувьд хүрч нэмэгдсэн байна (Зураг 31). Өнгөрсөн оны сүүлийн хагаст төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжихэд голлон нөлөөлсөн бол энэ онд зээлийн өсөлт, ялангуяа бизнес болон ипотекийн зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжих гол шалтгаан болов. Нөгөө талаас төсвийн орлого бүрдүүлэлт сайн байгаагаас нэгдсэн төсвийн тэнцэл 2024 оны эхний 6 сарын байдлаар 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ), улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлж байна. Улмаар гадаад цэвэр актив (ГЦА) болон зээл мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 43.1 нэгж хувийг бүрдүүлж байгаа бол ЗГЦЗ -7.3 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүллээ.

Зураг 31. M2 мөнгөний өсөлт, актив




Зураг 32. M2 мөнгөний өсөлт, эх үүсвэр




Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас төгрөгийн харилцах, хадгаламж эрчтэй нэмэгдэж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байна (Зураг 32). Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 31.9 хувьд хүрэхэд 27.2 нэгж хувийг төгрөгийн эх үүсвэр, 3.9 нэгж хувийг гадаад валютын эх үүсвэр бүрдүүлэв. Ийнхүү төгрөгийн эх үүсвэрийн өсөлт эрчимжиж, гадаад валютын эх үүсвэр харьцангуй тогтвортой байгаа нөлөөгөөр банкны системийн эх үүсвэрийн долларжилт сүүлийн 3 улирлын турш буурч, 2024 оны 2 дугаар улирлын эцэст 24.6 хувьд хүрлээ (Зураг 33). Энэ нь өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар бага дүн юм. Харин ханшийн нөлөөг хасаж тооцвол эх үүсвэрийн долларжилт 20.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 нэгж хувиар буурлаа. Зээлийн долларжилтын хувьд сүүлийн 2 жил гаруйн хугацаанд 6-7 хувийн орчимд тогтвортой байна.

Зураг 33. Банкны системийн долларжилт



Зураг 34. Банкны системийн зээлийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн өсөлт эрчимжих хандлага үргэлжилж, зээлийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 31.2 хувьд хүрлээ (Зураг 34). Өнгөрсөн оны сүүлийн хагаст төсвийн тодотголтой холбоотой цалин, тэтгэвэр нэмэгдэж, хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл эрчтэй өссөн нь нийт зээлийн өсөлтийг голлон тэтгэж байв. Харин энэ онд ипотек болон бизнесийн зээлийн өсөлт нэмэгдсэн нь банкны системийн зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжих гол шалтгаан боллоо. Тодруулбал, 2024 оны эхний 6 сарын байдлаар Засгийн газраас нийт 650 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг<sup>32</sup> аж ахуй нэгжүүдэд олгосон нь бизнесийн зээлийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв. Түүнчлэн, энэ оны ипотекийн зээлийн санхүүжилт өндөр<sup>33</sup> байгаагаас зээл олголт нь эрчимжиж, ипотекийн зээлийн өсөлт нэмэгдэж байна. Эдийн засгийн салбараар нь харвал зээлийн өсөлтийг хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл, үл хөдлөх, худалдаа болон үйлчилгээний салбарын зээл голлон бүрдүүлж байна.

Банкны системийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл буурч, зээлийн чанар сайжирлаа. Тухайлбал, анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар улиралд 1.2 орчим их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар, чанаргүй зээлийн үлдэгдэл 2.0 орчим их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар тус тус буурав. Улмаар банкны системийн нийт эргэн төлөлтийн доголдолтой зээл 3.2 их наяд төгрөгт хүрэн, нийт зээлийн багцын 9.6 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.3 нэгж хувиар буурсан дүн юм.

<sup>32</sup> Энэ онд “Ноолуур бэлтгэлийн зээл”-ийн хүрээнд 137 тэрбум төгрөг, “Хүнс болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих” хүрээнд 300 тэрбум төгрөг, “Аялал жуулчлалын салбарыг дэмжих” хүрээнд 18 тэрбум төгрөг, “Хоршооны гишүүн малчдын зээл”-ийн хүрээнд 193 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгоод байна.

<sup>33</sup> Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 4 сарын 19-ны өдөр батлагдсантай холбогдуулан тус сангаас 500 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэв. Улмаар энэ онд нийт 1250 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн санхүүжилтэд зарцуулах төлөвлөгөөтэй байгаа нь 2016-2023 оны дундаж санхүүжилтийн дүнгээс 2 дахин өндөр дүн юм.

## Хүснэгт 8. Мөнгөний тойм

Мөнгөний тойм	(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)											
	2019	2020	2021	2022	2023	2024				2025	2026	
	Q4	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	М07	Q3	Q4	Q4	
	Гүйцэтгэл					Төсөөлөл						
M2 мөнгө	20834	24220	27863	29665	37624	37400	41467	41754	45246	47156	57371	65407
M1 мөнгө	3904	4197	6507	7201	9853	9789	11807	12093	13104	13657	16616	18943
Банкнаас гадуурх мөнгө	614	753	847	831	906	827	1040	975	1057	1102	1340	1528
Харилцах ₮	3290	3444	5660	6370	8948	8962	10768	11117	12047	12555	15275	17415
Бараг мөнгө	16930	20023	21356	22463	27771	27611	29660	29662	32142	33498	40756	46464
Хадгаламж ₮	11120	13398	15039	12607	17125	18146	19631	20004	21677	22592	27486	31336
Хадгаламж \$	3484	4642	3973	4910	4999	4497	4601	4536	4916	5123	6233	7106
Харилцах \$	2326	1983	2345	4947	5647	4967	5428	5121	5549	5783	7036	8022
Гадаад цэвэр актив	1847	5356	3806	832	8972	9775	9865	10051	10475	10306	10451	8574
Төв банкны	5182	6273	4892	2434	11140	12172	12956	12582	13561	13399	13643	11784
Арилжааны банкны	-3335	-916	-1085	-1602	-1661	-1910	-2648	-2826	-2648	-2656	-2754	-2772
Дотоод цэвэр актив	18987	18864	24057	28833	28652	27625	31603	31704	34771	36850	46921	56833
Дотоодын цэвэр зээл	18825	19333	24203	26276	29106	28477	32296	32651	34873	37137	47209	56867
ЗГ-ын цэвэр зээл	-2488	-1524	-471	-1631	-4323	-6133	-6536	-6462	-5121	-4022	-2741	-1032
Төв банк	-1229	-1114	-738	-1775	-3842	-5621	-6460	-6297	-5480	-5381	-6400	-7174
Арилжааны банкууд	-1258	-411	267	143	-480	-511	-75	-165	359	1359	3659	6142
ЗГ-аас авах авлага	1480	1690	1734	1675	1558	1514	2126	2106	2561	3561	5861	8344
ЗГ-ын хадгаламж	2738	2100	1467	1511	-2038	-2025	-2202	-2271	-2202	-2202	-2202	-2202
Банк бусаас авах авлага	21313	20857	24674	27908	33428	34610	38832	39113	39994	41158	49950	57898
Зээл+ИЗББ	20979	19975	23530	25675	31447	33112	37327	37617	38792	39955	48747	56696
Үүнээс зээл	18096	17207	20876	22242	27374	29139	33486	33474	34648	35232	43324	50672
Хэрэглээний зээл	5143	4196	5214	5952	8410	9350	10369	10589	11017	11354	14737	17803
Ипотекийн зээл	1746	1979	2653	3055	3571	3945	4719	4579	4900	4755	5846	6824
Бизнесийн зээл	11208	11032	13009	13235	15393	15845	18399	18306	18732	19123	22740	26045
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	3685	4099	4510	5761	6054	5470	5346	5639	5346	5926	6626	7226
<b>Төв банк</b>												
Нөөц мөнгө	5172	4516	4808	6727	7227	6097	7584	6085	8220	8627	9666	10310
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	897	991	1106	1089	1152	1091	1338	1255	1360	1417	1724	1966
Арилжааны банкуудын харилцах, хадгаламж	4275	3525	3702	5638	6075	5006	6246	4831	6860	7210	7942	8344
Гадаад цэвэр актив	6913	7117	5509	4732	11140	12172	12956	12582	13533	13372	13614	11757
Дотоод цэвэр актив	-10	-1757	-84	1994	-3913	-6075	-5372	-6497	-5313	-4745	-3949	-1449
<b>Меморандум үзүүлэлтүүд:</b>												
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	7.0	17.5	13.8	6.5	26.8	20.9	31.9	30.4	36.2	25.3	21.7	14.0
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	5.4	-12.7	6.5	39.9	7.4	11.7	29.6	1.3	31.0	19.4	12.0	6.7
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	4.03	5.42	5.80	4.41	5.21	6.13	5.47	6.86	5.50	5.47	5.94	6.35
Зээл+ИЗББ жилийн өөрчлөлт (%)	4.5	-4.0	19.5	7.5	22.5	22.1	27.1	29.2	29.4	27.1	22.0	16.3
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	5.0	-4.0	21.3	6.5	23.1	25.4	30.9	31.9	32.8	28.7	23.0	17.0
Хэрэглээний зээлийн жилийн өөрчлөлт (%)	-7.7	-20.8	13.9	14.2	41.3	35.7	38.3	39.0	35.0	35.0	29.8	20.8
Бизнесийн зээлийн жилийн өөрчлөлт (%)	11.1	2.3	22.2	1.7	16.4	16.8	23.0	25.6	27.5	24.2	19.0	0.0
Зээл/ДНБ	0.57	0.54	0.55	0.48	0.46	0.46	0.49		0.50	0.50	0.53	0.56
Мөнгөний эргэлтийн хурд	1.77	1.53	1.56	1.82	1.83	1.91	1.85		1.71	1.69	1.60	1.54
Банкуудын ТБ дахь нөөц/Нэрлэсэн ДНБ	11.6	9.6	8.6	10.7	9.0	7.0			8.8	9.1	8.6	8.3
Нэрлэсэн ДНБ /их наяд төгрөг/	37.8	37.5	43.6	53.9	68.9	71.5	76.9		77.5	79.6	91.9	100.9
Нэрлэсэн ДНБ-ий жилийн өсөлт (%)	16.1	-1.0	16.3	23.6	27.9	23.5	26.0		20.3	15.6	15.4	9.8

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол


### 5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр

Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-246 дугаар тушаалаар “Банканд ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зээл олгох түр журам”-ыг баталсан. Журмын хүрээнд хөтөлбөрт оролцогч талууд болох МИК ОССК ХХК болон банкнуудтай 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдөр “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г шинэчлэн байгуулж хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанк өөрийн эзэмшлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын эргэн төлөлтөөр хэвийн үргэлжлүүлж байна.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр нийт 8.6 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 127.1 мянган зээлдэгчид олгоод байна. Үүнээс “Эрүүл

мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 2.7 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 30.4 мянган өрхөд олгожээ (Зураг 35).

Зураг 35. Ипотекийн зээл олголт



Эх сурвалж: Монголбанк


УИХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийг баталж, 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн Засгийн газрын хурлаар “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тус тогтоолд хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт Монголбанкаар дамжуулан хөрөнгө оруулахаар заасан байна. Тогтоолын хүрээнд Сангийн яам, Монголбанк хооронд “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г байгуулж, Хуримтлалын сангийн эх үүсвэрээр орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулан ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онуудад олгосон нийт зээлийн дүнгийн дунджаар 17 хувийг, нийт олгосон зээлийн тоогоор дунджаар 25 хувийг орон нутагт олгосон бол 2023 онд 932.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлийг 8.9 мянган өрхөд олгосноос 32 хувийг буюу 302.6 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 3.7 мянган өрхөд олгосон. Харин 2024 онд хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах ажлын хүрээнд орон нутагт олгох хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд хоёрдугаар улирлын эцсийн байдлаар олгосон нийт зээлийн 44 хувийг буюу 331.3 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 3.3 мянган өрх (нийт олгосон зээлийн өрхийн тооны 50 хувь)-д олгожээ.


### 5.3. Мөнгөний зах, хүүний түвшин

Банкнүүдын зээл олгох, хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ.

Зураг 36. Банк хоорондын захын хүү




Зураг 37. Банк хоорондын захын хүүний бодлогын хүүнээс хазайх хазайлт




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны МБХ-ны 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрээр бодлогын хүүг 1 нэгж хувиар, 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрээр дахин 1 нэгж хувиар бууруулж 11 хувьд хүргэсэн бөгөөд тус өөрчлөлтөөс шалтгаалан банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 2 дугаар улирлын эцэст 11.6 нэгж хувь болов (Зураг 36). Түүнчлэн оны эхнээс тайлант улирлын эцэс хүртэл хийгдсэн банк хоорондын арилжааны 66.9 хувь нь бодлогын хүү дээр хийгдсэн бол 18.5 хувь бодлогын хүүнээс 0 хувиас 0.05 хувийн интервалд харьяалагдаж байгаа нь банк хоорондын захын хүү бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалагдсаныг харуулж байна (Зураг 37).

Зураг 38. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны хэмжээ (Тэрбум ₮)



Зураг 39. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны дундаж хугацаа (Хоногор)



Эх сурвалж: Монголбанк

2024 оны II улиралд банк хоорондын төгрөгийн захад нийт 5,875.9 тэрбум төгрөгийн дүн бүхий 207 хэлцлийг 11.6 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, 10.7 хоногийн дундаж хугацаатайгаар байгуулжээ (Зураг 38, Зураг 39). Банк хоорондын төгрөгийн захад хийгдсэн нийт хэлцлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 72.2 хувиар буюу 2,462.9 тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 8.4 хувиар буюу 453.6 тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. 2024 онд инфляц буурч, зорилтын интервалд тогтворжихоор байгаа тул (Инфляцын тайлан 2024 оны 6 дугаар сар) санхүүжилтийн нөхцөлийг сулруулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулснаар оны эхнээс төгрөгийн нөөц нэмэгдэж, урсгал сайжирч ханш тогтворжсонтой холбоотой банк хоорондын захын идэвхжилийг нэмэгдүүллээ.

*Хүснэгт 9. Хоёрдогч захын төгрөгийн арилжаанд эзлэх хэмжээ (Хувиар)*

Үзүүлэлт	2023				2024	
	I	II	III	IV	I	II
Репо (ТБҮЦ)	28%	32%	32%	36%	38%	33%
Шууд (ТБҮЦ)	49%	28%	41%	37%	48%	53%
Овернайт	3%	2%	9%	6%	5%	10%
Банк хоорондын хадгаламж	20%	39%	19%	21%	9%	4%

*Эх сурвалж: Монголбанк*


Арилжааны бүтцийг авч үзвэл нийт банк хоорондын арилжаанд ТБҮЦ-ыг барьцаалан хийж байгаа репо хэлцэл 33%, ТБҮЦ-ны шууд хэлцэл 53%, овернайт хэлцэл 10%, банк хоорондын хадгаламж 4%-ийг тус тус бүрдүүлж байна. Банк хоорондын ТБҮЦ-ны шууд болон репо хэлцэл нь харилцагчийн эрсдэл багатай тул нийт арилжаанд давамгайлж байгаа бөгөөд 2024 оны 2 дугаар улиралд банк хоорондын овернайт арилжаа идэвхжлээ (Хүснэгт 9).

**5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханиш**

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш энэ оны I улиралд өмнөх улирлаас 1.35 хувиар, II улиралд өмнөх улирлаас 0.38 хувиар, оны эхнээс 0.87 хувиар тус тус чангарч, 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 3381.05 төгрөгт хүрэв. Ингэхдээ, 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.11 хувиар чангарч, 0.04 хувиар суларч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.01%-д хүрч, өмнөх оны мөн үеэс 0.03 нэгжээр буурлаа.



Зураг 40. Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж



Зураг 41. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

2023 оны төгсгөлд 1 тонн зэсийн үнэ 8,559.0 ам.доллар байсан бол 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 9,599.0 ам.доллар болж 12 хувиар өссөн байна. Харин нүүрсний үнэ 2023 оны төгсгөлд тонн тутамд 132.42 ам.доллар байсан бол 2024 оны 6 дугаар сарын байдлаар 119.57 ам.доллар болж буурлаа. Улмаар банкны системээр дамжин Монгол улсад орох гадаад валютын орох урсгал 2024 оны эхний 6 сарын байдлаар гарах урсгалаас 1,338.3 сая ам.доллаароор өндөр байв.

Улмаар Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2024 оны 6 дугаар сарын байдлаар 53.3 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц оны эхнээс 23.3 сая ам.доллаароор өссөн байна.

Мөн Монголбанкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь дотоодын зах зээлээс худалдаж авдаг алт байдаг. Монголбанк 2023 онд 17.3 тонн үнэт металл худалдан авсан бол 2024 оны эхний хагаст нийт 7.7 тонн үнэт металл худалдан аваад байна. Ингэснээр гадаад валютын албан нөөц нэмэгдэж улмаар олон нийтийн төгрөгт итгэх итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд эергээр нөлөөлөх болон эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримталж ажилладаг бөгөөд богино хугацааны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцон ажилладаг. Тус зорилгынхоо хүрээнд Монголбанк 2024 оны 6 дугаар сарын байдлаар нийт 3,104.4 сая ам.долларыг худалдан авч, гадаад валютын дуудлага худалдаа болон цахим талбараар нийт 2,866.4 сая ам.долларыг дотоодын валютын захад нийлүүлсэн. Ингэснээр Монголбанк цэвэр дүнгээр 238.0 сая ам.долларыг валютын захаас татжээ.

## VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗЭЭЛ

### 6.1. Төлбөрийн тэнцэл


Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2024 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 282 хувиар өсөж 609 сая ам.долларт, санхүүгийн дансны ашиг 16 дахин өсөж 744 сая ам.долларт тус тус хүрч, нийт тэнцлийн ашиг өмнөх оноос 589 сая ам.доллаар буурч 136 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

*Хүснэгт 10. Төлбөрийн тэнцлийн 2024 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэл, сая ам.доллар*


	Эхний 7 сар		Өөрчлөлт	
	2023	2024	Дүн	Хувь
<b>I. Урсгал данс</b>	<b>334</b>	<b>-609</b>	<b>-943</b>	<b>-282%</b>
1.1 Бараа ба үйлчилгээний худалдаа	1,292	640	-651	-50%
сА. Бараа	2,783	2,122	-661	-24%
Б. Үйлчилгээ	-1,491	-1,482	9	-1%
1.2 Анхдагч орлого	-1,154	-1,521	-366	32%
1.3 Хоёрдогч орлого	196	271	75	38%
<b>II. Хөрөнгийн данс</b>	<b>67</b>	<b>90</b>	<b>24</b>	<b>36%</b>
<u>Урсгал ба Хөрөнгийн дансны тэнцэл</u>				
<u>(зээлдүүлэг + / зээллэг -)</u>	400	-519	-919	-230%
<b>III. Санхүүгийн данс</b>	<b>46</b>	<b>-744</b>	<b>-790</b>	<b>-16x</b>
<u>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)</u>	46	-744	-790	-16x
А. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	-1,050	-1,648	-597	57%
а.1. Актив	26	36	10	38%
а.2. Пассив	1,076	1,683	607	56%
Б. Багцын хөрөнгө оруулалт	268	-211	-479	-179%
б.1. Актив	34	-1	-35	-104%
б.2. Пассив	-234	210	444	-190%
В. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	-2	-9	-7	442%
в.1. Актив	-2	0	2	-107%
в.2. Пассив	0	9	9	X
Г. Бусад хөрөнгө оруулалт	830	1,124	293	35%
г.1. Актив	443	398	-45	-10%
г.2. Пассив	-387	-725	-338	87%
<b>III. Алдаа ба орхигдуулаг</b>	<b>98</b>	<b>-362</b>	<b>-460</b>	<b>-468%</b>
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	452	-136	-589	-130%
<b>IV. Албан нөөцийн өөрчлөлт</b>	<b>452</b>	<b>-136</b>	<b>-589</b>	<b>-130%</b>

Эх сурвалж: Монголбанк

Зураг 42. Төлбөрийн тэнцэл



Зураг 43. Урсгал ба хөрөнгийн тэнцэл




Эх сурвалж: Монголбанк

**Урсгал ба хөрөнгийн данс**

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2024 оны эхний 7 сард өнгөрсөн оны мөн үеэс 919 сая ам.доллараар буурч 519 сая ам.долларын алдагдалтай гарсан. Үүнд барааны дансны ашиг 661 сая ам.доллараар буурч, анхдагч орлогын дансны алдагдал 366 сая ам.доллараар өссөн нь голлох нөлөөг үзүүлэв.

Урсгал дансны алдагдал нь дотоодын эдийн засгийн сэргэлт, уул уурхайн бүтээн байгуулалтууд болон импортын өсөлтөөс шалтгаалж 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байсан. Тэгвэл 2014 оноос барааны гадаад худалдаа ашигтай гарч эхэлснээр алдагдал буурч 2015 онд ДНБ-ий 8 хувь, 2016 онд 6 хувьд хүрсэн. Тэгвэл импортын өсөлттэй холбоотойгоор 2018 онд барааны дансны ашиг буурснаар, дээрх үзүүлэлт 33 хувьд хүрч өссөн бол 2020 онд импорт буурснаар 10 хувьд тус тус хүрсэн. 2023 онд уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр урсгал дансны ашиг ДНБ-ий 1 хувьд хүрэв.

Зураг 44. Урсгал тэнцэл/Нэрлэсэн ДНБ




Эх сурвалж: Монголбанк, УСХ

**Гадаад худалдаа тэлж байна.** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,955 сая ам.доллараар өсөж 15,677 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 7%-аар буюу 567 сая ам.доллараар, импорт 28%-аар буюу 1,387 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд гадаад худалдааны ашиг 2,855 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 820 сая ам.доллараар буурлаа.

Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ өмнөх оны мөн үеэс буурсан ч 2024 оны эхний 7 сард зэс, төмрийн хүдэр, жонш, чулуун нүүрсний экспортын биет хэмжээ өссөн нь экспортын өсөлтөд голлон нөлөөлөв. Тодруулбал, биет хэмжээгээр чулуун нүүрс 1,406 сая ам.доллаар, зэсийн хүдэр, баяжмал 68 сая ам.доллаар, төмрийн хүдрийн баяжмал 91 сая ам.доллаар, жонш 44 сая ам.доллаар тус тус нэмэгдэв.

Импорт өмнөх оны мөн үеэс 1,387 сая *Зураг 45. Барааны гадаад худалдаа*

ам.доллар буюу 28%-иар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүн 391 сая ам.доллаар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 725 сая ам.доллаар, нефтийн бүтээгдэхүүний импорт 194 сая ам.доллаар тус тус өссөн нь нөлөөлсөн. Нефтийн бүтээгдэхүүний хувьд дизель түлшний импорт 23%-иар буюу 144 сая ам.доллаар, АИ-92 болон АИ-95 бензиний импорт 22%-иар буюу 64 сая ам.доллаар өссөн.




Эх сурвалж: Монголбанк

**Үйлчилгээний дансны алдагдал буурав.** *Зураг 46. Үйлчилгээний гадаад худалдаа*

Үйлчилгээний дансны алдагдал 2024 оны эхний 7 дугаар сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 1 хувиар буюу 9 сая ам.доллаар буурч 1,482 сая ам.долларт хүрсэн.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний дансны алдагдалд тээврийн үйлчилгээний зардал 227.1 сая ам.доллаар буурч, аялал жуучлалын зардал 182.1 сая ам.доллаар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.



Эх сурвалж: Монголбанк

**Анхдагч орлогын дансны алдагдал өссөн.** Анхдагч орлогын дансны алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32 хувиар буюу 366 сая ам.доллаар өсөж 1,521 сая ам.долларт хүрсэн нь хөрөнгө оруулалтын зардлын өсөлттэй холбоотой байна.


### Санхүүгийн данс

Санхүүгийн дансны ашиг 2024 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 16 дахин өсөж 744 сая ам.долларт хүрчээ. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт 597 сая ам.доллаар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Зураг 47. Санхүүгийн данс



Зураг 48. Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монголбанк

**Гадаад валютын албан нөөц.** Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 7 сарын байдлаар 136 сая ам.долларын алдагдалтай гарснаар гадаад валютын албан нөөц 7 дугаар сарын эцэст 4,737.1 сая ам.доллар байна.

### 6.2. Хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны 2 дугаар улирлын эцэст -41,629.4 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 41,629 сая ам.доллаароор өндөр байна. Гадаад хөрөнгө оруулалтын актив, пассивийн үлдэгдэл болон позицийг Хүснэгт 11-т дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 11. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2024 оны 2-р улирал, сая ам.доллар

А. ГАДААД АКТИВ	8,966.6	Б. ГАДААД ПАССИВ	50,596.0
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>	<b>1,047.7</b>	<b>6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	<b>31,786.9</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	771.5	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	15,513.9
1.2 Бусад хөрөнгө	276.3	6.2 Бусад хөрөнгө	16,272.9
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>480</b>	<b>7. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>2,671</b>
2.1 Хөрөнгийн хувьцаа	393.3	7.1 Хөрөнгийн хувьцаа	212
2.2 Өрийн бичиг	86.4	7.2 Өрийн бичиг	2,459.1
<b>3. Санхүүгийн дериватив</b>	<b>2.3</b>	<b>8. Санхүүгийн дериватив</b>	<b>2.8</b>
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>2,598.1</b>	<b>9. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>16,135.2</b>
4.1 Худалдааны зээл	365.3	9.1 Худалдааны зээл	1,520.3
4.2 Зээл	168.8	9.2 Зээл	13,527.3
4.2.1 Төв банк	0	9.2.1 Төв банк	131.3
4.2.2 Засгийн газар	0	9.2.2 Засгийн газар	6,096.2

4.2.3 Банк санхүүгийн байгууллага	96.5	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	1,425.4
4.2.4 Аж ахуйн нэгж	72.3	9.2.4 Аж ахуйн нэгж	5,874.5
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	2,064	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	932.5
4.4 Бусад актив	0	9.4 Бусад пассив	155.2
<b>5. Нооц актив</b>	<b>4,838.8</b>	<b>В. ПОЗИЦ</b>	<b>-41,629.4</b>
5.1 Мөнгөжсөн алт	589.6	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-30,739.1
5.2 Зээлжих тусгай эрх	96.4	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-2,191.4
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	7.1	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	-0.5
5.4 Бэлэн валют ба харилцах	1,530.8	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-13,537.2
5.5 Үнэт цаас	2,614.8	14. Нооц актив	4,838.8
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0		
5.7 Бусад нооц актив	0		

Эх сурвалж: Монголбанк

**Гадаад актив.** Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 8,966.6 сая ам.доллар байна. Үүний 54%-ийг гадаад валютын албан нөөц, 29%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

**Гадаад пассив.** Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 50,596.0 сая ам.долларт хүрэв. Үүний 63%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 32%-ийг бусад хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлжээ.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 49%-ийг буюу 15,513.9 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 51% буюу 16,272.9 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (*компани хоорондын өглөг, санхүүжилт*) байна.

### 6.3. Монгол Улсын гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2024 оны 2 дугаар улирлын эцэст 34,867.3 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн үлдэгдлээс 5%-иар буюу 1,799.5 сая ам.доллаар нэмэгдсэн. Энэхүү өсөлтийг банкуудын урт хугацаат зээл болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн өсөлт тайлбарлаж байна.

## Хүснэгт 12. Гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллар

Үзүүлэлт	6/30/2023	6/30/2024	ҮеҮ, %	Нийтэд эзлэх %
<b>Нийт гадаад өр</b>	<b>33,067.8</b>	<b>34,867.3</b>	<b>5.4%</b>	<b>100%</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>7,632.6</b>	<b>7,607.1</b>	<b>-0.3%</b>	<b>22%</b>
<b>II. Төв банк</b>	<b>1,980.5</b>	<b>1,111.9</b>	<b>-43.9%</b>	<b>3%</b>
<b>III. Банк</b>	<b>1,702.3</b>	<b>1,842.1</b>	<b>8.2%</b>	<b>5%</b>
Богино хугацаат	178.4	169.2	-5.2%	
Урт хугацаат	1,523.8	1,673.0	9.8%	
<b>IV. Бусад сектор</b>	<b>7,899.5</b>	<b>8,033.3</b>	<b>1.7%</b>	<b>23%</b>
Богино хугацаат	963.3	1,719.7	78.5%	
Урт хугацаат	6,936.1	6,313.6	-9.0%	
<b>V. Хөрөнгө оруулагч зээл</b>	<b>13,852.9</b>	<b>16,272.9</b>	<b>17.5%</b>	<b>47%</b>

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын гадаад өр 25.5 сая ам.доллаароор буурч 7,607.1 сая ам.долларт, Төв банкны гадаад өр 868.7 сая ам.доллаароор буурч 1,111.9 сая ам.долларт хүрлээ.

Засгийн газрын гадаад өрийн бууралтад олон улсын зах зээлд арилжаалсан бондын эргэн төлөлт болон үнийн өөрчлөлт нөлөөлсөн. Харин Төв банкны гадаад өрийн бууралт нь ОУВС-гийн зээлийн эргэн төлөлт, Хятадын Ардын банктай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээл өнгөрсөн оны мөн үеэс 2,693.7 сая ам.доллаароор нэмэгдэж 26,148.4 сая ам.доллар боллоо.

**Банкны салбарын гадаад өр.** Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар улирлын эцэст 1,842.1 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 139.8 сая ам.доллаароор өсжээ. Гадаад өрийн 74 хувийг урт хугацаат зээл, 17 хувийг бонд өрийн бичиг, 6 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг, үлдсэн 3 хувийг богино хугацаат зээл тус тус бүрдүүлж байна.

**Бусад (банкны бус) салбарын гадаад өр.** Аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр 2024 оны 2 дугаар улирлын эцэст өнгөрсөн оны мөн үеийн үлдэгдлээс 2,553.9 сая ам.доллаароор нэмэгдэж 24,306.2 сая ам.долларт хүрэв. Үүний 67 хувь буюу 16,272.9 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгжүүдийн гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаатай, ихэнх тохиолдолд хүүгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдаг.

## VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

### 7.1. Санхүүгийн салбар

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын санхүүгийн системд нийт 12 банк, 531 банк бус санхүүгийн байгууллага, 184 хадгаламж зээлийн хоршоо, 19 даатгалын компани, 63 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 24 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна. Манай санхүүгийн систем нь банкны салбар давамгайлсан бүтэцтэй боловч банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд өргөжин тэлж байна. Тодруулбал, 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүгийн системийн нийт актив хөрөнгийн 9.8 хувь, нийт ашгийн 28.9 хувь, нийт өөрийн хөрөнгийн 33.3 хувь нь тус тус банкнаас бусад санхүүгийн салбарт хамаарч байна (Хүснэгт 13).

#### Хүснэгт 13. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	Банк	ББСБ	ХЗХ	Даатгал
<b>2024 оны I улирал</b>				
Нийт хөрөнгө	54,981.8	5,062.1	316.2	582.3
Өр төлбөр	48,515.2	2,144.5	244.9	339.3
Өөрийн хөрөнгө	6,466.6	2,917.6	71.3	243.0
Зээлийн өрийн үлдэгдэл	28,923.7	4,249.5	220.3	-
Чанаргүй зээл	2,051.5	282.0	6.9	-
Тайлант үеийн ашиг	384.9	145.9	1.9	8.4
Даатгалын хураамжийн орлого				110.0
Даатгалын нөхөн төлбөр				36.2
<b>2023 он</b>				
Нийт хөрөнгө	57,069.7	4,672.2	306.5	551.4
Өр төлбөр	50,887.4	1,926.9	237.0	325.6
Өөрийн хөрөнгө	6,182.3	2,745.3	69.5	225.8
Зээлийн өрийн үлдэгдэл	27,151.6	3,675.9	209.1	-
Чанаргүй зээл	2,039.3	259.1	6.7	-
Тайлант үеийн ашиг	1,273.8	432.1	3.8	11.8
Даатгалын хураамжийн орлого				398.7
Даатгалын нөхөн төлбөр				126.7


Эх сурвалж: Монголбанк, СЗХ

Сүүлийн 2 жил орчмын хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт огцом нэмэгдсэнээр эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсний зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний нөлөөгөөр санхүүгийн системийн эрсдэл 2023 оны туршид буурч, эрсдэлийн нэгдсэн индексийн<sup>34</sup> утга харьцангуй бага түвшинд хүрээд байна (Зураг 49 болон Зураг 50).


<sup>34</sup> Эрсдэлийн индексийн талаар Г.Амартүвшин, О.Энхбаатар болон Э.Урангоо, (2022). “Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал” судалгааны ажлаас дэлгэрүүлэн харна уу.



Зураг 49. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс



Зураг 50. Системийн эрсдэлийн зураглал (heatmap)




Эх сурвалж: Монголбанк

## 7.2. Банк бус санхүүгийн салбар


### 7.2.1 Банк бус санхүүгийн байгууллагын салбар

Энэ оны эхний улирлын байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөрөл бүхий 531 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд давхардсан тоогоор үүний 88.9 хувь нь зээл, 31.5 хувь нь гадаад валютын арилжаа, 7.0 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, 8.9 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 11.5 хувь нь факторингийн үйлчилгээ, 5.5 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 15.1 хувь нь итгэлцлийн үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна. Салбарын голлох үзүүлэлтүүдийг авч үзвэл нийт хөрөнгийн хэмжээ 5.1 их наяд төгрөгт, зээлийн хувь хэмжээ 4.2 их наяд төгрөгт, өр төлбөр 2.2 их наяд төгрөгт, эздийн өмч 2.9 их наяд төгрөгт, тайлант үеийн ашиг 145.9 тэрбум төгрөгт тус тус хүрч өмнөх оны мөн үеэс харгалзан 36.7 хувь, 48.4 хувь, 54.8 хувь, 26.0 хувь болон 46.5 хувиар нэмэгджээ (Хүснэгт 11, Зураг 51 болон Зураг 54).

Зураг 51. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээлийн дүн /тэрбум төгрөг/ ба өсөлт



Зураг 52. ББСБ-ын өр төлбөрийн задаргаа, жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: СЗХ


ББСБ-уудын өр төлбөрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өсөж 2024 оны эхний улирлын байдлаар 2.2 их наяд төгрөгт хүрээд байна. ББСБ-аас гаргасан өрийн бичиг, дотоодын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өсөлт нь нийт өр төлбөр ийнхүү огцом өсөхөд голлон нөлөөлөв (Зураг 52).

ББСБ-ын нийт зээлийн үлдэгдлийн 89.4 хувийг буюу 3.6 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.7 хувийг буюу 151.8 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.9 хувийг буюу 282.0 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүлж байна. Энэ оны эхний улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7 нэгж хувь болон 1.0 нэгж хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Зураг 53. Зээлийн жигнэсэн дундаж хүү / сарын/ ба зээлийн чанар



Зураг 54. ББСБ-ын орлого, зарлага болон ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

### 7.2.2 Үнэт цаасны салбар

Санхүүгийн зохицуулагч байгууллагаас Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хөрөнгийн зах зээлийн идэвхжил, үнэлгээ нэмэгдлээ.


Энэ оны эхний улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 80.7 хувиар өсөж, 11.8 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий<sup>35</sup> 17.1 хувьтай тэнцэж байна. Тайлант улиралд нийт 204.9 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт арилжааны 188.9 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 16.0 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна. Түүнчлэн, Монгол Улсын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн утга 2024 оны 1 дүгээр улиралд дунджаар 43046.2 нэгжид хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.0 хувиар өслөө (Зураг 55).

<sup>35</sup> 2023 оны нэрлэсэн ДНБ

Зураг 55. Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн өөрчлөлт



Зураг 56. Даатгалын салбарын нийт хөрөнгө ба нөөц сан /тэрбум төгрөг/ ба өсөлт



Эх сурвалж: СЗХ

### 7.2.3 Даатгалын салбар


Тайлант улирлын байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй 19 даатгалын компани, 63 даатгалын зуучлагч, 2462 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 582.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар өссөн бол нөөц сангийн нийт дүн 273.4 тэрбум төгрөгт хүрэв (Зураг 56). Даатгалын нийт хураамж 110.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 44.4 хувиар өссөн бөгөөд нийт даатгалын хураамжийн 97.2 хувийг ердийн даатгал, 0.8 хувийг урт хугацааны даатгал, 2.0 хувийг давхар даатгалын хураамж тус тус бүрдүүлжээ.

Харин даатгалын нийт нөхөн төлбөр 36.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар өсөв. Тус хугацаанд хохирлын харьцаа (нөхөн төлбөрийн зардал, орлогод тооцсон хураамжийн харьцаа) ердийн даатгалын компаниудын хувьд 54.5 хувь, урт хугацааны даатгалын компаниудын хувьд 60.3 хувь байгаа бол хосолсон харьцаа ердийн даатгалын хувьд 111.1 хувьтай байна. Энэ нь даатгалын компаниудын удирдлага, үйл ажиллагааны зардал харьцангуй өндөр байгааг харуулж байна. Салбарын нийт цэвэр ашиг 2024 оны эхний улиралд 8.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 125.0 хувиар өслөө.


### 7.2.4 Хадгаламж, зээлийн хоршооны салбар

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй 184 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) үйл ажиллагаа явуулж байна. Тус салбарын голлох үзүүлэлтүүдийг авч үзвэл нийт хөрөнгө 316.2 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 220.3 тэрбум төгрөг, нийт хадгаламж 219.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс харгалзан 15.2 хувь, 3.7 хувь болон 14.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна (Зураг 57 болон Зураг 58). Тайлант улиралд ХЗХ-дын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өсөж 1.9 тэрбум төгрөгт хүрчээ. Түүнчлэн, нийт зээлийн үлдэгдлийн 93.1 хувь буюу 205.1 тэрбум төгрөг нь хэвийн, 3.8 хувь буюу 8.3 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн, 3.1 хувь буюу 6.9 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүллээ.

Зураг 57. ХЗХ-ын нийт хадгаламж ба ашигийн дүн /тэрбум төгрөг/



Зураг 58. ХЗХ-ын салбарын нийт хөрөнгө, зээлийн дүн /тэрбум төгрөг/ ба өсөлт



Эх сурвалж: СЗХ

### 7.2.5 Банкны бус санхүүгийн салбарт тулгамдаж буй эрсдэл

ББСБ-уудаас олгосон иргэдийн хэрэглээний зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдэж байна. Энэ оны эхний улирлын байдлаар ББСБ-ын хэрэглээний зээлийн үлдэгдэл 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 44.7 хувиар, 2018 онтой харьцуулахад 5.8 дахин нэмэгджээ. Үүнд, СЗХ-ны шийдвэрээр ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2018-2021 онуудад үе шаттайгаар нэмэгдүүлснээс гадна ББСБ-уудын өр төлбөр (үүн дотроо итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад өгөх өглөг)-ийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өсөж, улмаар ББСБ-уудын санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-ын хэрэглээний зээлийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн талын голлох хүчин зүйлс болж байна. Нөгөө талаас гар утасны программ, техник, технологийн дэвшлийн нөлөөгөөр зээлдэгчид ББСБ-аас зээл авахад илүү хялбар болсны зэрэгцээ Монголбанкнаас банкны салбарт мөрдүүлж буй хэрэглээний зээлийн хязгаарлалтын улмаас ББСБ-руу чиглэсэн иргэдийн хэрэглээний зээлийн эрэлтийг нэмэгдүүлж байна.

СЗХ-ноос финтек зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, иргэд, өрхүүдийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор ББСБ-ын финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоосон бөгөөд тус зохицуулалт нь 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь ББСБ-аас иргэдэд олгох хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлахад нөлөөлөл багатай байна. Тухайлбал, тайлант улиралд финтек зээлийн үйлчилгээ үзүүлж буй 50 ББСБ-ууд зөвхөн 1.5 сая зээлдэгчийн 834.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь ББСБ-ын нийт зээлдэгчийн 84.2 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 20.5 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн финтек зээлийн хувьд нэг зээлдэгчид дунджаар 550.4 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь ББСБ-ын уламжлалт зээлийн дунджаас 20.7 дахин бага юм.


Ийнхүү ББСБ-ын хэрэглээний зээлийн хэмжээ огцом нэмэгдэх нь өрхийн бодит өрийн дарамтыг нэмэгдүүлэх, тухайн салбарт төдийгүй банкны салбарт зээлийн эрсдэл хуримтлагдах, Монголбанкнаас хэрэгжүүлж буй иргэдийн хэрэглээний зээлийн

